

LAW ENFORCEMENT UNIVERSITY
OF MONGOLIA



LAW ENFORCEMENT

THEORETICAL AND METHODOLOGICAL
QUARTERLY JOURNAL

2018
№03 (17)

Ulaanbaatar, Mongolia

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга:

Энхтөр Ө. Хууль сахиулахын их сургуулийн захирал, профессор, цагдаагийн хурандаа

Зөвлөлийн орлогч дарга:

Бат-Эрдэнэ Б. ХСИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

Гишүүд:

Амарсанаа Ж. Академич

Амгаланбаяр Ц. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хууль зүйн доктор, бригадын генерал

Баатаржав С. Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа

Бадрал Т. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал

Батжаргал Д. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал

Бернд Шюнеманн ХБНГУ-ын Людвиг Максимилианы нэрэмжит Мюнхений их сургуулийн Өмгөөллийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, профессор, доктор h.c.mult

Болд Л. Шинжлэх Ухааны Академийн хэл зохиолын хүрээлэнгийн захирал, Академич

Болдбаатар Б. ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

Ганбаатар Г. ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Гантөмөр Г. Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Жавхланцогт В. ХСИС-ийн Хилийн сургуулийн захирал, цэргийн ухааны доктор, дэд профессор, хурандаа

Жигалов Н.Ю. ОХУ-ын Дотоод явдлын яамны Дорнод Сибирийн их сургуулийн дэд захирал, хууль зүйн доктор, профессор

Ил Сү Ким БНСУ-ын Криминологийн институтын ерөнхийлөгч, хууль зүйн доктор, профессор

Лхагвасүрэн Б. Шинжлэн магадлахуйн институтын захирал, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа

Мөнхболд Ж. ХСИС-ийн Ахисан шатны боловсролын сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Нарангэрэл С. Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич

Сэргэлэн Ц. Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал

Чулуунбаатар Г. Академич

Эрдэнэбаатар Д. ХСИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

JOURNAL BOARD

Chief of the Board:

EnkhTUR U. President of Law Enforcement University, police colonel

Deputy Chief of the Board:

Bat-Erdene B. First Vice President of Law Enforcement University, Ph.D, Professor, police colonel

Members:

Amarsanaa J. Academician

Amgalanbayar Ts. Chief of Court Decision Execution Agency, Ph.D in Law, Brigadier General

Baatarjav S. Chief of National Police Agency, Police Colonel

Badral T. Chief of National Emergency Management Agency, Major General

Batjargal D. Chief of National Institute of Forensic Science, Brigadier General

Bernd Schuenemann Prof.Dr.Dr.h.c.mult. Professor Emeritus at the University of Munich, Executive Director of the Institute for Lawyers' Law at the University

Bold L. Director of Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences, Academician

Boldbaatar B. Director of Police Institute, Law Enforcement University, Ph.D in Law, Professor, Police Colonel

Ganbaatar G. Director of Non-Commissioned school, Law Enforcement University, Ph.D in Law, Police Colonel

Gantumur G. Scientific Secretary of Law Enforcement University, Ph.D in Law, Associate Professor, Police Colonel

Javkhantsogt V. Director of Border Institute, Law Enforcement University, Ph.D in Military Science, Associate Professor, Colonel

Jigalov N.Yu. Deputy Director of Eastern-Siberian Institute of Ministry of Internal Affairs, Russia, Ph.D in Law, Professor

Il Sou Kim President of Korean Institute of Criminology, Ph.D in Law, Professor

Lkhagvasuren B. Director of Forensic Science Institute, Ph.D in Law, Police lieutenant colonel

Munkhbold J. Director of Graduate school, Law Enforcement University, Ph.D in Law, Associate Professor, Police Lieutenant Colonel

Narangerel S. Honored Science Worker of Mongolia, Academician

Sergelen Ts. Chief of the Border Protection Authority, Border Troops Commander, Major General

Chuluunbaatar G. Academician

Erdenebaatar D. Vice President of Law Enforcement University, Ph.D in Law, Police Colonel

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:

Бат-Эрдэнэ Б. Эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Эрдэнэбаяр М. Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Нарийн бичгийн дарга:

Мөнхдорж Б. Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн хошууч

Гишүүд:

Алтангэрэл Б. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, хурандаа

Ариунбилэг Ш. Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Батсайхан Н. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрхлэгч, биологийн ухааны доктор, дэд профессор, хошууч

Ганбадрал Н. Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Гантулга С. Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн дэд профессор, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хошууч

Даваа Б. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрхлэгч, биологийн ухааны доктор, цагдаагийн дэд хурандаа

Муратхан Т. Хэвлэл, редакцийн албаны ахлах редактор, цэргийн ухааны доктор, профессор, хурандаа

Мягмарцэрэн Д. Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Нармандах С. Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Гадаад хэлний тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа

Нямсүрэн Ч. Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Одбаатар Б. Хууль сахиулахын удирдлагын академийн Цагдаагийн стратеги, удирдлагын профессорын багийн профессор, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Өвгөнбүргэд Ж. Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Хил судлалын төвийн эрхлэгч, цэргийн ухааны доктор, дэд профессор, хурандаа

Цолмон Б. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа

Энхболд Б. Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч

Энхжаргал Д. Ахисан шатын боловсролын сургуулийн Гадаад хэлний сургалтын багийн ахлагч, хэл шинжлэлийн ухааны доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

JOURNAL EDITORIAL BOARD

Editor of the journal:

Bat-Erdene B. First Vice President of Law Enforcement University, Ph.D in Law, Professor, Police Colonel

First Secretary:

Erdenebayar M. Director, Scientific Research Institute, Ph.D in Law, Police Colonel

Secretary:

Munkhdorj B. Senior Researcher, Police Studies Center, Scientific Research Institute, Police Major

Members:

Altangerel B. Dean, Court Decision Execution Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Law, Colonel

Ariunbileg Sh. Dean, Department of of Law Theory, Law and Social Science Institute, Ph.D in law, Police Colonel

Batsaikhan N. Dean, Disaster Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Biology, Associate Professor, Major

Ganbadral N. Dean, Department of Police Law, Police Institute, Ph.D in Law, Police Colonel

Gantulga S. Associate Professor, Department of Criminology and Criminal Law, Police Institute, Ph.D in Law, Police Major

Davaa B. Dean, Forensic Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Biology, Police Lieutenant Colonel

Muratkhan T. Senior Editor of Publication and editorial offices, Ph.D in Military Science, Professor, Colonel

Myagmartseren D. Dean, Department of Intelligence work, Police Institute, Ph.D in Law, Associate Professor, Police Colonel

Narmandakh S. Dean, Department of Foreign Language, Institute of Law and Social Science, Police Colonel

Nyamsuren Ch. Dean, Police Studies Center, Research and Development Institute, Ph.D in Law, Police Colonel

Odbaatar B. Professor, Professor's Team of Police Management, Executive Leadership Academy of Law Enforcement, Ph.D in Law, Associate Professor, Police Colonel

Uvgunburgud J. Dean, Border Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Military Science, Associate Professor, Colonel

Tsolmon B. Senior Researcher, Forensic Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Law, Police Lieutenant Colonel

Enkhbold B. Dean, Department of Criminology and Criminal Law, Police Institute, Ph.D in Law, Police Major

Enkhjargal D. Dean, Training Team of Foreign Language, Graduate School, Ph.D in Linguistics, Associate Professor, Police Lieutenant Colonel



ГАРЧИГ-TITLE



"ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ" СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ	6
МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ	9
Б.Алтанхүү Хил хамгаалах ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа	
SOME ISSUES ON BORDER SECURITY OF MONGOLIA AND CHINA	14
Altankhuu B. Colonel, Head of Administration Directorate, General Authority for Border Protection	
ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	
BORDER SECURITY AND STATE POLICY, LEGAL ENVIRONMENT	
Д.Алтангэрэл Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа, докторант	20
Altangerel D. Lieutenant Colonel, PhD student, Associate professor, Border faculty, Border Institute, Law Enforcement University	
ХИЛИЙН БООМТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХИЛИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ЭРСДЭЛ ТООЦОХ АРГА ЗҮЙГ ХЭРЭГЛЭХ АРГА ЗАМ	
THE WAYS TO IMPROVE METHODS OF RISK MANAGEMENT AND SECURITY OF BORDER CROSSING POINTS	26
Д.Баярсайхан Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн эрхлэгч, цэргийн ухааны магистр, хурандаа	
Baysaikhan D. Colonel, Master in Military Science, Head, Department of Security at Border Crossing Points, Border Institute, Law Enforcement University	
ХИЛИЙН БООМТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ	
SOME ISSUES OF IMPROVING THE CURRENT SITUATION AND LEGAL ENVIRONMENT OF BORDER POINT	36
Х.Асхар Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын дэд профессор, докторант, хошууч	
Askhar Kh. Major, PhD student, Assistant Professor, Faculty of Border Checkpoint Security, Border Institute, Law Enforcement University	
ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АШИГЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	
THEORY AND RESEARCH BASIS TO APPLY DIPLOMATIC ACTION IN ENSURING BORDER SECURITY	43
Б.Аманбек Хууль сахиулахын их сургуулийн докторант, дэд хурандаа	
Amanbek B. Lieutenant Colonel, PhD Student, Law Enforcement University	



ОЛОН УЛСЫН ТЕРРОРИЗМ БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА

PREVENTION OF INTERNATIONAL TERRORISM

Л.Бат-Очир

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад
Bat-Ochir L.
Police Captain, Senior Lecturer of Criminal Law and Criminology faculty,
Police Institute, Law Enforcement University

55

ХИЛ ДАМНАСАН БОЛОН ХИЛИЙН БҮСЭД ГАРСАН ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭР УНТРААХАД ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ

FOREST FIRE ISSUES ACROSS THE BORDER AND BORDER AREA

Д.Хадбаатар

Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулийн
Онцгой байдлын албаны тэнхимийн эрхлэгч, хошууч
Khadbaatar D.
Major, Head of the State Emergency Department,
School of Noncommissioned Officer, Law Enforcement University

62

Ю.Ганзориг

Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулийн
Онцгой байдлын албаны тэнхимийн ахлах багш, ахмад
Ganzorig Yu.
Captain, Senior lecturer of the State Emergency Department,
School of Noncommissioned Officer, Law Enforcement University

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР ГАРГАХ УР ЧАДВАРТ СУРАЛЦАХ НЬ

LEARNING IN DECISION MAKING SKILLS

А.Гантуул

Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Удирдахуйн ухааны профессорын багийн дэд профессор, цагдаагийн хошууч
Gantuul A.
Police major, Associate professor of Management Professor's team,
The Executive Leadership Academy, Law Enforcement University

68

ХИЛ ДАМНАСАН БОЛОН ХИЛ ОРЧМЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛД

CHALLENGES FACING CROSS-BORDER ROAD FREIGHT TRANSPORTATION

М.Дэлгэрнасан

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургууль
Delgernasan M.
School of Mechanical Engineering and Transportation,
Mongolian University of Science and Technology

76

Э.Чанцалдулам

“Автотээврийн үндэсний төв” Төрийн өмчит үйлчилгээний газар
Chantsaldulam E.
“National Center for Road Transportation” State Owned Enterprise



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРОО



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



ХУУЛЬ
САХИУЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ



ХИЛ ХАМГААЛАХ
ЕРӨНХИЙ ГАЗАР



ХБНГУ-ЫН
ХАННС-ЗАЙДЕЛИЙН
САН

“ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Хууль сахиулахын их сургуулиас санаачлан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг олон улсын эрдэм шинжилгээний хурлыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хил хамгаалах ерөнхий газар, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сантай хамтран “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр 2018 оны 10 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд тус Их сургуулийн төв байранд амжилттай зохион байгуулав.

Энэ удаагийн хуралд төрийн захиргааны байгууллага, шүүх мэдлийн болон хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн бус байгууллага зэрэг 54 байгууллагуудын 250 гаруй эрдэмтэн судлаач, мэргэжилтэн, ОХУ, БНХАУ-ын эрдэмтэн судлаач, Монгол Улсад суугаа АНУ, Франц, Казахстан, Вьетнам, БНСУ, Франц, Итали, Энэтхэг, Куба, Япон зэрэг улсын элчин сайдын яам болон АНУ-ын Азийн сан зэрэг олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцож, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хилийн аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, хууль сахиулах үйл ажиллагаанд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай асуудлаар дараах саналыг гаргав.

I. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд:

1. НҮБ-ын дүрмийн 102-ын 1-д “Нэгдсэн Үндэстний Байгууллагын аль ч гишүүний байгуулсан аливаа гэрээ болон олон улсын хэлэлцээрийг Нарийн бичгийн дарга нарын газарт аль болохоор шуурхай бүртгүүлж, тэндээс хэвлэн нийтлүүлж байвал зохино” гэж заасан нь маргаан үүссэн үед НҮБ-ын салбар байгууллагууд, түүний дотор Олон улсын шүүхэд энэ асуудлаар хандан шийдвэрлүүлэх боломжийг олгож байгаа зохицуулалт болно. Иймд Монгол-Оросын хилийн гэрээг дээрх заалтыг үндэслэн НҮБ-д бүртгүүлэх шаардлагатай. Үүний үр дүнд Монгол Улсын хойд хилд аливаа маргаан үүсэх тохиолдолд түүнийг шийдвэрлэх олон улсын эрх зүйн орчин бүрдэнэ;

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гэсэн 3 дугаар бүлгийн “Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал” хэсэгт 3.1.2.8 дугаар заалт болгож, “Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт хил

залгаа улстай харилцан итгэлцэл, ойлголцол, олон улсын эрх зүйн хүрээнд “нэг хил, хоёр улс” зарчимд тулгуурлан улсын хилийн аюулгүй байдлыг хамтран хангана” гэж өөрчлөх хуулийг төслийг УИХ-д өргөн барьж, батлуулах;

3. Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт уул уурхай, ашигт малтмал олборлох, байгалийн баялаг хууль бусаар ашиглагчдаас улсын хилийн аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөллийг мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын багаар судалгаа дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийлгэх, цаашид энэ талаар зөвлөмж гарган 3 жил тутам ҮАБЗ-д танилцуулдаг байх.

II. Монгол Улсын Их Хуралд:

1. Монгол Улсын Засгийн газрын тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого болон бусад холбогдох хууль, бодлогын баримт бичигт “Хилийн аюулгүй байдлын тухай” нэмэлт, өөрчлөлт, тодотгол оруулах;

2. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг Монгол Улсын Засгийн Газраас батлан гаргасан журмаар зохицуулдаг эрх зүйн үндсийг бүрдүүлж мөрдүүлэх;

3. Улсын хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдийн эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг сайжруулах, алслагдсан бүс нутгийн нэмэгдлийг олгох, эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар хил хамгаалалтад нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

III. Монгол Улсын Засгийн газарт:

1. Хилийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дүгээр заалтыг хэрэгжүүлж “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх, байгууллага иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам”-ыг ойрын хугацаанд гаргаж мөрдөх;

2. Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөр (стратегийн) боловсруулан, хилийн аюулгүй байдлын бодлогыг цогцоор хэрэгжүүлэх арга хэмжээг авах;

3. Евро Азийн гаалийн нэгдсэн конвенцод нэгдэх, хилийн болон гаалийн нэгдсэн хяналтын системийг ОХУ, БНХАУ-тай хамтран хэрэгжүүлэх асуудлыг судалж, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг Засгийн Газар хооронд болон холбогдох байгууллагуудын хооронд авч хэрэгжүүлэх;

4. Улсын хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хилийн аюулгүй байдлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор Монгол Улс – Бүгд Найрамдах Хятад Улсын хил хамгаалах байгууллага хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийг Засгийн газрын түвшинд байгуулах;

5. Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт зэвсэгт болон зэвсэггүй мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх талаар улс хоорондын хэлэлцээр байгуулах, нэгдэн орох (ШХАБ-ын гишүүн орнуудын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн Уфа хотод, байгуулсан “хилийн асуудлаар харилцан хамтран ажиллах хэлэлцээрт нэгдэх);



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
1924

6. Ой, тал хээрийн бүс нутагт хил давсан түймрээс урьдчилан сэргийлэх зурвас байгуулах, байгуулсан зурвасыг хамгаалах технологи, багаж хэрэгслээр хангах зардлыг тухайн орон нутгийн төсөвт жил бүр тусгах.

IV. Хууль зүй, дотоод хэргийн яаманд:

1. Хил дамнасан болон хилийн бүс, зурваст үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох судалгааг 3 жил тутам хийж, санал, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж байх;

2. Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, ялангуяа хүн болон зэвсэг, галт хэрэгсэл худалдаалах, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, түүхийн болон археологийн үнэт олдворыг хил давуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцооны “нэгдсэн сан”-г байгуулах;

3. Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, хилийн аюулгүй байдлын судалгааг тогтмол явуулж, үр дүнг Засгийн газарт 2 жил тутам тайлагнаж байх.

V. Хил хамгаалах ерөнхий газарт:

1. ХСИС-ийн Хилийн сургуулийн багшлах бүрэлдэхүүнийг чадваржуулах, ялангуяа хилд үүрэг гүйцэтгэж байсан туршлагатай болон эрдмийн зэрэг цолтой багш нараар бүрдүүлэх, томилох;

2. Хөрш улсуудын хил хамгаалах байгууллагуудтай хилийн аюулгүй байдлыг хангах талаар хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

3. Хил хамгаалах байгууллагын сургалтын хөтөлбөрт хилийн аюулгүй байдал, түүнийг хангах чиглэлээр нэмэлт хичээл төлөвлөж оруулах.

VI. Хууль сахиулахын их сургуульд:

1. Хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг шинжлэх ухааны үндэстэйгээр хэрэгжүүлэхэд хил судлалын шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг ихээхэн чухал учраас түүнийг хөгжүүлэхэд бүх шатны төрийн болон эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын анхаарлыг хандуулах;

2. Хилийн сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд “Хилийн аюулгүй байдал”-ын талаар мэдлэг олгох хичээлийг шинээр нэмж оруулах;

3. Ахисан шатны боловсролын сургуулийн магистрын болон докторын сургалтын төлөвлөгөөнд хилийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хичээл төлөвлөн оруулах;

4. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хил судлалын төвийн бүтэц, орон тоог нэмэгдүүлж эрдмийн зэрэг, цолтой, судалгаа хийж байсан туршлагатай судлаачдаар бүрдүүлэх, судалгаа хийх чадамжийг нэмэгдүүлэх, судалгааны ажлын чанар, үр дүнг сайжруулах.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогчид

Монгол Улс, Улаанбаатар хот

2018 оны 10 дугаар сарын 11

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Алтанхүү

Хил хамгаалах ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа



МОНГОЛ
ХАМГААЛАХ
ЕРӨНХИЙ
ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ
УДИРДАГЫН
ГАЗРЫН
ДАРГА,
ХУРАНДАА

Товч агуулга: Монгол, Хятадын улсын хил нь дэлхийн хамгийн урт 4 газрын хилийн нэгэнд тооцогдохын зэрэгцээ газарзүй, байгаль цаг уур, хүн ам, дэд бүтцийн хувьд өвөрмөц, өөрийн онцлогтой. Улсын хил дамнасан гэмт хэрэг нь эдгээр онцлог болон сүүлийн 30 орчим жилд улс орны нийгэмд гарсан өөрчлөлтүүдтэй ихээхэн хамааралтай байна. Энэ өнцгөөс харахад хэдийгээр нааштай хандлага ажиглагдаж буй боловч бүс нутаг, цаашилбал олон улсын аюулгүй байдлын чиг хандлага, орчинг харгалзан тодорхой арга хэмжээнүүдийг хоёр улс хамтын ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлэх нь Монгол, Хятадын хилийн аюулгүй байдлыг хангахад үр дүнтэй болно.

Түлхүүр үгс: Хилийн аюулгүй байдал, Хил дамнасан гэмт хэрэг, Монгол-Хятадын хил.

Оршил

1990-ээд оны эхэн хүртэл Монгол, Хятадын хил улс төрийн болон бусад шалтгааны улмаас харьцангуй хаалттай хил байсан боловч энэ үеэс эхлэн хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хөдөлгөөнд нээлттэй болсон билээ. Энэ хил өөрийн аюулгүй байдлын хүндрэл, зорилтуудтай тулгарч эхэлсэн 1990-ээд оны эхэн үед Монгол Улс улс төр, нийгмийн шилжилт хийж, БНХАУ-д илүү нээлттэй байх бодлого баримталж, эдийн засгийн хурдацтай хөгжилд шилжиж байсантай давхцаж ирдэг. Хоёр улсын хооронд хүн, капитал, барааны урсгал ч хурдацтай нэмэгдэв. Энэ бүх эрчимтэй урсгал эдийн засгийн хөгжил дэвшлээс гадна төрөл бүрийн хил дамнасан гэмт хэргийг тээж ирсэн байна.

Энэ үед уламжлалт бус аюулын асуудал олон улсын хэмжээнд яригдаж, хүлээн зөвшөөрөгдөж ирсэн байдаг. Энэ асуудал цаг уурын өөрчлөлтөөс эхлээд гоц халдварт өвчин хүртэл олон төрлийн асуудлыг өөртөө багтааж ирсэн. Түүний дотор үндэстэн дамнасан гэмт хэрэг анхаарал татах болсон бөгөөд энэ асуудал нь дэлхийн улсуудын үндэсний болон хилийн аюулгүй байдалд бодит болон болзошгүй аюулыг бий болгож, хил дамнасан гэмт хэргийн асуудлыг өөртөө багтаах болжээ.

Хил дамнасан гэмт хэрэг дийлэнхдээ ашгийн төлөө болон бусад зорилгоор хоёр улсын эдийн засаг, нийгмийн өөр өөр нөхцөл байдлыг хууль бусаар ашиглах үйл ажиллагаа юм. Энэ нь хүний болон нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн бүхий л үйл ажиллагааны төрөлд илэрдэг. 2017 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Хилийн тухай хуулиар ХХБ-д хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүрэг нэмэгдэж тусгагдсан.

Энэ утгаар нь Монгол, Хятадын хил дамнасан гэмт хэргийн асуудлыг сүүлийн 30 орчим жилийн байдлаар хоёр улсын үндэсний болон хилийн аюулгүй байдалд учруулах уламжлалт бус аюулын хүрээнд харж та бүхний анхаарлыг хандуулъя.



Монгол, Хятадын хилийн онцлог

Монгол, Хятад улс нь 4700 гаруй км буюу дэлхийд 4 дүгээрт орох урт хилтэй бөгөөд Монгол, Хятад улсын хувьд бусад хөрш улсуудаас нь хамгийн уртад тооцогдох хил юм.

Хоёр улсын хооронд байгуулсан 1962 оны Хилийн гэрээг 1975 онд НҮБ-д бүртгүүлсэн. Хилийн асуудлаар холбогдох бүхий л гэрээ, хэлэлцээр тухайлбал, Хилийн гэрээ, Хилийн дэглэмийн гэрээ, Хилийн боомт, түүний дэглэмийн гэрээ, Иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай хэлэлцээр, Гэмт хэрэгтэй тэмцэх тухай хэлэлцээр байгуулагдсан. Олон улсын эрх зүйн хувьд бүрэн баталгаажсан хил юм.

Энэ хил нь дэлхийд хамгийн урт бөгөөд тайван хилийн нэгэнд зүй ёсоор орж байна. Монгол болон Хятад улс нь газар нутаг, хил хязгаарын хувьд ямар нэг маргаангүй. Хилийн орон зайд шашны болон үндэстэн, ястны зөрчилгүй. Өнөөгийн байдлаар энэ хилийн хэсэгт ямарваа терроризм, салан тусгаарлах, шашны хэт даврагсдын үйлдэл байхгүй байна.

Монгол-Хятадын хил нь газарзүй, цаг уур, хүн ам, дэд бүтцийн хувьд өвөрмөц онцлогтой.

Энэ хилийн орон зайд хүн ам хамгийн сийрэг суурьшсан. Энэ нь ялангуяа Монгол Улсын талд илүү ажиглагдах бөгөөд дэд бүтцийн хувьд сул хөгжсөн.

Монгол, Хятадын хил дамнасан гэмт хэргийн талаарх зарим ажиглалт

Монгол, Хятадын хил дамнасан гэмт хэргийн хувьд дийлэнхдээ хууль бусаар хил давсан болон давуулсан малын зөрчил, хориотой болон хязгаарласан бараа, бүтээгдэхүүн, машин, түүхэн болон соёлын дурсгалт зүйл, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хууль бусаар хил давуулах, хууль бусаар хил давж ан агнах, загас барих, байгалийн баялаг ашиглах төрлийн хэргүүд гарч байсан. Одоо ч тодорхой хэмжээгээр гардаг.

Монгол, Хятадын хил дамнасан гэмт хэргийн талаар дараах зарим ажиглалтыг хийж болохоор байна.

1. Монгол, Хятадын хилд сүүлийн 30 орчим жилийн хугацаанд цөөн төрлийн хил дамнасан гэмт хэргүүд гарч байсан. Эдгээр нь тодорхой хугацаанд, тодорхой орон зайд идэвхжин, эрчимждэг боловч тодорхой шалтгаанууд тухайлбал хоёр улсын хил хамгаалах албадын зүгээс хил хамгаалалтыг идэвхжүүлэх, сөрөг арга хэмжээ авах, сэдэл, хэрэгцээ, нийлүүлэлт нь алга болох зэрэг тодорхой шалтгаануудын улмаас бүр мөсөн алга болж, таслан зогсоогдож байсан. Хоёр жишээ хэлэхэд барууны улсуудад үйлдвэрлэсэн автомашиныг БНХАУ-руу хууль бусаар давуулах худалдаалах, БНХАУ-аас Монгол Улс уруу хууль бусаар спирт хил давуулах зэрэг зөрчлийг хэлж болно.

2. 1990 оноос өмнөх 25 жилд Монгол, Хятадын хилд гарсан хил дамнасан гэмт хэрэг нь дараагийн 25 жил буюу 1990-2015 онд гарсантай харьцуулахад тооны хувьд дөрөв дахин нэмэгдсэний зэрэгцээ төрлийн хувьд олширсон байна. Хэдий тийм ч энэ тоо сүүлийн 30 орчим жилд 1990-2000, 2000-2010, 2010-одоог хүртэл гэсэн гурван шатлалаар буурч, илрүүлэлт нь өсөж ирсэн байна.



Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх өнөөгийн механизм

3. Илүү олон тооны хил дамнасан гэмт хэрэг улсын хилийн боомт хооронд буюу хилийн боомтуудаар илрэх болсон нь 70%/30%-ийн харьцаатай байна. Энэ хил Монгол улсын хувьд худалдааны том боомттой бөгөөд Монгол Улсын импортын 33, экспортын 84 хувь нь Хятад улстай хийгддэг. Нийт зорчигч, тээврийн хэрэгслийн мөн 60 гаруй хувь нь энэ хилээр нэвтэрдэг. Хоёр улсын хооронд зорчих зорчигч, тээврийн хэрэгслийн тоо үргэлж өсөлттэй байж ирсэн. 2000 онд 1,5 сая зорчигч, хагас сая орчим тээврийн хэрэгсэл энэ хилээр нэвтэрч байсан бол өнөөгийн байдлаар жилд дунджаар 3,5 сая зорчигч, 2 сая тээврийн хэрэгсэл нэвтэрч байна.

4. Монгол Улсын болон Хятадын хил дамнасан гэмт хэргийн тоо, төрөл нь хоёр улсын тодорхой аймаг, орон нутагтай тодорхой хэмжээгээр хамааралтай байна. Тухайлбал Монгол Улсаас БНХАУ-д нэвтрэх зорчигчдын 94, тээврийн хэрэгслийн 96 хувь нь БНХАУ-ын ӨМӨЗО-той хил залгаа хэсгээр нэвтэрдэг. Цөөн тооны тохиолдлыг эс тооцвол хил дамнасан гэмт хэрэг ч мөн үүнтэй ижил хандлагатай.

5. Сэдэл, хэмжээ, давтамжийг нь харгалзан үзэхэд Монгол, Хятадын хил дамнасан гэмт хэрэг нь зарим улстай харьцуулахад улсын хил гэдэг аюултай орон зай, хамгийн аюулгүй байдлын эмзэг цэг болсон тухайлбал Энэтхэг/Пакистан, Энэтхэг/Бангладеш, АНУ/Мексик зэрэг орнуудыг бодвол хилийн аюулгүй байдалд үзүүлэх аюул заналын хэмжээгээр тайван байна.

Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх өнөөгийн механизм

Төр, засгийн дээд түвшинд хоёр тал хилийн аюулгүй байдлыг хамтран сахиулах чиглэлээр бодлогын болон үйл ажиллагааны үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд бэлэн байгаагаар илэрхийлсээр ирсэн. Тухайлбал 2001-2005 онд явагдсан хоёрдох удаагийн хилийн хамтран шалгах комиссын хамтарсан мэдэгдэлд *"...талууд Монгол, Хятадын хилийг энх тайван, найрсаг хамтын ажиллагааны хил байлгахгаар санал нэгтэй тэмдэглэв..."*. Түүнчлэн, хоёр улсын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлд шилжүүлэх 2014 оны хамтарсан мэдэгдэлд *"...хууль сахиулах байгууллагуудын хооронд ялангуяа хил хамгаалах байгууллагуудын хооронд дээд түвшинд харилцах механизмыг хөгжүүлэх, бэхжүүлэх асуудлаар хамтран ажиллана..."* гэж дурджээ.

Одоогийн байдлаар хоёр орны хооронд 160 гаруй эрх зүйн баримт бичиг байгаагаас 20 гаруй нь хилийн асуудалтай холбоотой байна. Хилийн асуудлыг хамтран шийдвэрлэж байх эрх зүйн гол механизм болох Хилийн дэглэмийн гэрээний дагуу түүний хэрэгжилтийг хангах механизм болох өөрийн үйл ажиллагааны журмыг батлан гаргадаг Монгол, Хятадын хилийн хамтарсан комисс байгуулагдан ажиллаж байна. 2011 онд байгуулагдсан Гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааны талаарх Засгийн газар хоорондын хэлэлцээр нь хил дамнасан гэмт хэргийн эсрэг хамтран ажиллах чухал суурь юм.

Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд Монгол Улсын Хил хамгаалах алба, БНХАУ-ын НАХЯ-ны болон Батлан хамгаалахын салбар нэгжүүдтэй хамтран ажиллаж байна. Монгол Улсын болон БНХАУ-ын хилийн төлөөлөгчдийн хамтын ажиллагаа нь хилийн зөрчил, хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,

хилийн асуудлыг шийдвэрлэх өдөр тутмын хамтын ажиллагааны чухал механизм болж байна.



Санал

Хил дамнасан гэмт хэрэг нь ойрын ирээдүйд ч өөрийн мөн чанараа өөрчлөн үргэлжлэх өндөр магадлалтай бөгөөд бүс нутаг, цаашилбал, дэлхийн хэмжээнд аюулгүй байдлын төсөөлөх боломжгүй нөхцөлд хоёр улс хилийн аюулгүй байдлын хувьд хүндрэл, сорилттой тулгарсаар байх нь маргаангүй юм. Ийм ч учраас хоёр улс улсын хилээр гарч болзошгүй аливаа аюулд сонор сэрэмжтэй, бэлэн байхыг шаардаж байна.

Хил дамнасан гэмт хэрэг, бусад хилийн зөрчлийн асуудлаар мэдээллийг шуурхай солилцох, холбогдох албадын дээд түвшний уулзалт яриа, үе шаттайгаар зохион байгуулсан хамтарсан сургууль, дадлага, шалгалт, операц зэрэг нь хоёр улсын хилийн албадын чадавх, хамтран ажиллах чадамжийг дээшлүүлснээр Монгол, Хятадын хилд хил дамнасан гэмт хэргийн асуудлыг бууруулж чадсан байна. Энэ өнцгөөс эргэн харахад сүүлийн 30 орчим жилийн хугацаанд хоёр улсын хилчдийн хамтын ажиллагаа хөгжиж, хил дамнасан гэмт хэргийг таслан зогсоох чиглэлд үр дүнд хүрч, хамтын ажиллагаа тогтмолжин хөгжиж, түүний эрх зүйн үндэс нэгэнт бүрдэж чадсан байна. Харин тодорхой хугацаанд бий болсон аюулын эсрэг хариу үзүүлэх төдий биш болзошгүй аюулыг харах хэмжээнд урьдчилан сэргийлэхэд чиглэсэн стратегитай байх хэрэгтэй байна.

Бид хилийн аюулгүй байдлыг энэ хүрээнд нь биш үндэсний болон нийгмийн аюулгүй байдлын хүрээнд нь, хил дамнасан гэмт хэргийг хил дамнасан хууль бус үйл ажиллагааны хүрээнд бус үндэстэн дамнасан гэмт хэргийн нэг хэсэг ч байж болзошгүй гэдэг талаас нь харах шаардлага ирж байна. Өөрөөр хэлбэл хамтын ажиллагааны хүрээнд хилийн аюулгүй байдлыг хангахад иж бүрэн хандах хандах шаардлагатай. Тийм ч учраас энэ шаардлагад нийцсэн сайн бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэл, илүү бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, хилийн аюулгүй байдлыг хангах дэвшилтэт технологи, хамгийн гол нь илүү зохицуулалт, хамтын ажиллагаа, ойлголцол шаардлагатай байна.

Хүндрэлтэй бөгөөд харилцан уялдаатай эдийн засаг, нийгэм, соёл, институцын олон хүчин зүйл улсын хилийн нөхцөл байдлыг хэлбэршүүлж байхад хилийн шугамаас гадна хил орчмын нутаг дэвсгэрийг хилийн аюулгүй байдлын бодлогын хувьд гол орон зай гэж үзэх шаардлага тулгарч байна. Эцсийн дүндээ энэ бүхэн хүний ялангуяа хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч буй хүмүүсийн амар амгалан, аюулгүй байдлын асуудал юм. Хил орчмын нутаг дэвсгэр, тэнд оршин суугчдад чиглэсэн бүхий л бодлого нь хилийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байх болно.

Дүгнэлт

Монгол, Хятадын хил хууль ёсны худалдаа, зорчигч, бараа, эд зүйлст нээлттэй боловч аливаа хууль бус үйл ажиллагаанд хаалттай хил байх ёстой. Өөрөөр хэлбэл нээлттэй бөгөөд хяналттай хил юм. Энэ хил энх тайван, найрамдлын хил байх ёстой. Даяаршиж буй энэ эринд ялангуяа олон улсын

худалдаа, капитал, хүний урсгал, улс хооронд асар хурдацтай нэмэгдэж, үүнийг дагалдан уламжлалт бус аюулын нэг болох үндэстэн дамнасан гэмт хэрэг эрчимжиж буй энэ үед энэ асуудлыг хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх шинэлэг арга хэрэгслийг гаргаж, үр дүнтэй ашиглах нь зайлшгүй шаардлагатай.

Хилийн дэглэмийн гэрээний оршилд *"...улсын хилийг хамтран хамгаалахад бүхий л хүчин чармайлтыг гаргаж, энх тайван, найрамдлын хамтын ажиллагааны хил байлгана..."* гэж дурдсаныг тэмдэглэж байна.

Улсын хил аюулгүй байх нь хил залгаа улсуудын хамтын хил аюулгүй байна гэсэн үг. Нэг улсын хил гэж байдаггүй харин "нэг шугам-хоёр улс", "нэг хил-хоёр хилчин" гэсэн зарчим бий.



МОНГОЛЫН
ХУУЛЬ
ЭРХЭМ
ХАМГААЛАХ
АКАДЕМИ

SOME ISSUES ON BORDER SECURITY OF MONGOLIA AND CHINA

Altankhuu B.

Colonel, Head of Administration Directorate, General Authority for Border Protection

Abstract: The Common border of Mongolia and China, the 4th longest land border in the world, has its unique features in terms of geography, climate, population and infrastructure. Cross border crime on this border has intrinsic link with above mentioned features and the changes occurred in the society of the country. In this sense, it would be effective to take certain measures in consideration of the regional, moreover, international security trend and environment within the frame of the cooperation between Mongolia and China to ensure the border security of the two countries.

Keywords: Border security, Cross border crime (CBC), Mongolian and Chinese border.

Preamble

A common border of Mongolia and China was comparatively closed mainly due to the political reasons up until 1990s, however, since then it became open to flows of passengers and means of transportations. This border started experiencing its own security challenges and difficulties since early 1990s, when important events such as political and economic transitions in Mongolia and further opening-up and rapid economic growth in China happened. As a result, rapid flows of people, capital and goods soared between the two countries. These brought with it not only development and economic progress but as well as different types of cross border crimes (CBC).

This period was exactly when non-traditional security threat starts to pose challenges to states. CBC is a phenomenon that illegally took advantage of the different economic and legal situation of the two countries mostly for profit and other purposes, it is found in various fields of criminal activities against security of humans and society. According to the 2017 new revised Law on Border of Mongolia, prevent from and intercept the CBC is one of the new missions of the Border Protection Organization in Mongolia.

In this sense, I would like to draw your attention to the CBC issues between Mongolia and China as non-traditional security threat to the national and border security of the two countries for the last three decades or so.

Features of Mongolian and Chinese border

Mongolia and China share 4709 km common border, the fourth longest land border in the world and the longest for both Mongolia and China compared with the border they share with their neighboring countries.

The border treaty of 1962 concluded between the two countries has been registered with the United Nations in 1975 which is an important characteristic of this border. There are all the relevant treaties and agreements in relation to border

management purposes signed. As far as international law is concerned, it is fully guaranteed border.

This is one of the most peaceful border in the world. Mongolia and China have no disputed issues with regard to territory and border and there is no religious and ethnic conflict in border area. So far there are no significant cases of terrorism, separatism and extremism in MCB area.

MCB has diverse features in terms of geography, climate, population and infrastructure. This border is one of the most sparsely populated, and more so in the Mongolian side, and the infrastructure is less.

Some observations on the CBC between Mongolia and China

CBCs on MCB were and are mostly cattle related illegal border crossings, smuggling of prohibited or restricted goods, products, cars and historical and cultural items, smuggling of cattle related raw materials, illegal cross border hunting, fishing and exploitation of natural resources.

Some general observations can be made on CBC on MCB.

1. On MCB, there were several unique CBCs occurred during the period of last three decade or so. They were active or prevalent at certain period of times and disappeared or stopped due to certain reasons: better border protection and response by the relevant authorities of the two countries, disappearance of the motivation, no longer existing supply and demand etc.,. Just to name, smuggling of western made cars to China, smuggling of alcoholic spirit to Mongolia are the few examples to name.

2. CBCs occurred on MCB in 25 years before 1990 quadrupled in numbers in 25 years between 1990-2015 and its type diversified. Yet, this number for the last three decade has been decreasing in three phases: 1990-2000, 2000-2010 and 2010 to present and the number of interception is increasing.

3. More and more CBCs are being committed through BCCs than between the BCCs showing a ratio of 70%/30%. Flow of passengers and means of transportations crossing the border between the two countries have always been on the rise. While in 2000, more than 1.5 million passengers and half million means of transportation were crossing the borders of the two countries, now annually around 3.5 million passengers and 2 million means of transportation cross the border.

4. Certain border regions of Mongolia and China has some connection with the number and types of CBC. For instance, 94% of all the passengers and 96% of all the means of transportation of Mongolia with China goes through the border with Inner Mongolian autonomous region in China. Generally, this is the case for border violations except few instances.

5. Considering its motive, volume and frequency, the CBC on MCB are reasonable in terms of its danger or threat to the border security of the two countries compared with some other countries where border is dangerous area or the most security sensitive zone like borders between India/Pakistan or Bangladesh; or USA/Mexico.



Measures and mechanisms being implemented

At the highest government level, two sides were always eager in terms of policy and operations to take effective measures to maintain joint border security. In the joint declaration of the border demarcation which was conducted second time in 2001-2005 between the two countries, it was provided that *"...unanimously underlined that the Mongolian-Chinese border will be peace and friendly cooperation border."* Moreover, in the joint declaration of 2014 to upgrade bilateral ties to a comprehensive strategic partnership between the two countries, it was mentioned that *"...shall cooperate to develop and strengthen the mechanism of high level relation and cooperation between law enforcement organizations, in particular, border protection organizations among them..."*.

At the moment, there are more than 160 legal documents signed between Mongolia and China and more than 20 are border related agreements among them. Under Border regime treaty which is main legal mechanism to solve border issues, its implementation mechanism was established as Joint Mongolian–Chinese Border commission which adopts its working procedure. An Inter-governmental Agreement on the cooperation against the Crime which was concluded in 2011 is an important framework of cooperation against CBC.

Main official authorities in the fight against the CBC are Border Protection Service in Mongolia and Border protection units, Ministry of Public Security and Military Regions, PLA in China. Border representatives from Border Protection service in Mongolia; and PLA and Ministry of Public Security in China are the most active day to day co-operating mechanism on preventing and resolving border violations.

Recommendations on the measures to take

It is likely that CBCs will continue so changing its nature in the near future and two countries still and will continue to face challenges and difficulties of border security in times of unpredictable security situation in the region and world at large. It is what requires two countries to be ready and vigilant for any potential threats through our borders.

Starting from rapid exchange of intelligence and information on border violation and related incidents, high level of visits between relevant authorities, joint trainings, exercises, inspections, and operations organized in phases were effective in increasing the inter-operability and capacity of the two border guarding forces resulting in decrease of border violations on MCB. However, we will need strategy that is preventive enough to see what will come next, rather that reacting against what has come out at certain times.

We will need to see border security not just in its frame but as part of national and public security frame and CBC not just as cross border illegal activity but as it likely to be part of transnational organized crime. In other words, we will need comprehensive approach in securing our borders in cooperation. Thus, we will need good policy, strategy and operational direction, better trained personnel, advanced technology in maintaining border security and most importantly, better coordination, cooperation and understanding commensurate with this.

In the light of the complicated and often countervailing economic, social, cultural, and institutional forces that shape borders, two governments should have to broaden their traditional focus on the boundary line to include the governance of borderlands as the territory central to security policy. After all it is the safety and security of the people, in particular, living in the borderland area. All the policies directed to the borderland and border area people will have its benefit on the border security.

Conclusion

This border is to be open to legal trade, passengers and capital, yet closed to the illegal activities. In other words, should be open yet controlled border. This border is to be peaceful and friendship border. In this new era of globalization, in particular, increasing speed of international trade, capital and human flows among states followed by new dynamics of non-traditional security threat-TOC, new advanced tools and methods should be exploited and used to effectively tackle this issue in cooperation.

It is time to state from the preamble of the Border regime treaty between the two countries that "... to work and make all endeavor to jointly protect the state border, and to ensure it as border of peace and friendly cooperation..." Just like there is no such thing as border of single country, there exist a principle of "one line-two countries" and "one border- two bordermen."

Bibliography

Laws, legal documents and official publications:

1. Mongolian Law on Border, revised. 2017
2. Criminal Law of Mongolia, revised. 2016
3. State Border Regime treaty of Mongolia and China. 2010
4. Agreement between the Government of Mongolia and the Government of People's Republic of China on Mongolian and Chinese border crossing checkpoints and their regimes. 2004
5. Agreement on the fight against cross-border crimes between Mongolia-China, 2011
6. Statistical information report, General Authority for Border Protection, Mongolia, 2017
7. Mongolia Reference book, National Statistics Committee of Mongolia, 2015
8. "Border Security and Theoretical and practical pressing issues-2017" titled research conference materials, School of Border, Law Enforcement University, 2017
9. "State Border Security and Cooperation-2012" international conference materials, University of Internal Affairs of Mongolia, 2012
10. UNODC. Annual Report-covering all the activities, 2016
11. UNODC. Transnational Organized Crime in East Asia and the Pacific, A Threat Assessment, April 2013
12. UNODC. Transnational Organized Crime-The Globalized Illegal Economy, 2015



МОНГОЛЫН ХУУЛЬ ТАСЛАХ АНГАМ
 ХУУЛЬ ГАРГАХ АНГАМ
 ХУУЛЬ ГАРГАХ АНГАМ

13. Shri Vardhman Parivar. Plunder of India, Research report, Nov 2013
14. Joint declaration by the heads of state, Mongolia and China, 2014 to upgrade bilateral ties to a comprehensive strategic partnership.

Books:

15. Zhao Jingfang. National Security Strategy. Reading materials, ICDS, NDU, 2012
16. Emmanuel Brunet-Jailly. Borderlands: Comparing Border Security in North America and Europe. University of Ottawa Press, 2007
17. Mustafa Oguz. Improving Turkish-Iraqi Border Security. Dissertation. Randee Rand Graduate School, 2014
18. Border Research Partnership. The State of the Border Report: A Comprehensive Analysis of the US-Mexico Border. Wilson Center, Mexico Institute, 2013
19. Serghei Golunov. EU-Russian Border Security: Challenges, Misperceptions, and responses. Routledge, 2012.
20. Jay S. Albanese and Philip L. Reichel. Transnational Organized Crime. An overview from the Six continents. Sage, 2014
21. Letizia Paoli. The Oxford Handbook of Organized Crime. Oxford University Press, 2014

Journal articles:

22. Anxxi Paasi. Boundaries as Social Practice and Discourse: The Finnish-Russian Border. Routledge Taylor&Francis Group, Regional Studies, Oulu, 2010
23. James Anderson. Theorizing State Borders: Politics/Economics and Democracy in Capitalism. School of Geopgraphy and Centre for International Borders Research, Working paper, Queen's Univeristy, Belfast, 2001
24. International advisory Board for Border Security at the Geneva Centre for the Democratic Control of Armed Forces (DCAF). Lessons Learned from the Establishment of Border Security Systems: General Information on Past, Present, and Future Activities. The Quarterly Journal, Fall 2006
25. Thomas Pankratz and Hanns Matiasek. Understanding Transnational Organized Crime. A constructivist approach towards a growing phenomenon. SIAK-Journal-Journal for Police Science and Practice (Vol.2), 41-50, 2012
26. John T. Picarelli. Transnational Organized Crime. 453-467 p, in Paul D. Williams. Security Studies. Routledge, Taylor and Francis Group, 2008
27. Phil Williams. Transnational crime and Security. 265-270 p, in Christopher W Hughes and Lay Yew Meng. Security Studies. Routledge, Taylor and Francis Group, 2011
28. Muratkhan A. Cooperation of the Law enforcement agencies in preventing the smuggling of drugs and narcotics, weopons and arms throug state border. Historical lessons learned from Border protection. Border Research

Sector, 2003

29. Bert Tussing. New Requirements for a New Challenge: The Military's Role in Border Security. Homeland Security Affairs, Volume IV, No.3, October 2008.



Electronic source:

30. Sasa Dordevic. Understanding translational organized crime as a Security threat and Security Theories:WBSO. Carl Schmitt and Copenhagen School of Security Studies, №13 April-June 2009.
<http://citeseerx.ist.psu.edu/viewdoc/download?doi=10.1.1.618.66&rep=rep1&type=pdf>
31. Allan Castle. Transnational Organized Crime and International Security. Institute of International Relations, The University of British Columbia, Working paper, No.19, 1997.
<https://zh.scribd.com/document/51277224/Allan-Castle-Transnational-Organized-Crime-and-International-Security>
32. InterPol web page: www.interpol.int
33. United Nations Office on Drugs and Crime webpage: www.unodc.org
34. Cross-border crime colloquium, www.cross-border-crime.net
35. Central Intelligence Agency, World fact book,
<https://www.cia.gov/library/publications/the-world-factbook>

سازمان امور داخلی
جمهوری آذربایجان

Д.Алтангэрэл

Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн
Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа, докторант
Altangerel D.
Lieutenant Colonel, PhD student, Associate professor, Border faculty,
Border Institute, Law Enforcement University

✉ altangerel.d@leu.gov.mn

Товч агуулга: Төрөөс хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг шинэчлэн гаргаж, үүндээ тулгуурлан хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх, хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Abstract: To redevelop the Border security policy and it is necessary to implement border security system based on the development.

Түлхүүр үгс: Улсын хил, хилийн аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэр, хилийн орон зай, хууль, эрх зүй.

Keywords: State border, border security, immunity of state border, border area, border space, law.

Оршил

Экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм.

Дэлхий нийтэд өрнөж байгаа даяаршил, нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандахын чухлыг харуулж байна.

Сүүлийн үед гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитоор нөлөөлөх болов.

Өнөөгийн байдлаар улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд учруулж болзошгүй аюул занал, эдийн засаг, хүн амын түрэмгийлэл, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг хил дамнасан үндэсний шинжтэй аюул, зөрчил бүхэн хилийн орон зайд хуримтлагдаж байна.



Үүнтэй холбогдуулан дээр дурдагдсан аюулуудыг арилгах, саармагжуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа улс төр, нийгэм, цэргийн шинжтэй арга хэмжээнүүдийн зэрэгцээ “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд хилийн орчинд учруулж болзошгүй аюул занал”-ын ерөнхий тодорхойлолт, тэдгээрийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд түүн дотроос газар нутгийн маргаан, зэргэлдээ улсад гарч байгаа цэргийн үйл ажиллагааны идэвхжил, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж буй салан тусгаарлах бодлого, үйл ажиллагаа, нийгэм улс төрийн түгшүүртэй байдлын голомт үүсэх үндсийг судлан төрөөс хилийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулж албан ёсоор баталгаажуулах асуудал онцгой чухлаар тавигдаж байна.

Тиймээс төрөөс хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг шинэчлэн гаргаж, үүндээ тулгуурлан хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх, хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Төрөөс хилийн аюулгүй байдлын талаар баримталж буй бодлого

Төрөөс улсын хилийн талаар дараах эрх зүйн акт, хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийг боловсруулан баталсан. Үүнд:

- Монгол Улсын хилийн тухай хууль;
- БНХАУ, ОХУ-тай байгуулагдсан улсын хилийн гэрээнүүд, улсын хилийг газар дээр нь тогтоосон болон олон удаа дараа хамтарч шалгаж тодотгосон Засгийн газар хоорондын протоколууд гарсан;
- Монгол-Хятадын хилийн боомтууд тэдгээрийн дэглэмийн тухай БНХАУ-ын засгийн газартай, Монгол-Оросын хилийн дэглэм, хилийн будлианыг зохицуулах тухай ОХУ-ын засгийн газартай тус тус хэлэлцээр байгуулсан;
- Монгол Улсын Их хурлаас батлагдсан “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргасан;
- Монгол Улсын хил хамгаалах дүрмүүдийг баталсан;
- Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам баталсан;
- Бүсчилсэн хил хамгаалалтын үзэл баримтлалыг засгийн газраас баталсан.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор улсын хилийн аюулгүй байдлын талаарх зохицуулалтыг шинээр тусгасан.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлын бүрэлдэхүүнд хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдлыг цогц байдлаар хамруулсан нь хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход баримтлах төрийн бодлого юм¹.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-д

1. Нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарчимтай уялдуулан Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно;

¹ МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

2. Улсын хил хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах бодлого явуулна;
3. Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээг авна;
4. Хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ;
5. Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно;
6. Хил дээр боомт нээх, хаах, боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага шийдвэрлэнэ;
7. Хилийн дагуух орон нутгийн хөгжлийн бодлого, гадаад харилцаа нь төрийн нэгдсэн бодлогод захирагдана² гэж хилийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлон өгсөн байна.

Төрийн бодлогыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсон боловч тухайн заалтууд нь зөвхөн тунхаглалын чанартай болсон байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогод сүүлийн үед олон улсын хэмжээнд болон хил судлалын шинжлэх ухааны судалгааны категори болсон “Хилийн орон зай”, “Хилийн аюулгүй байдал”, “Хилийн харилцаа”, “Хилийн талаар баримтлах бодлого”, “Хил орчмын нутаг дэвсгэр”, “Хилийн орчин”, “Хилийн хүрээ” зэрэг нэр томъёонууд хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэгч объект, субъектүүд, хилийн орон зайд Монгол улсын үндэсний аюулгүй байдалд учирч болох аюул заналын үндэс зэргийг тодорхойлоогүй байна. Тиймээс үндэсний аюулгүй байдал, тэр дундаа хилийн аюулгүй байдлын талаар үүрэг хүлээсэн субъектүүдэд хариуцлага тооцох эрх зүйн үндэс одоогоор байхгүй байна.

Нийгмийн болоод улсын хилийн орон зайн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичгийг шинэчлэн найруулах шаардлагатай байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь

Манай улс нь хилийн аюулгүй байдлаа хангах гадаад эрх зүйн орчныг НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болж хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гэрээ, конвенцод нэгдэн орсноор, Монгол Улс, ОХУ-ын хооронд, Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан Хилийн дэглэмийн гэрээг УИХ-аар соёрхон баталснаар хэрэгжүүлж байна.

² МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Хил хязгаар нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал” /3.1.2/



Харин дотоод Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг “Үндсэн хууль”, “Монгол Улсын хилийн тухай хууль”, “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Хил хамгаалалтын дүрэм-I, II, III анги”-иар тус тус хэрэгжүүлж байна.

Түүнчлэн өнөөдрийн байдлаар хилийн дэглэмийн болон хилээр зорчигч, ачаа тээш, тээврийн хэрэгслийг харилцан нэвтрүүлэх, зорчих нөхцөл, боомтын асуудлаарх 50 гаруй Монгол Улсын Олон улсын гэрээ үйлчилж байна.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор улсын хилийн аюулгүй байдлын талаарх зохицуулалтыг шинээр тусгасан.

Манай улсын хувьд Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад Хилийн аюулгүй байдал хэрхэн хангагдах, түүнийг ямар арга, хэрэгслээр хангах талаар тодорхой зааснаас гадна “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна.”³ гэж заасан тул Хилийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр боловсруулж түүндээ хөтөлбөрийн зорилго, зорилт, хамрах хүрээ, зарчим, хэрэгжүүлэх арга хэмжээ, удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлэх байгууллагуудын (Яамдууд, тэдгээрийн харьяа агентлагууд, Тагнуулын ерөнхий газар, хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий бусад байгууллагууд) эрх, үүрэг, хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт зэргийг тусган засгийн газраар батлуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичигт “Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно”⁴ гэж заасан байна.

Монгол Улсын олон улсын гэрээгээр улсын хилийг хууль бусаар өөрчлөхгүй байх, түүний аюулгүй байдалд занал хийсэн аливаа үйлдлийн эсрэг тэмцэхийн тулд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, хилийн болон хил орчмын дэглэм, боомтод мөрдөх журам зэргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын хууль, эрх зүйн үйлчлэх нутаг дэвсгэрийн зах хязгаараар улсын хилийг тодорхойлсон байдаг.

Тиймээс улсын хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал хадгалагдан хамаарах орон зайн хүрээний зах хязгаар дотор гарсан хуулиар тодорхойлогдох ёстой.

Хилийн аюулгүй байдлын талаар Монгол Улсын хилийн тухай хуульд хуульчилсан нь төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх субъектүүдийг тодорхой болгож, төрийн бусад байгууллагуудын бүрэн эрхийг хуваарилахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх, тэдний хүчийг нэгтгэж хилийн аюулгүй байдлыг хангахад нэн чухал эрх зүйн үндэслэл болсон.

³ Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга. 5 дугаар зүйл. 5.4.

⁴ Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Нийтлэг үндэслэл 1.8.



Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх явцад буй болсон өнөөгийн байдал, өөрчлөлтүүдтэй холбон авч үзэх нь зүйтэй гэж үзнэ.

Нийгмийн хурдацтай хөгжлийг дагаад хилийн орон зайд өрнөж буй харилцааны бүх асуудлыг хуульчилсан эрх зүйн баримт бичгээр шийдэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Өнөөдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад бага боловч дүн шинжилгээ хийж үзэхэд тулгуур ойлголтуудыг нэг мөр болгох, хилийн аюулгүй байдлын үндэслэлийг гаргах, Ерөнхийлөгч болон Засгийн газраас гаргаж буй баримт бичгүүдийг цэгцлэх, нэг мөр болгох, хуулийн заалтад нийцүүлэх асуудлууд байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлын талаар Монгол Улсын төрийн баримтлах бодлого, эрхэм зорилго бол улсын хил хязгаар нутагт аюулгүй байдлыг хангах явдал юм гэж тодорхойлж болох юм.

Иймийн тулд хил хязгаар, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэсэн асуулт зүй ёсоор урган гарч байгаа нь хилийн аюулгүй байдлыг хэрхэн хангахаас шалтгаалах болоод байна.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь бүхэлдээ үндэсний аюулгүй байдлыг улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрт хангах ажиллагаа байх тул улс орныг батлан хамгаалах арга хэмжээний нэг хэсэг болж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад, дотоодын аюул, заналаас төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан улсын болон олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх, учирч болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх, арилгах тогтолцоо бүрдүүлэхэд оршиж байна.

Үүнээс үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилт бол

- газар нутгийн бүрэн бүтэн байдал;
- улсын тусгаар тогтнолыг хангах;
- улсын хил, хязгаар нутагт сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэгдсэн, хилийг зөрчилгүй байлгах болон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг сахиулах;
- улсын хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх;
- хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал гэж тодорхойлж болох юм.

Хилийн аюулгүй байдлын талаар өнөөгийн мөрдөж буй эрх зүйн актууд, хуулиудад бүрэн хэмжээгээр тусгагдаагүй байгаа ба цаашид түүнийг улам боловсронгуй болгох шаардлага урган гарч байна. Үүний тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “хилийн аюулгүй байдал”-ын талаар нэмэлт өөрчлөлт оруулах, тайлбар өгөх;
2. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод хилийн аюулгүй байдлыг хангах талаар нэмэлт, тодотгол оруулах;
3. Хилийн аюулгүй байдлыг хангах төрийн удирдлагын үйл ажиллагааг нэгтгэн уялдуулах;
4. Олон улсын харилцааг сайжруулахад түлхэц болох улс орны улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд нийцсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
5. Хөрш улстай хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын гэрээ, хэлэлцээрийг шинэчлэн боловсронгуй болгох санал болгож байна.

Монгол Улсын эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хуулиудад хилийн аюулгүй байдлыг хангах талаар тэр бүр бүрэн хэмжээгээр тусгаагүй учир тэдгээрт зохих хэмжээгээр нэмэлт оруулах шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Монгол Улсын Хилийн тухай хууль. 2016.
3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010.
4. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. 2002.
5. Д.Нямдорж. Хил судлал. УБ., 2011.
6. Ч.Улаанхүү. Аюулгүй байдал. УБ., 2014.
7. Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа. ДХИС. 2012.



ХИЛИЙН БООМТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХИЛИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ЭРСДЭЛ ТООЦОХ АРГА ЗҮЙГ ХЭРЭГЛЭХ АРГА ЗАМ

THE WAYS TO IMPROVE METHODS OF RISK MANAGEMENT AND SECURITY OF BORDER CROSSING POINTS

Д.Баярсайхан

Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн эрхлэгч, цэргийн ухааны магистр, хурандаа

Bayarsaikhan D.

Colonel, Master in Military Science, Head, Department of Security at Border Crossing Points, Border Institute, Law Enforcement University

✉ bayarsaikhan.d@leu.gov.mn

Товч агуулга: Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагааг боловсронгуй болгох, Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн нэвтрүүлэх чадамж, хилийн хяналтын байгууллагуудын харилцан ажиллагааг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах, ажлын уялдаа холбоо, нэгдсэн зохицуулалтыг бий болгоход оршино.

Abstract: The aim of the scientific paper is to create combined regulation of such issues related to border security which are qualifying the security of border crossing points, increasing the capacity of checkpoints of vehicles and means of transports through the border crossing points, strengthening the cooperation between authorities that conduct review at the border and their work coordination as well.

Түлхүүр үгс: Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хяналтын байгууллагууд, эрсдэлийн удирдлага, эрсдэл тооцох арга зүй, хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагаа.

Keywords: To provide border port security, control organizations, risk management, risk assessment method, border control organization cooperation.

Үндсэн хэсэг

Төв азийн өндөрлөгт орших Монгол улс газарзүйн байршлын онцлогоос хамааран өөрийн улсын газар нутаг дээгүүр Ази Европыг холбосон шашны, соёлын, худалдааны зам, гарцтай байсан талаар түүхийн ном, сурвалжуудад олонтоо тэмдэглэгдсэн байдаг. Тодруулбал дэлхий дахинд “Торгоны зам, Гүнжийн зам, Цайны зам” гэж нэрлэгдэх энэ зам манай улсаар дайран өнгөрч байсан тухай нотлох баримт олныг дурдаж болно. Улсын оршин тогтнох, амар тайван баталгаа гарцаагүй хил хамгаалах албатай шууд холбоотой юм. Энэ л цаг үеэс хилийн шалган нэвтрүүлэх албаны үүсэл хөгжил эхэлсэн гэж хэлж болохоор байдаг. Өнөөдөр Монгол улсын хэмжээнд нийт 46 боомт үйл ажиллагаа явуулж байгаагаас байнгын 24, түр 15, дамжин 7 байгаагаас олон улсын 14, хоёр талын ажиллагаатай 32 боомт байгаа ба автозамын 39, төмөр замын 3, агаарын 4



боомтод Хил хамгаалах байгууллага боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлын талаарх асуудал нь цоо шинэ ойлголт биш бөгөөд Хил хамгаалах байгууллага шалган нэвтрүүлэх албыг хэрэгжүүлэх явцдаа бусад харилцан ажиллагаа бүхий байгууллага болох цагдаа, тагнуулын байгууллагуудтай хамтран хилийн боомтын аюулгүй байдлыг давхар хангаж иржээ. Үүнээс харахад хэдийгээр хилийн боомтын аюулгүй байдлыг сахиулах нь бидний өмнө нь хийж байсан ажил боловч нөгөө талаас гадаад улс орнуудын цагийн байдал, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдлаас улбаатай учирч болзошгүй эрсдэлт асуудлаас урьдчилан сэргийлэх зорилготой олон шинэлэг ажлуудыг зохион байгуулж, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх шаардлага бид бүгдэд тулгараад байгаа билээ.

Өнөөдөр дэлхийн улс орнууд хилийн боомтын хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулахад олон хүчин зүйлс нөлөөлж байгааг онцолжээ. Үүнд: Террорист халдлага, хар тамхи, хүний наймаа, цагаачлалын зэрэг асуудлуудыг анхаарч үздэг байна. Үүний тод жишээ нь Европын холбооны улсуудын нээлттэй байдал буцаад хаагдмал хэлбэрт шилжиж байгаагаар илэрч байна.

Улсын хилээр нэвтрэх буй зорчигч, тээврийн хэрэгсэлд тавих хяналтыг оновчтой зохион байгуулах асуудал олон жилийн турш хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжин, хөгжиж ирсэн. Хил хязгаараар тусгаарлагдсан улсууд, тэдгээрийн бүрэн эрхт байдлыг хуулийн хүрээнд хамгаалах, хилийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулахад хилийн боомтын хяналтын үйл ажиллагаа чиглэгдэнэ (2012 Bersin). Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад хилийн хяналтын байгууллагын тогтолцоог харилцан адилгүй байдлаар зохион байгуулж ирсэн байна. Энэ байдлыг харгалзан Виддовсон (2007), Козловский (2011) нар хилийн хяналтын үйл ажиллагааг:

- Аюулгүй байдал, Цэрэг, дайны зорилгоор хилийн хяналт тавих;
- Зорчигч, цагаач иргэдийн шилжилт, хөдөлгөөний хяналт;
- Хилээр нэвтрэх бараанаас татвар, хураамж авахтай холбоотой хяналт;
- Бараа, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэх хяналт гэж дөрөв ангилжээ.

Хилийн боомтоор нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих явцад хилийн хяналтын байгууллагууд нь зохион байгуулалт, ашиг сонирхол, харьяалал, үйл ажиллагааны зорилго ба чиглэл, хуулийн өмнө хүлээх хариуцлага, өмчлөлийн хувьд ялгаатай олон субъекттэй харилцдаг. Иймэрхүү ялгаанууд нь хилийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулахад олон төрлийн эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна. Улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хилийн хяналтын байгууллагууд өөр өөрийн чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллана. Эдгээр хяналтыг дараах зурагт бүлэглэн авч үзлээ.

ЦАГААЧЛАЛ:

- Хууль ёсны
- Хууль бус

ЗОРЧИГЧИЙН ХЯНАЛТ:

БАРААНЫ ХЯНАЛТ:

- Татвар, хураамж;
- Барааг хууль бусаах нэвтрүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
- Хүн, амьтан, ургамалын аюулгүй байдал.

Зураг 1. Хилийн хяналтын үйл ажиллагаа

Дээрх чиглэлд тавих хяналтын үйл ажиллагаа нь хэд хэдэн байгууллагын чиг үүрэгт хамаарна. Хэдийгээр хяналтын чиг үүрэг нь ангилал тус бүрт ялгаатай боловч хилийн боомтын хяналтын үйл ажиллагаа нь харилцан уялдаатай хэрэгжих тул орчин үед хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал дэлхий нийтийн анхаарлын төвд байсаар байна.

Орчин үеийн хилийн хяналтын байгууллага нь “зорилго нь тодорхой, дэд бүтэц хөгжсөн, технологийн дэвшлийг ашигласан, цаг хугацаанд анхаарсан, зардал бага гаргах, үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, хялбаршуулсан” гэсэн 6 үйл ажиллагааны хүрээнд хяналтыг зохион байгуулна (Tom Coyle, Kevin Cruthirds, Sara Naranjo and Katharina Nobel, 2014).

Дэлхийн нийтийн хэмжээнд улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн өсөн нэмэгдэх урсгалтай уялдан хилийн хяналтын байгууллагууд хилийн боомтын хяналтын үйл ажиллагааг хялбаршуулах, уялдуулах, стандартчилах, хамтарсан хяналт хийх, нэгдмэл нэг удирдлагатай үйл ажиллагаа явуулах зэргээр олон шинэлэг санаачилгуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, АНУ-ын хилийн хяналтын байгууллага, Зүүн Азийн Хамтын ажиллагааны нийгэмлэг, Швед-Норвеги, Финлянд, Швецари-Франц, Герман-Швецари, ОХУ-Казакстан-Беларусийн гаалийн холбоо зэрэг олон орнууд хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагыг хамтран хэрэгжүүлж байдаг байна.

Хилийн хяналтын байгууллагууд нэг малгайн дор хамтран ажиллах эхлэлийг хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор үүссэн гэдэгтэй судлаачид санал нэгддэг. АНУ-д 2001 онд болсон алан хядах үйл ажиллагааны дараа хилийн хяналтын байгууллагуудын чиг үүрэг бүхэлдээ өөрчлөгдөн, 2003 оны 3 дугаар сараас эхлэн хилийн хяналтын байгууллагууд нь нэгдэн үйл ажиллагаагаа хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагын хэлбэрээр явуулж байна. Дэлхий нийтэд зорчигч, тээврийн хэрэгсэл, гадаад худалдаа бараа нийлүүлэлтийн сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллахын тулд хилийн хяналтын байгууллагын хоорондын ажлын уялдаа холбоо, нэгдсэн зохицуулалтыг бий болгох, эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Үүнтэй уялдан хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон төрлийн арга ажиллагаа, санаачилгуудыг АНУ болон дэлхийн улс орнууд хамтран нэвтрүүлж,



хяналтын орчин үеийн тоног төхөөрөмжийг хэрэглэн, хяналтыг үр дүнтэй тавьж, худалдааг хөнгөвчлөн ажиллажээ.

Хилийн боомтын хяналтад зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хамаарна. Энэхүү хөдөлгөөнд үр дүнтэй хяналт тавих асуудал хилийн хяналтын байгууллагуудын өөр өөрийн үндсэн чиг үүрэгтэй уялдана. Ийнхүү хяналт тавих явцад олон төрлийн эрсдэлтэй учирч байдаг. Иймээс эрсдэл тооцох асуудал гадаад худалдааны орчин нөхцөлтэй уялдан гарч ирсэн. Эрсдэлийн удирдлагын талаар сүүлийн жилүүдэд ихээр ярьж энэ нь орчин нь үеийн хилийн хяналтыг үр дүнтэй тавих инновацийн арга хэрэгсэл, шилдэг техник болсон. Байгууллага өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолон, хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай хуваарилах замаар ажиллахад эрсдэлийн удирдлагын мөн чанар оршино. Үүнтэй уялдуулан хилийн хяналтын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг төрөлжүүлэн (WCO, 2013-2014), тэдгээрийн бууруулж, хилийн боомтын чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр дэлхийн улс орнуудын хэрэгжүүлсэн туршлагыг Дэлхийн Банкны “Бизнес эрхлэхүй” 2011-2015 оны дүгнэлтийн “Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт” үзүүлснийг судалгааны ажлын хүрээнд харьцуулан судалсан (ДБ, 2011-2015). Харьцуулсан шинжилгээнээс харахад дэлхийн улс орнуудын хилийн хяналтын байгууллагууд зөвхөн өөр өөрийн хяналтын чиг үүрэгт анхаарлаа хандуулаагүй хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, хөгжүүлж ажилласан нь харагдаж байна. Эдгээр үйл ажиллагаа, санаачилгыг хэрэгжүүлэх болсон шаардлага нь боомтын хяналтын үйл ажиллагаа давхардсан, боомтын дэд бүтэц хөгжөөгүй, гаалийн бүрдүүлэлтэд хавсаргах бичиг баримтын тоо олон, мэдээлэл солилцох үйл ажиллагаа тогтмолжоогүй, цахим бичиг баримтын баталгаажуулалт нэг мөр болоогүй зэргээс шалтгаалжээ.

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын хилийн боомтын хяналтыг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлсэн тэргүүн туршлага

Үндсэн үйл ажиллагаа, эрсдэлийн төрөл	Олон улсын туршлага
<p>ҮНДЭСНИЙ БОЛОН НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ</p> <ul style="list-style-type: none"> - Буу, зэр зэвсэг; - Үй олноор хөнөөх зэвсэг; - Цацраг идэвхит бодис; - Хар тамхи, мансууруулах бодис; - Хуурамч бараа; - Чанар, стандартын шаардлага хангаагүй бараа; - Аюултай хог хаягдал, озон задалдаг бодис; - Хууль бусаар зорчигч хил нэвтрэх; - Боомт бус газраар барааг хууль бусаар нэвтрүүлэх... 	<ul style="list-style-type: none"> ✓ Хилийн хяналтын байгууллага үйл ажиллагаагаа сайжруулсан: Армян, Египет, Этиоп, Фижи, Гренад, Мали, Перу, Гүрж, Ямайк, Малави, Хойд Африк, Аргентин, Азербайджан, Бенин, Бурунди, Конго, Украин, Узбекистан, West Bank and Gaza, Сан-Томе Принсипи, Свазиланд; ✓ Хилийн хяналтад шаардлагатай бичиг баримтыг цахим хэлбэрээр баталгаажуулсан: Бахрейн, Бруней, Беларусь, Израиль, Казахстан, Латви, Литва, Никарагуа, Пакистан, Перу, Филиппин, Свазиланд, Тунис, Эмирт, Замби, Белиз, Ботсван, Бурунди, Чех, Сальвадор, Грек, Мадагаскар, ОХУ, Шри-Ланка, Уругвай, Доминикан, Гренад, Унгар, Лаос, Нигер, Катар, Хойд Африк, Испани, Уругвай, Тринидад-Тобаго, Бенин, Доминикан, Мьяанмар, Узбекистан; ✓ Бичиг баримтын тоог цөөлсөн: Буркина-Фасо,



МОНГОЛЫН ХУУЛЬ
ЭРХЭМЖИЙН
УДИРДАГА



Хууль сахиулах үйл ажиллагаа

САНХҮҮ	<ul style="list-style-type: none"> - Хуурамч бичиг баримт бүрдүүлж хүн нэвтрүүлэх; - Барааны ангилал, гаалийн үнэлгээ; - Гарал үүслийн улс; - Тариф, татварын чөлөөлөлт; - Шилжих үнэ. 	<p>Камбож, Казахстан, Монтенегро, Руанда, ОХУ, Танзани, Зааны ясан эрэг;</p> <p>✓ Цахим нэг цонхны систем нэвтрүүлсэн: Индонез, Израиль, Мадагаскар, Колумб, Сингапур, Гана, БНСУ, Бенин, Португал, Узбек, Сальвадо, Мексик, Мозамбик, Руанда;</p> <p>✓ Боомтын дэд бүтэц болон үйл ажиллагааг сайжруулсан: Бенин, Төв Африк, Кроата, Ангол, Бахрейн, Bahrain, Кени, Никарагуа, Пакистан, Саудын Араб, Джибути, Вануату, Сенегал, Нидерланд, Уругвай, Бүгд Найрамдах Ардчилсан Сахарын Араб Улс, Бенин, Латви, Гвиней, Казахстан, Алжир, Гана, Йордан, Танзани;</p>
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	<ul style="list-style-type: none"> - Хууль эрх зүйн тогтолцоо; - Боомтын дэд бүтэц хөгжөөгүй; - Удирдлагын арга барил; - Ажилтнуудын чадавхи; - Үйл ажиллагааны давхардал; - Мэдээллийн технологи; - Хязгаарлагдмал нөөц; - Хамтын ажиллагаа хөгжөөгүй; - Үр дүнгүй үйл ажиллагаа... 	<p>✓ Эрсдэл тооцох арга зүйд суурилсан хилийн хяналт: Армян, Гана, Казахстан, Перу, Египет, Кени, Бельги, Тайланд, Хондурас, Иордан, Либери, Марокко, Нигер, Палау, Суринам, Вьетнам, Албани, Камерун, Филиппин, Мавритани, Уругвай;</p> <p>✓ Цахим мэдээлэл солилцох: Чили, Малайз, Словени, Эмират, Болгар, Гамби, Хондурас, Иордан, Либери, Польш, Сан-Томе Принсипи, Сейшель, Сьерра-Леоне, Слован, Танзани, Белиз, Эстони, Турк, Пакистан, Замби, Ботсван, Лаос;</p> <p>✓ Хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлага: Руанда, Замби.</p>

Эх сурвалж: WCO, Annual Report 2013-2014; WB, Doing Business 2011-2015

Дэлхийн Банкны “Бизнес эрхлэхүй” 2012 дүгнэлтийн “Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт”-д оролцсон 183 улсын “130 улс нь цахим хэлбэрээр мэдээлэл солилцдог, 97 улс нь эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, эдгээрээс 49 улс нь 2006 оноос, 31 улс нь бага, дунд орлоготой, 49 улс цахим нэг цонхны системийг нэвтрүүлсэн” (WB, Doing Business 2012) гэж дүгнэжээ.

Улс орнуудын хилийн хяналтын байгууллагууд зөвхөн нэг удирдлага дор үйл ажиллагаа явуулаагүй, харин хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөгжүүлэх замаар улсын хилийн шалган нэвтрүүлэх чадамжийг нэмэгдүүлэн ажиллажээ. Тэд хилийн боомтоор нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд эрсдэл тооцон, өндөр эрсдэл бүхий зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд тавих хяналтыг өндөрсгөн, харин хууль сахилт өндөр зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд тавих хяналтыг хялбаршуулж, уялдуулан ажилласан байна.

Хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагаа Монгол Улсад:

Хилийн боомтын тухай Монгол Улсын хууль 2013 онд батлагдан, 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр Хил хамгаалах ерөнхий газрын “Хилийн шалган нэвтрүүлэх алба”-ны зарим чиг үүрэг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт шилжин, улсын хилийн орох, гарах чиглэлд Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Гаалийн байгууллага, шаардлагатай тохиолдолд Хилийн мэргэжлийн хяналтын шалгалтад хамруулахаар баталжээ. (2016 онд өөрчилсөн)

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хилийн боомтод хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагууд хилийн цогцолборт хамтдаа байрлан өөр өөрийн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Эдгээр байгууллагын үйл ажиллагааг



Хүснэгт 2. Хилийн хяналтын байгууллагын бүтээмж /2006-2015/

уялдуулах гол арга зам нь “Цахим нэг цонх” -ны үйлчилгээнд хамгийн бага зардлаар шилжиж, нэгдсэн мэдээллийн тогтолцоотой болсноор нэг газарт мэдээлэл төвлөрөн, энэхүү мэдээллийн сангаас хилийн хяналтын байгууллага, бусад төрийн байгууллагууд өөрт шаардлагатай мэдээллийг авч, эрсдэл тооцон хяналт тавих боломж бүрдэн, байгууллагын бүтээмж дээшилнэ. Нөгөө талаас төрийн үйлчилгээ хилийн харилцаанд оролцогчдод ил тод, шуурхай байдлаар хүрч, гадаад худалдааны бараа эргэлт түргэсэн, зорчигчдыг хилээр шалган нэвтрүүлэхэд зарцуулах цаг хугацааг бууруулах боломжтой болно.

Хүснэгт 2. Хилийн хяналтын байгууллагын бүтээмж /2006-2015/

Үзлэг	Гадаад худалдаа /сая ам.долл./			Зорчигчийн тоо /мян.хүн/			Нийт тээврийн хэрэгслийн тоо				Ачаа эргэлт /мян.тн/	Гаалийн мэдлэгийн тоо		
	Экспорт	Импорт	Нийт	Гарсан	Орсон	Нийт	Орсон	Гарсан	Нийт	Экспорт		Импорт	Нийт	
2006	1 542	1 435	2 977	1 219	1 152	2 371	338 379	343 298	681 677	19 097	37 541	106 503	144 044	
2007	1 948	2 062	4 009	1 447	1 416	2 863	381 133	360 575	741 708	16 038	30 390	127 634	158 024	
2008	2 535	3 245	5 779	1 527	1 520	3 047	512 010	550 231	1 062 241	13 491	30 802	165 510	196 312	
2009	1 885	2 138	4 023	1 461	1 448	2 909	412 984	398 131	811 115	18 123	34 288	96 494	130 782	
2010	2 909	3 200	6 109	1 847	1 833	3 681	696 452	682 036	1 378 488	53 761	43 769	143 638	187 407	
2011	4 818	6 598	11 416	2 170	2 170	4 340	1 395 413	1 350 925	2 746 338	86 531	64 636	214 187	278 823	
2012	4 385	6 738	11 123	2 257	2 254	4 511	951 916	918 658	1 870 574	53 244	67 428	208 015	275 443	
2013	4 269	6 358	10 627	2 176	2 168	4 344	858 254	852 371	1 710 625	33 119	62 871	201 486	264 357	
2014	5 775	5 237	11 011	2 182	2 173	4 355	946 917	936 246	1 883 163	42 762	224 588	191 133	415 721	
2015	4 670	3 797	8 467	2 444	2 415	4 859	906 086	909 643	1 815 729	35 828	277 842	163 656	441 498	
Дүн	34 733	40 808	75 541	18 731	18 549	37 280	7 399 544	7 302 114	14 701 658	371 994	874 155	1 618 256	2 492 411	

Эх сурвалж: Статистикийн нэгдсэн мэдээллийн сан /2006-2015 он/

Дээрх хүснэгтэд сүүлийн 10 жилд улсын хилээр нэвтэрсэн зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн урсгалыг харьцуулан үзүүлээ. Сүүлийн 10 жилд 37.2, сая зорчигч, 14.7 сая тээврийн хэрэгсэл, 75.54 тэрбум ам.долларын барааг хилийн хяналтын байгууллагууд Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн байна. Уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан 2011 онд улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 2.74 саяд хүрч 86.5 мянган тонн бараа тээвэрлэсэн нь гадаад худалдааны бараа эргэлт 11.41 тэрбум ам.долларт хүрэхэд нөлөөлсөн байна. Харин эдгээрт хяналт тавих хилийн хяналтын байгууллагуудын ажилтны тоо өсөөгүй. Боомтын дэд бүтцийн хувьд ихэнх боомт анхны бүтээн байгуулалтаар ажилласан тухай хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны тайланд дурдсан байна. Монгол Улс, ОХУ-тай байгуулсан гэрээгээр “Алтанбулаг” дахь хилийн боомт 24 цагаар ажиллах болсонтой уялдуулан хилийн боомтын дэд бүтцийг өргөтгөсөн бол Замын-Үүд дэх боомтод ачаа шалгах хяналтын бүсийг шинээр байгуулсан байна. Гэсэн хэдий ч БНХАУ-тай хиллэх хилийн гол боомт болсон Замын-Үүдийн боомтын хилийн шалган нэвтрүүлэх чадамж шаардлагын хэмжээнд ажиллаж чадахгүй байгаа нь хилийн хяналтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна.

Улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд эрсдэл тооцох арга зүйд суурилсан хяналт, шалгалт хийх үйл ажиллагааны дэс дарааллыг хилийн хяналтын байгууллагуудын дэд бүтэцтэй уялдуулан зохион байгуулах ёстой. Хилийн хяналтыг зөв зохион байгуулаагүйгээс үүдэн гарах



эрсдэл нь зөвхөн хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд эрсдэл учруулна. Хилийн хяналтад эрсдэл тооцох боломжийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ач холбогдолтой. Иймд эрсдэл тооцох арга зүйд суурилсан хяналтыг нэвтрүүлсэн туршлагыг хилийн хяналтаар төлөөлүүлэн судаллаа.

Эрсдэл тооцох арга зүйд суурилсан хилийн хяналт: Хилийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллагууд нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад голлох үүрэгтэй. Монголын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг бүхий олон улсын худалдаа ба бизнесийг дагалдсан зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг төрийн зүгээс хянаж зохицуулахад хил хяналтын байгууллага гол үүргийг гүйцэтгэнэ.

Улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг бүгдийг шалгах нь хяналтыг чанартай хийхэд тустай боловч, үйл ажиллагаа давхардах, зардал их гарах эрсдэлийг дагуулна. Харин зарим хэсгийг түүвэрлэн шалгахдаа оновчтой буюу зөвхөн өндөр эрсдэлийг онилон шалгах нь зардлын хувьд хэмнэлттэй, ажиллагаа багатай байхын зэрэгцээ хяналтаа алдахгүй байх боломжийг олгоно. Иймд олон тооны оролцогч бүхий хилийн хяналтын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад хяналтын гол зорилго оршино. Зорилгодоо хүрэхийн тулд эрсдэл тооцох арга зүйн тусламжтай, өндөр эрсдэлийг онилох замаар хэрэгжүүлэх шаардлагатай олон улсын¹ гэрээ, хэлэлцээр, бодлогын бичиг баримтад тусгасан. Өндөр эрсдэлийг онилохдоо хилийн хяналтын эрсдэлийн зэрэглэлийг тодорхойлох шаардлагатай. Хилийн хяналтад хяналт тавих явцад учрах эрсдэлийг олон улсын хэмжээнд болон манай улсын хууль тогтоомжид утга агуулгын хувьд ижил байдлаар тодорхойлжээ.

Энэ нь байгууллагын эрсдэлийг тодорхойлсон олон улсын байгууллага, судлаачдын томъёоллоос нэлээд өөр байгааг анзаарч болно. Тухайлбал, Олон улсын стандартын байгууллагаас гаргасан ISO 31000 стандартад “Эрсдэл бол тодорхойгүй байдлын эерэг эсвэл сөрөг нөлөө” (2009) гэж тодорхойлсон бол эрдэмтэн А.Ганзориг “Эрсдэл гэж урьдчилан тааварлах боломжгүй тохиолдлын шинж чанартай зүйлээс болж, мөнгөн хөрөнгөөр илэрхийлэгдсэн, хүсээгүй, гарч болзошгүй алдагдлыг хэлнэ.” (2014) гэж үзсэн байна.

Хилийн хяналттай холбоотой олон төрлийн эрсдэл нь хилийн хяналтын бусад байгууллагын эрсдэлтэй ижил байдлаар зэрэгцэн оршиж байдаг. Тухайлбал, үндэсний аюулгүй байдал, ургамал, хорио цээр, ажилтнуудын ур чадвар, хяналтын үр дүнгүй тогтолцоо, удирдлагын арга барил зэрэг эрсдэлүүд нь байгууллагын үйл ажиллагаа буюу хяналтын технологи ажиллагаанаас хамаарч үүсдэг ба эрсдэлийг бууруулахад байгууллагын үйл ажиллагааны бүх түвшний оролцоо чухал. Энэхүү онцлогоос нь шалтгаалан хилийн хяналтын үйл ажиллагааг зохицуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, бодлогын бичиг баримт, үндэсний хууль тогтоомжид эрсдэлийг нарийвчлан, ангилж заагаагүй, зөвхөн дурдаж жишээ байдлаар авч үзсэн нь олон тооны оролцогч бүхий үйл ажиллагаа явуулдагтай холбоотой.

¹ “Хяналтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай” конвенцийн 6 дугаар бүлэг. 33 дах тал.



МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
ЗӨРЧИЛ
МАГАДЛАЛ
ТӨСӨӨР
НӨЛӨӨЛӨХ
ЭРСДЭЛИЙН
ЗЭРЭГЛЭЛИЙГ
ИХ,
БАГА,
ДУНД
ГЭЖ
ТОГТООН,
ХИЛИЙН
ХЯНАЛТАД
СӨРГӨӨР
НӨЛӨӨЛӨХ
ЭРСДЭЛИЙГ
ГАРГАНА.

Хилийн хяналтын байгууллагын мэдээллийн урсгалыг нэгтгэх боломж:
Хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг хялбаршуулах, уялдуулахад мэдээллээ нэгтгэн боловсруулах хэрэгцээ, шаардлага гарч ирнэ. Мэдээллийн стратеги нь мэдээлэл боловсруулах эргэх холбооны тусламжтайгаар байгууллага хяналтаа ямар түвшинд хийхийг тодорхойлж, ухаалаг, оновчтой байдлаар хилийн хяналтын эрсдэлийг бууруулж буй арга ажиллагаа юм. Хилийн хяналтын байгууллагуудын давхардсан үйл ажиллагаа нь мэдээллийн давхардлыг үүсгэнэ. Харин хяналтын эрсдэлийг тооцоход мэдээлэл боловсруулах чиглэлээ буруу тодорхойлох нь алдаа дутагдал гарах, хэрэгцээгүй, бэлэн байгаа мэдээллийг боловсруулж цаг хугацаа алдах эрсдэлийг дагуулна. Чиглэлээ зөв тодорхойлсны дараа “Цуглуулах” үе шатанд шилжин, цуглуулсан мэдээллээ нэгтгэх, ангилах, мэдээллээ харьцуулах, харилцан хамаарлаар нь дэс дараалуулан байрлуулах ажилбаруудыг гүйцэтгэнэ. Үүний дараа тухайн эрсдэл гарах магадлал, үр дагавраар нь эрсдэлийн үнэлгээ өгч, түүнд үндэслэн эрсдэлийн зэрэглэлийг их, бага, дунд гэж тогтоон, хилийн хяналтад сөргөөр нөлөөлөх эрсдэлийг гаргана.

Хилийн хяналтын байгууллага улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих явцад олон төрлийн эрсдэлтэй учирдаг тухай өмнө өгүүлсэн. Зарим төрлийн эрсдэл гарах магадлал ховор, эсхүл бага хэдий ч гарсан тохиолдолд үр дагавар нь илүү аюултай байдаг. Тухайлбал, хар тамхи, мансууруулах бодис, оюуны өмчийн зөрчил, зэр зэвсэг, аюултай хог хаягдал, цацраг идэвхит бодис зэрэг эрсдэлийн нийгэмд үзүүлэх хор хохирол их байдаг боловч манай улсад одоогийн байдлаар эдгээртэй холбоотой бүртгэгдсэн зөрчлийн тоо цөөн, бараг байхгүй гэж хэлж болохоор байна. Гэсэн хэдий ч дээрх төрлийн зөрчлийг дагалдан бий болох үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор байнгын хяналтдаа байлгах шаардлагатай болдог. Харин боомт бус газраар барааг хууль бусаар нэвтрүүлэх байсаар байгааг Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны тайлангаас харж болно.

Дүгнэлт

Боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагааг олон улсын түвшинд хүргэх нөхцөл боломжийг тодорхойлох зорилгоор гадаад, дотоод хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийхэд дэлхийн улс орнуудыг айдаст автагдуулж буй улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “хяналтын техник хэрэгслийг түлхүү ашиглах” гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөг тогтсон хэв загвараас гадна гадаад улс орнуудын боомтуудад гарч өнгөрсөн гэмт хэрэг, хууль бус үйлдлийн эсрэг авч хэрэгжүүлсэн жишээг судалж, олон хувилбартайгаар боловсруулж, түүний дагуу дадлагажиж бэлэн байдлыг хангах.

Орчин үеийн олон улсын худалдаанд худалдааг хөнгөвчлөх нь амин чухал асуудал болж хувирсантай холбоотойгоор эрсдэл тооцох арга зүйд суурилсан хилийн хяналт давамгайлах хандлагатай болсон нь дэлхийн улс орнуудын туршлагаар нотлогдож байна. Улсын хилээр нэвтэрч буй зорчигч, бараа, тээврийн хэрэгсэл бүрийн хууль зөрчих магадлалыг нь тооцож, зөвхөн зөрчил гаргах өндөр магадлал бүхий эрсдэлтэй объектуудыг онилсон, оновчтой, ухаалаг

хяналтыг хэрэгжүүлэх нь хилийн хяналтын байгууллагуудын өмнө тавигдаж буй үндсэн зорилт боллоо.

Орчин үеийн техник, технологи, тооцоолон бодох арга зүй ба мэдээллийн системд гарч буй ахиц дэвшил, үүсэн бий болж буй удирдлагын шинэлэг арга барилууд, хувь хүний чадавхад гарч буй өөрчлөлт зэрэг нь байгаа зөв онилсон хяналтыг хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Улмаар эрсдэл өндөртэй зорчигч, барааг онилох замаар хилийн хяналтыг хялбаршуулах боломжийг олгож гадаад худалдааны бараа эргэлтийг хурдасган, улсын хилээр нэвтрэх зорчигчийг түргэн, шуурхай нэвтрүүлэх боломжийг олгоно. Судалгааны ажлын үр дүнг практикт хэрэгжүүлэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хилийн нэгдсэн зохицуулалтыг хилийн хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжийг судлан, зохион байгуулах;
2. Эрсдэл тооцох арга зүйд суурилсан хяналтын үр дүнтэй тогтолцоог бий болгохын тулд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг байгууллагын хөгжлийн стратегитай уялдуулах, стратегийн түвшинд эрсдэлээ удирдах арга барилыг хилийн хяналтын байгууллага бүрийн чиг үүрэгтэй уялдуулах;
3. Дүн шинжилгээний чадварлаг үндэсний багийг бүрдүүлэн, эрсдэлийн шалгуур үзүүлэлт болон байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хилийн боомт бүрээр тодорхойлох;
4. Мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагааг бий болгон, мэдээллийн нэгдсэн кодчиллыг улсын хэмжээнд нэвтрүүлж, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;
5. Хилийн хяналтын байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхийн тулд хүний нөөцийн бодлогод ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг нэвтрүүлэх, урамшууллын тогтолцоог сайжруулах, сахилга хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг ажлыг шат дараатайгаар зохион байгуулах шаардлагатай юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. Д.Амарсайхан, Д.Оюунчимэг. Гаалийн өөрчлөлт-Шинэтгэлийн эргэн тойронд. УБ., 2010.
2. Б.Баттөмөр. Эрсдэлийн менежмент. УБ., 2013.
3. Г.Батхүрэл. Байгууллагын менежментийн онол, арга зүйн асуудал. УБ., 2008.
4. Г.Бат-Эрдэнэ. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт. УБ., 2012.
5. Гаалийн ерөнхий газар. Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам. УБ., 2011.
6. А.Ганзориг. Эрсдэлийн удирдлага. УБ., 2012.
7. Д.Гүргэмжав. Олон улсын худалдаа. УБ., 2000.
8. Ч.Далай. Монголын түүх. Их Монгол Улс. 1206-1260 он. УБ., 2006.
9. Дэлхийн банк. 2011-2015. Бизнес эрхлэхүй дүгнэлт.
10. Д.Моломжамц. Санхүү, Мөнгө-Зээлийн Харилцаа. УБ., 2008.

11. УИХ. "Зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенци"-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай. Төрийн мэдээлэл. УБ., 2007.

12. Анон. Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенци. Женев, 1982.



МОНГОЛЫН
ХУУЛЬ ТАСГАЛЫН
АКАДЕМИ

ХИЛИЙН БООМТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES OF IMPROVING THE CURRENT SITUATION AND LEGAL ENVIRONMENT OF BORDER POINT

Х.Асхар

Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн
Хилийн боомтын аюулгүй байдлын дэд профессор, докторант, хошууч

Askhar Kh.

Major, PhD student, Assistant Professor, Faculty of Border Checkpoint Security,
Border Institute, Law Enforcement University

✉ khadbaatar.d@leu.gov.mn

Товч агуулга: Хилийн боомтын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, Монгол Улсын эдийн засгийн өсөлт, худалдааны эргэлтийг бүс нутаг, улмаар олон улсын хэмжээнд нэмэгдүүлэх, боомтын дэд бүтцийн асуудлыг цогцоор нь хөгжүүлэх буюу зам харилцаа, хилийн боомтын орчныг тохижуулах, тоноглох, хүчин чадлыг нь дээшлүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгамдаж буй асуудлын нэг болоод байна.

Abstract: The advancement of border area legal environment, increase of the economic growth and trade circulation regionally and internationally and establishment of holistic and sophisticated infrastructure (facilitation and furnishing of road, communication and environment and enhance capacity) are the priorities for the border areas.

Түлхүүр үгс: Хилийн боомт, хилийн хяналтын байгууллага, зам, тээвэр, логистик.

Keywords: Border checkpoint, border control authority, transportation and logistics.

Монгол Улсын Их Хурлаар 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шинэчлэн найруулгаар батлагдсан “Монгол Улсын Хилийн тухай хууль”-д /цаашид хилийн тухай хууль гэх/ хилийн аюулгүй байдал, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, “Хилийн боомтын тухай хууль”¹-ийн зарим зүйл заалтуудыг нэгтгэсэн утга, агуулгаараа хилчдийн алба хаах эрх зүйн зэрэг агуулга багтсан байна.

Хилийн тухай хуулийн 3.1.12 дугаар зүйлд хилийн боомт гэж “Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг хэлнэ”² гэж заасан.

Монгол Улсын Засгийн газраас гадаад худалдааг хөнгөвчлөх, стратегийн ач холбогдолтой томоохон орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулан уул уурхайн

¹ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 сарын хуралдаанаар хүчингүйд тооцсон.

² Монгол Улсын Хилийн тухай хууль, 2017 оны 12 сарын 28-ны хуралдаанаар баталсан.



ХХЕГ-ын
 БООМТЫН
 АЮУЛГҮЙ
 БАЙДЛЫН
 ХЭЛСТИЙН
 2016 ОНЫ
 ТАЙЛАН
 МЭДЭЭЛЭЛ

бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын таатай орчныг бүрдүүлэх талаар авч байгаа арга хэмжээтэй холбогдуулан хилийн боомтуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, боомтын дэд бүтэц, барилга байгууламжийг олон улсын жишигт хүргэх, нэвтрүүлэх хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад үе шаттайгаар шилжүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Өнөөгийн байдлаар улсын хилээр жилд дунджаар 4.3 зорчигч, 2.1 сая тээврийн хэрэгсэл /1,6 сая автомашин, 0.5 сая ачааны болон суудлын вагон, 0.06 сая агаарын хөлөг/ нэвтэрч байна. 2016 оны тоон үзүүлэлтийг 2006 онтой харьцуулахад зорчигч 2 дахин, тээврийн хэрэгсэл 67.8 хувь, 2011 онтой харьцуулахад зорчигч 13 хувь, тээврийн хэрэгсэл 20.6 хувиар өссөн байна³.

Энэ тоо баримтаас харахад жил бүр өсөн нэмэгдэх зорчигч, тээврийн хэрэгсэл Монгол Улсын хилийн боомтуудаар нэвтэрч байгаа нь өнөөгийн хилийн боомтуудын хүчин чадал хэр байна вэ? Энэхүү ачааллыг дааж явах нөхцөл бололцоо хэр байна вэ? зэрэг асуултууд ар араасаа гарсаар л байгааг нуух юун билээ.

Монгол Улсын хилийн боомтууд нь 1980-1990-ээд оны үед байсан бүтэц, орон тоогоор ажиллаж байгаа бөгөөд нэвтрүүлэх хүчин чадал нь яг хэвээрээ байна. Тухайн үед Монгол Улсын хилээр нэвтэрч байсан зорчигчдын тоо, тээврийн хэрэгсэл үлэмж бага байсан ба түүндээ тохирсон дэд бүтэц, хүчин чадалтай байсан байжээ. Энгийн нэг жишээ дурдахад 1998 онд өдөрт 200 машин үйлчлэх хүчин чадалтайгаар байгуулагдаж байсан авто замын “Замын Үүд” боомтын цогцолборт өдгөө жирийн үед өдөрт 400-500, томоохон баяр ёслолын өмнө өдөрт 700-800 машин орж, гардаг, ажлын байрны багтаамж хангалттай бус, байцаагч нарын ажлын цагийн ачаалал их, гаалиар нэвтрэх тээврийн хэрэгслүүдэд ялгаа зааг байхгүй, өөрөөр хэлбэл хүн тээвэрлэлт болон ачаа тээвэрлэлтийн гаралт, оролт нэг байдаг ажээ. Энэ нь байцаагчдыг үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг, эмх замбараагүй байдал бий болох нөхцөл, боломжийг бүрдүүлж байна. Түүнчлэн зорчигчдын ачаа, тээшинд үзлэг хийх нөхцөл бүрдээгүй, үзлэг хийсэн барааг тээврийн хэрэгсэлд нь буцаан ачих талаар ямар нэгэн үйлчилгээ хийгддэггүй байна.

Энэ нь үйлчлүүлэгчдийн бухимдлыг төрүүлэх нэгэн шалтгаан болдог. Мөн хилийн цэрэг, гааль, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагууд нь нэг байранд хэтэрхий давчуу байрласнаар өөр өөр чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагын ажилтнуудыг дүрэмт хувцсаар нь л ялгахгүй бол өөр боломж байхгүй байна. Зарим ажилтан стандартын бус нөхцөлд стандартын бус шаардлагыг тавьж ажилладаг. Хилийн цэргийн албан хаагчид, хилийн мэргэжлийн хяналтын байцаагчдын үйл ажиллагааг иргэд ялгахгүй, зөвхөн гаалийн ажилтнуудыг буруутган ойлгож байдаг нь гомдолтой байдгаа илэрхийлдэг байна.

Хилийн боомтын шалган нэвтрүүлэх өнөөгийн хүчин чадал нь жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа ачааллыг даахгүйд хүрч, үүнтэй холбоотойгоор боомтуудад тулгамдаж буй асуудлууд ар араасаа гарч ирэх болсон байна.

³ ХХЕГ-ын Боомтын аюулгүй байдлын хэлстийн 2016 оны тайлан мэдээлэл.



Дүгнэлт хийж судлан үзэхэд хилийн боомтууд дээр сөргөөр нөлөөлж буй дараах чиглэлийн асуудлууд байна гэж дүгнэн үзэж болохоор байна. Үүнд:

- **улсын хилээр нэвтрүүлэх үед үүсэх зорчигч, тээврийн хэрэгслийн бөөгнөрөл.** Энэ асуудал нь хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадал хэрхэн шууд нөлөөлж байгаагийн нэг илрэл гэж үзэж байна. Монгол Улсын эдийн засгийн хөгжил, ялангуяа экспорт импортын өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн хэрэгцээг хилийн боомтуудын дийлэнх хувь нь нэвтрүүлэх хүчин чадлын хувьд хангахгүй байгаагаас албаны үйл ажиллагаа, шалгалтын тоног төхөөрөмжийн хоцрогдол, боомтын бүтэц, орон тооны хүрэлцээгүй байдал зэргээс бөөгнөрөл гэгч нь үүсэх болсон байна.

- **хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны доголдол буюу хүнд суртал.** Хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь өөр өөрийн гэсэн хууль, тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэдэг босоо удирдлагын тогтолцоотой. Хилийн боомтод хяналт, шалгалт явуулах байгууллагуудын үйл ажиллагааг Хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3-д заасныг үндэслэн хилийн боомтод мөрдөх журмыг боловсруулж мөрдлөг болгон зохицуулсан хэдий ч харилцан уялдаа холбоо муу, зарим тохиолдолд зөрчилтэй байгаа нь нэг ижил нөхцөлд ажиллаж байгаа байгууллага, албан хаагчдын харилцан адилгүй ажлын нөхцөл, цалин хангамж, хөнгөлөлт, ахуй хангамж зэргээс харагдаж байна;

- **хилийн боомтуудын зарим барилга байгууламж, дэд бүтцийн асуудал бусдын хараат болсон.** Өөдлөх айл үүднээсээ гэдэг. Тэгэхээр Монгол Улсын үүд, хаалга болсон хилийн боомтууд маань төрийн мэдэлд бус зарим нэг байдлаараа бусдаас хараат болсон явдал. Ялангуяа БНХАУ-тай хиллэх хилийн боомтууд цахилгааны эх үүсвэрээ урд хөршөөс авч байна. Энэ асуудал нь өөрөө бусдаас хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулах гэсэн зарчмыг зөрчиж байна. Зам харгуй, бусад дэд бүтцийн асуудлыг төр өөрөө бус хилийн наана цаана бизнесийн үйл ажиллагаа явуулдаг компаниудад даатгадаг явдал юм. Тийм ч учраас Монголын төр төсвөөсөө мөнгөө гаргадаг, төсвөөсөө хөрөнгө оруулалтаа хийдэг, тэр төсөвтөө орж ирж байгаа мөнгө нь магадгүй компаниудаас, төсөвт аваад буцаагаад төсвөөс санхүүжүүлдэг ийм зарчмаар үйл ажиллагаа явуулж байна. Төрийн энэ том бүтэц өнөөдөр, тэр дундаа энэ эдийн засгийн өсөлтийн үед экспорт, импортын бүтээгдэхүүн нэмэгдэж байгаа, гадаад харилцаа нэмэгдэж байгаа энэ үед бол хэн нэгэн хувь хүн, компани, аль нэг улс орноос хамааралгүй байх тэр бололцоо боломжийг бүрдүүлж өгч чадахгүй байна;

- **хилийн боомтод ажиллагсдын нийгмийн асуудал цогц байдлаар шийдэгдээгүй байгаа.** Хил дээр ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн асуудал маш ихээр хаягдсан байна. Мэдээж тэдний гэр бүлийнхэн мөн адил энэ асуудалд хамаардаг. Сургууль нь хол, цэцэрлэг байхгүй, сургууль завсардах асуудал ихээхэн гардаг байна. Хилийн хяналт, шалгалтын байгууллагын ажиллах нөхцөл, албан хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа ямар нэгэн байдлаар хангагдаагүй байна. Үүнээс үүдэн орон нутгийн засаг захиргаа, хилийн хяналт шалгалтын байгууллагууд хил залгаа улсын аймаг, хошуу болон бусад этгээдийн



ХАМГААГАХ
 ХАМГААГАХ
 ХАМГААГАХ
 ХАМГААГАХ
 ХАМГААГАХ

тусламж, дэмжлэгээр боомтын байр, албан хаагчдын орон сууц зэргийг бариулах, дэд бүтэцгүйн улмаас эрчим хүч импортлон авах, мөн Хятадын талын утасны сүлжээг ашиглан төвтэйгөө холбоо барих зэрэг нь хэвийн үзэгдэл болжээ. Жишээ дурдахад: Бичигт, Шивээхүрэн, Гашуун сухайт, Сүмбэр хилийн боомтуудын шалган нэвтрүүлэх байрыг Хятадын талын тусламжаар бариулсан, мөн Дорнод, Өмнөговь, Сүхбаатар аймгийн нийт 5 хилийн боомтод Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн газрын таван сэндвичин орон сууцыг Хятадын талын тусламжаар бариулсан байна. Тусламжаар бариулсан эдгээр байшин, байгууламж нь чанарын хувьд муу, манай цаг агаарын нөхцөлд тохироогүй, цахилгаан, дулааны асуудал бүрэн шийдэгдээгүй байна⁴.

Иймд төрийн зүгээс хилийн боомтын дэд бүтцийг барьж байгуулах асуудалд нэгдсэн бодлоготой хандаж, улс орны хөгжлийн ойрын болон хэтийн бодлого, байгалийн баялгийн нөөц, боомтын статус, зэрэглэл, бодит ачаалал, хэтийн төлөв зэргийг харгалзан боомтын дэд бүтцийн стандартыг тогтоож, түүнийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг болох, эсхүл боломжгүй тохиолдолд хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалттайгаар эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр бариулах, шаардлагатай эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэх хэрэгтэй байна.

Ашигт малтмалын олборлолт, экспортын хэмжээ үлэмж нэмэгдэж, стратегийн ач холбогдолтой Таван толгой, Оюутолгой зэрэг бусад томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах гэж байгаа зэргийг харгалзан орчин үеийн техник, технологи бүхий нэвтрүүлэх өндөр хүчин чадал бүхий автозам, төмөр замаар тээвэрлэх ачаа болон зорчигчдын хөдөлгөөний урсгалыг төрөлжүүлэн саадгүй нэвтрүүлэх боломжтой, олон улсын жишигт нийцсэн хилийн боомтыг барьж байгуулах, түүнийг дагалдсан жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний бизнесийг хөгжүүлж, боомт дагасан төвлөрлийг бий болгох нь чухал байна.

Төрөөс бодлогын түвшинд дараах баримт бичгүүдэд тусган анхааралдаа авч байгаа нь судалгааны явцад харагдаж байна. Үүнд Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичгийн Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлнэ. I үе шат (2016-2020): Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр логистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа худаг— Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт—Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх”⁵ гэж тусгасан нь төрийн бодлогын түвшинд эхнээсээ биеллээ олж байгаа нь сайшаалтай байгаа ба үүний нэг тод жишээ болох Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудал юм. Энэхүү Монгол Улсад том гэж нэрлэгдэх нисэх буудал 2018 онд үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад зам, тээвэр, логистикийн сүлжээг тэлэх, шинээр байгуулах замаар экспорт, импортын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

⁴ “Хилийн боомтын бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв” ХЗЯ-ны захиалгат судалгааны ажил. УБ., 2012.

⁵ Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичгийн 3-р зорилт.



Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр баримт бичгийн 5.4.14-д "...хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, боомтуудыг холбосон өргөн зурвасын сүлжээнд суурилсан цогц, удирдлага хяналтын систем бий болгох"⁶ гэж оруулсан байна.

Энэхүү бодлогын түвшний асуудал нь дээрх худалдааны эргэлтийг улсын хилээр нэвтрүүлэхэд хилийн боомтуудын чадавх, хүчин чадал ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Мөн түүнчлэн 2015 оны 07 дугаар сард Уфа хотноо гурван улсын төрийн тэргүүн нарын хоёр дах удаагийн дээд хэмжээний уулзалтаар Монголын "Талын зам", Хятадын "Торгоны замын эдийн засгийн бүс" санаачилга, ОХУ-ын "Евроазийн эдийн засгийн холбоо"-г уялдуулан Монгол-Орос-Хятадын "Эдийн засгийн коридор" байгуулах болсноо зарлаж, гурван улсын холбогдох байгууллагууд ажлын хэсэг гарган хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна.

2016 оны 06 дугаар сарын 23-нд гурван улсын төрийн тэргүүн нарын 3 дахь удаагийн дээд хэмжээний уулзалт Узбекистан Улсын нийслэл Ташкент хотноо зохиогдож талууд Монгол-Орос-Хятадын "Эдийн засгийн коридор" байгуулах хөтөлбөрийг баталсан.

Хөтөлбөрт хамтын ажиллагааны чиглэл, зарчим, төслийн санхүүжилт, хэрэгжүүлэх механизмыг тусгасны зэрэгцээ гурван тал хамтран хэрэгжүүлэх төслүүдийг тусгагдсан.

Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь гурван улсын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг өрсөлдөх чадвараар хангах, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэх замаар эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оршиж байна. Хөтөлбөрт хил, гааль, аялал жуулчлал, худалдаа, аж үйлдвэр, эрчим хүч, хил орчмын бүс нутаг хоорондын болон хүрээлэн буй орчны хамгаалал зэрэг хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тохиролцсоны нэг нь тээврийн дэд бүтцийн харилцан уялдаа бүхий хөгжлийг дэмжих зорилт юм.

Эдгээр баримт бичгүүдийг үндэслэн дотоодын хууль тогтоомж, хэм хэмжээний актуудыг яаралтай боловсруулж гаргах, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх нь нэн чухал болоод байна.

Өнөөгийн дэлхийн улс орнуудын хилийн боомтуудын хөгжлийн чиг хандлага, Европын холбоонд элссэн 35 орны мөрдөж буй "Улсын хилийн тухай Шингэний хууль", Словени Улсын "Улсын хилийн хяналт шалгалтын тухай", Украин Улсын "Хилийн хяналт шалгалтын тухай", ОХУ-ын "Хилийн боомтын тухай" хуулиуд, Казахстан Улсын "Хилийн хяналт шалгалт явуулахад боомтын барилга байгууламжид тавигдах стандарт шаардлага", ОХУ-ын "Хилийн боомтод гаалийн хяналт шалгалт явуулахад барилга байгууламж, тоног төхөөрөмжид тавигдах стандарт шаардлага", хилийн боомтуудыг хариуцаж, захиргааны удирдлага хэрэгжүүлдэг "Росграница" агентлагийн эрх зүйн орчин, байгууллагын бүтэц, орон тоо, эрх үүргийг тусгасан баримт бичгүүдийг судалж үзэх явцад хилийн боомтуудыг байршлаас нь хамааран шинээр байгуулах, тэдгээрийн онцлог, эерэг сөрөг тал, хилийн боомтуудыг хамтран ашиглахад засгийн газар

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр баримт бичиг.

хоорондын байгуулах хэлэлцээрийн баримт бичгийн агуулгад юу туссан байхыг зааж өгсөн байна⁷.

Илтгэлийн гол үзэл санаа, дэвшүүлж буй асуудлаар хилийн боомтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулах, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд хүргэх талаар дараах асуудлыг дэвшүүлж байна. Үүнд:

✓ Хилийн боомтод төрийн үүргээ гүйцэтгэж байгаа хилийн шалган нэвтрүүлэх алба, гааль, хилийн мэргэжлийн хяналт болон гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагуудын чиг үүрэг, харилцан ажиллах журмыг нэгдсэн бодлогын түвшинд өөр өөрийн байгууллагын мөрдлөг болгон хэрэгжүүлэх эрх зүйн хэм хэмжээний актуудад тусгах;

✓ Улс орныг хөгжүүлэх, гадаад худалдааг идэвхжүүлэх “хаалга” болсон хилийн боомтуудад олон улсын стандарт, шаардлагад нийцсэн хяналт, шалгалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэвтрүүлэх, суурилуулах, сайжруулах, тэдгээрийн болон боомтын барилга, байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах боомтын ашиглалтын захиргааны байгууллагыг хоёр хөрш орны адил бий болгож, Засгийн газрын харьяа агентлагийн түвшинд байхаар эрх зүйн зохицуулалт хийх;

✓ Хилийн хяналт, шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, тэдгээрийн үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн албан хаагчдын хилийн боомтод ажиллаж амьдрах нөхцөлийг дээшлүүлэх, тэдэнд адил тэгш хөдөлмөрийн цалин хөлс, нийгмийн хамгааллын баталгаагаар хангах нэгдсэн бодлого чиглэлийг холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах;

✓ Хилийн боомтод ажиллагсдын нийгмийн асуудал шийдэгдээгүй маш ихээр хаягдсан байна. Мэдээж тэдний гэр бүлийнхэн мөн адил энэ асуудалд хамаардаг. Сургууль нь хол, цэцэрлэг байхгүй, сургууль завсардах асуудал ихээхэн гардаг байна. Хилийн хяналт, шалгалтын байгууллагын ажиллах нөхцөл, албан хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа ямар нэгэн байдлаар хангагдаагүй байна. Энэ асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх талаар хилийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудад тодорхой заалтуудыг нэмж оруулах;

✓ Сүүлийн үед харьцангуй хөгжилтэй улс орнууд өндөр техник технологи дээр тулгуурлан бичиг баримтын нууцлалыг нарийвчлан шалгах, бичиг баримтад тухайн эзэмшигчийн тодорхой мэдээллийг агуулсан чипийг байрлуулж, улсын хилээр нэвтрэх үед нь мэдээллийн нэгдсэн сүлжээнээс эзэмшигчийн баримт бичиг мөн эсэхийг батлах, тухайн хүнийг биометрийн багаж ашиглан нэмж тодотгох зэрэг шинэ хяналт шалгалтын арга ажиллагаанд аль хэдийн шилжин орсон байна. Иймд шинэ дэвшилтэд техник технологийг хилийн боомтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх зайлшгүй шаардлага гарч байгаа учир төрийн нэгдсэн бодлогын хүрээнд зохицуулалт хийж өгөх. Өнөөдрийн байдлаар улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг бүртгэх, хяналт шалгалт хийх, мэдээллийн нэгдсэн

⁷ “Хилийн боомтын бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв” ХЗЯ-ны захиалгат судалгааны ажил, 2012 он, УБ хот.



МОНГОЛЫН
ХУУЛЬ
ЭРХ
ЗҮЙН
ТӨЛӨӨ
ХАМГААЛАХ
ЯМАН



санг бүрдүүлэх программ хангамжийн шинэчлэлийг гадаадын олон улсын байгууллагын төсөлт ажлаар хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь өөрөө бусдаас хараат болох нөхцөл боломжийг бүрдүүлж байна гэж үзэж байна. Харин энэ байдлыг халж, өөрийн дотоод нөөц боломжийг түлхүү ашиглах явдал дутагдаж байгаад анхаарах;

✓ Хилийн боомтыг дагалдан бий болох хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боомт бүрээр шинэчлэн боловсруулж, түүнд инженерийн дэд бүтцэд орох ус, цахилгаан, дулааны хангамжийн найдвартай эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, гол зам, холбоожуулалтын талаар тусгах.

Хилийн боомтуудыг олон улсын болон Монгол Улсын авто ба төмөр зам, тээврийн сүлжээнд холбох асуудлыг одоогийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийх бүрэн боломжтой ч энэ ажлыг эрс эрчимжүүлэхийг улсын эдийн засаг, уул уурхайн өсөн нэмэгдэж буй экспорт, импортын бүтээгдэхүүний эргэлт шаардаж байна.

Дүгнэлт

Дээрх дурдагдсан бүх нөхцөл байдалд тулгуурлан дүгнэхэд хилийн боомтын эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, хилийн боомтын нэгдсэн бодлого, стандарттай болох, боомтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, боомтуудыг нэг урсгалтай бус хоёр урсгалтай болгох, боомтын дэд бүтцэд хамаарах автозам, эрчим хүч, усны болон цахилгааны хангамж зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, хүн ам төвлөрсөн, дэд бүтэц хөгжсөн, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжтой суурин газар болгох зэрэг асуудлыг судлан үзэж, хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах бодит хэрэгцээ, шаардлага байгааг судлаач миний хувьд үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.
3. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ., 2002.
4. Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 1993.
5. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 сарын хуралдааны тэмдэглэл, № 151.
6. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичиг.
7. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр баримт бичиг.
8. "Хилийн боомтын бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв" ХЗЯ-ны захиалгат судалгааны ажил. УБ., 2012.
9. ХХЕГ-ын Боомтын аюулгүй байдлын хэлтсийн 2017 оны тайлан мэдээлэл.

ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АШИГЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

THEORY AND RESEARCH BASIS TO APPLY DIPLOMATIC ACTION IN ENSURING BORDER SECURITY



Б.Аманбек

Хууль сахиулахын их сургуулийн докторант, дэд хурандаа

Amanbek B.

Lieutenant Colonel, PhD Student, Law Enforcement University

✉ b_amanbek@yahoo.com

Товч агуулга: Улс орны тусгаар тогтнолыг бэхжүүлэх, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хангах, тэдгээрт учирч болзошгүй аюул, заналыг арилгах нь дипломат ажиллагааны гол зорилт юм.

Abstract: Strengthening the nation's independence, ensuring the interest of the state, society and citizens in the territory and neighbourhood of the state border and protecting from any expected threats are the basis to diplomatic action.

Түлхүүр үгс: Үндэсний аюулгүй байдал, хилийн аюулгүй байдал, улсын хил, олон улсын эрх зүй, дипломат ажиллагаа.

Keywords: National security, state border, border security, international law, diplomatic action.

Оршил

Аливаа улс орон улсынхаа хилийг бодит байдлаар болон олон улсын эрх зүйгээр баталгаажуулдаг. Олон улсын эрх зүйгээр баталгаажсан хил нь тухайн улсын тусгаар тогтнолын бат илэрхийлэл мөн боловч түүний аюулгүй байдал нь бүрэн дүүрэн хангагдсан гэсэн ойлголт хараахан биш юм.

Энэ нь орчин үед дэлхий нийтийг хамарсан үйл явц болох даяарчлалын үр дагавар, нөлөөгөөр улс дамнасан терроризм, халдварт өвчний тархалт, байгалийн гамшиг, улсын хил давуулан хар тамхи, цөмийн болон химийн зэвсгийн түүхий эд, зэвсэг, хүн наймаалах, бохир мөнгө угаах, хил дамнасан гэмт хэргийн элементүүд нарийн зохион байгуулалттай болж улс орнуудад аюул занал учруулж байгаагаар илэрдэг.

НҮБ-ийн тайлан илтгэлд: “Өнөөдрийн аюул заналхийлэл нь зөвхөн нэг улсын хилээр хязгаарлагдахгүй харилцан хамаарал сүлжээтэй бөгөөд түүнд дэлхий нийт, бүс нутгийн төдийгүй олон улсын хүчин чармайлт хэрэгтэй байна. Хичнээн хүчирхэг гүрэн байсан ч нэг улс орон энэхүү аюул заналаас өөрийгөө бие даан хамгаалахад хүчин мөхөстөж байна”¹ гэж онцлон тэмдэглэсэн.

Энэ ч утгаараа Монгол Улс дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан аюулгүй байдлын

¹ Ж.Энхбаяр. Аюулгүй байдлын олон талт асуудал. УБ., 2007. 1 дэх тал.



хамтын ажиллагааг хангах гадаад бодлого баримталж байгаа төдийгүй хөрш орнуудтайгаа найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх нь төрийн гадаад бодлогын эн тэргүүний зорилт хэмээн тунхагласан.

Энэхүү бодлогын хүрээнд хөрш орнуудтайгаа харилцан итгэлцэл, ойлголцлын үндсэн дээр “нэг хил, хоёр улс” зарчимд тулгуурлан улсын хилийн аюулгүй байдлыг хамтран хангах асуудал чухлаар тавигдаж байна.

Монгол Улс хилийн аюулгүй байдлыг хамтран хангах асуудлаар ОХУ, БНХАУ-тай “...Найрсаг хамтран ажиллах үзэл санааны дагуу улсын хилийг хамтран хамгаалах, өнө мөнхөд энх тайван, найрсаг харилцааны хил байлгахын төлөө хүчин чармайлт гаргаж ажиллахаа илэрхийлж”² хилийн дэглэмийн болон холбогдох бусад гэрээ, хэлэлцээр байгуулсан.

Монгол Улсын ИХ Хурал 2016 онд хилийн тухай хуулийг шинэчлэн батлахдаа “Хилийн аюулгүй байдал”-ын асуудлыг анх удаа хуульчилсан ба “...төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаа”³-ны үр дүнд хилийн аюулгүй байдал хангагдана гэж тодорхойлсон.

Иймд Монгол Улс тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, улсын хил, хязгаар нутгийн аюулгүй байдлыг хангахад дипломатын ажиллагааг урьтал болгох, түүний үр нөлөөг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Дипломат ажиллагаа ба Хилийн аюулгүй байдал

Монгол Улс их гүрнүүдийн геополитик, эдийн засгийн ашиг сонирхлын уулзвар дээр гео-стратегийн хувьд чухал бүсэд оршдог нь нэг талаас хөгжлийн ихээхэн боломж олгодог ч нөгөө талаас манай улсын үндэсний аюулгүй байдлыг эмзэг болгох магадлалтай юм.

Хөршийг сонгодоггүй гэж эртний мэргэн үг байдаг. Тийм болохоор түүхэн хувь заяагаар Монгол Улс хойд талдаа ОХУ, өмнөд талдаа БНХАУ-тай хөрш болсон далайд гарцгүй улс юм. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд хөрш хоёр гүрэн, тэдгээрийн дотоод, гадаад байдал шууд нөлөөлдөг⁴ гэдэгтэй ихэнх судлаачид санал нэгтэй байдаг.

Иймд хөгжил буурай, хөгжиж буй эдийн засагтай, хөршүүдээсээ эдийн засгийн хувьд хэт хараат байдалтай орны хувьд цэрэг стратегийн хүчний хамгийн их төвлөрөлтэй бүс нутагт, улам бүр хүчирхэгжиж байгаа хоёр том гүрний дунд хавчуулагдан орших Монгол Улсыг геополитикийн хувьд жижиг улс гэсэн ангилалд зүй ёсоор хамруулж байдаг⁵. Энэ нөхцөлд Хятадын нэрт жанжин Сунь-цзыгийн “хүчээр хамгаалж чадахгүй бол аргаар хамгаал” гэж хэлсэнчлэн манай улс Үндэсний аюулгүй байдлаа хангахын тулд оновчтой дипломат ажиллагаа явуулах нь зүйтэй юм.

² Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн Газар, БНХАУ-ын Засгийн Газар хоорондын гэрээ. УБ., 2011.

³ Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2016.

⁴ Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. УБ., 2010. №14(24). 45 дах тал.

⁵ Үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах нь. Эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2010. 129 дах тал.



ӨНДӨН
 ХУРААН
 ГЭНЭ
 2010

Үүний эрх зүйн үндсийг Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах...” нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт байна гэж заасан.

Мөн түүнчлэн аюулгүй байдлыг хангах дипломат ажиллагаа тухайн орны батлан хамгаалах бодлоготой холбоотой байдгийн хувьд “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-д “Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр, дипломатын аргыг урьтал болгох” арга хэмжээ авч хэрэгжүүлэхээ тодорхойлсон.

Дипломат ажиллагааны тухай Монголын ууган дипломатуудын нэг судлаач М.Дүгэрсүрэн өгүүлэхдээ:

- а) улс гүрний хоорондын харилцааны хэрэглүүр болдог
- б) харилцаанд хүч хэрэглэхийг орлох, халах, өөрөөр хэлбэл эв зүйгээр явуулах арга болдог
- в) дипломат ажиллагаа ОУЭЗ-д үндэслэн явагдана хэмээн түүний үндсэн шинж чанаруудыг заасан бөгөөд эдгээрээс үндэслэн “олон улсын харилцааг хүч хэрэглэх замаар биш хэлэлцээ зэрэг эв зүйн аргаар ОУЭЗ-н дагуу явуулахыг дипломат ажиллагаа” гэнэ хэмээн тодорхойлж болох юм⁶.

Дипломат ажиллагаа гэдгийг Британника нэвтэрхий тольд “олон улсын харилцааг явуулах арга” ...“хүч хэрэглэхгүйгээр улс үндэстэнд туйлын таатай нөхцөл бүрдүүлэх хэрэглүүр” гэж заажээ.

Монголын дипломат нэвтэрхий тольд “Дипломат ажиллагаа гэж улс орны гадаад бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл буюу төр засаг, ГХЯ, гадаад харилцааны байгууллага, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарын албан ёсны үйл ажиллагаа, улс орны гадаад бодлогын зорилго, зорилтыг шийдвэрлэхээр олон улсын хуралд оролцож буй төлөөлөгчийн үйл ажиллагааг тусган тооцож, улс орон түүний байгууллагууд болон иргэдийн ашиг сонирхлыг хамгаалахад хэрэглэдэг цэргийн бус бодит (практик) арга хэмжээ, арга барил, аргачлалын цогц” хэмээн тодорхойлсон.

Дипломат ажиллагаа бол гадаад бодлогын зорилгыг хэлэлцэн тохиролцох, зөвшилцөх замаар хэрэгжүүлэх арга юм. Гадаад бодлогыг стратеги гэж томъёолбол, дипломат ажиллагаа нь тактикийн чиг шугам, арга барил нь гэж хэлж болох юм. Дипломат ажиллагааны гол зорилго нь энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалахад⁷ оршиж байдаг. Тухайлбал Харвардын их сургуулийн профессор Жозеф С.Най (Jozef S.Nye) “аливаа улс орон “Зөөлөн хүч”(soft power)-тэй байгаагийн нэг илрэл нь дипломат бодлого нь хүчтэй байна⁸” гэж үздэг.

Дипломат ажиллагааны гол зорилт бол улс орныхоо болон ард иргэдийнхээ язгуур, эрх ашгийг хамгаалах явдал юм. Үүнийг ойлгохын тулд

⁶ Д.Цолмон, Д.Оюунсүрэн, Д.Баясгалан. Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс. УБ., 2009. 13 дах тал.

⁷ Мөн тэнд. 5 дах тал.

⁸ Стратеги судлал сэтгүүл. УБ., 2010. №51. 39 дах тал.



Английн ерөнхий сайд асан нэрт дипломатч Лорд Пальмерстон: “Англи улсад мөнхийн дайсан ч байхгүй, мөнхийн анд ч байхгүй. Харин түүнд гагцхүү эрх ашиг л бий” гэж хэлсэн нь дээрх санааг давхар баталж байна.

Орчин үеийн дипломат ажиллагааны үндэс нь асуудлыг эв зүй, хэлэлцээний аргаар шийдвэрлэх хүсэл, зориг эрмэлзэл байх ёстой. Хамгийн чухал нь дипломат ажиллагаа ОУЭЗ-н үндсэн зарчмууд, НҮБ-ын дүрмийн зорилгыг эрхэмлэн сахих учиртай бөгөөд дипломат ажиллагаа, консулын харилцааны түгээмэл болоод тусгай эрх зүйн зохицуулалт “Дипломат харилцааны тухай” 1961 оны болон “Консулын харилцааны тухай” 1963 оны Венийн конвенцуудад тусгалаа олсон байдаг.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын ажиллагаа байна⁹. Орос, Хятад хоёр том хөрштэйгөө хилээ тодорхой тогтоосон явдал нь манай улс бүс нутагтаа газар нутгийн маргаангүй цорын ганц улс болохын хувьд хилийн аюулгүй байдлыг хангахад дипломат аргыг тэргүүлэх чиглэл болгох бодлого баримталж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах дипломат бодлого нь ч, үйл ажиллагаа нь ч тэр Монгол Улсын дипломатын бодлогын үргэлжлэл бөгөөд төрийн дипломат албаны нэгээхэн хэсэг байдаг. Тухайлбал, төр, засгийн бодлогоос гадуур биеэ даасан аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа гэж байхгүй, байх ч ёсгүй. Хилийн аюулгүй байдлын бодлого нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлогын нэгэн хэсэг байдаг бол түүнийг хангах дипломат бодлого нь Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлын үзэл санаа, хууль тогтоомжтой яв цав нийцэж байх шаардлагатай.

Иймд ч Хилийн тухай хуулийн 5.3-зүйлд: “Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана” гэж шинээр тодорхойлсон.

Хилийн аюулгүй байдлыг хангах дипломат ажиллагааг доктор Ш.Арвай “улсын хилийн баталгаажилт, хил болон хилийн орон зайд аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн хүлээн зөвшөөрсөн эрх зүйн баримт бичгийг үндэслэн гадаад бодлогын зарчмуудад тулгуурлан, төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, ялангуяа хил хамгаалах байгууллагаас олон улсын хэмжээнд яриа хэлэлцээ, гэрээний хэлбэрээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм”¹⁰ гэж үзсэн.

Миний хувьд хилийн аюулгүй байдлыг хангах дипломат ажиллагааг “улсын хилийг баталгаажуулах, хамгаалах тухай Монгол Улсын болон Олон улсын эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хөрш зэргэлдээ болон бусад улсуудтай хилийн аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааг хөгжүүлэх, хилийн асуудлыг энхийн аргаар зохицуулах

⁹ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2010. №36. 10 дах тал.

¹⁰ Ш.Арвай. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. 2005. 186 дах тал.



МОНГОЛ
УЛСЫН
ХАМГААЛАХ
БАЙГУУЛЛАГААНЫ
ДИПЛОМАТЫН
АЖИЛЛАГААНЫ
УРСАМЖ

зорилгоор Монгол Улсын төр, хил хамгаалах байгууллагаас явуулж буй арга хэмжээ, арга барил, аргачлалын цогц” гэж үзэж байна.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах дипломатын ажиллагаа нь Монгол улсын Үндсэн хуулийн “Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Улсын хил халдашгүй дархан байна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх олон улсын /гадаад/ болон дотоодын эрх зүй орчинг бүрдүүлэх, олон улсын гэрээгээр тодорхойлон тогтоон тэмдэглэсэн хилийг бүрэн бүтэн дэглэмтэй байлгах, хил залгаа улс хоорондын байгуулсан хилийн дэглэмийг сахиулах, хил хамгаалах эрх ашигт нийцүүлэн тогтоосон хилийн зурвас, бүс, хилийн боомтын журам/хил орчмын дэглэм/-ын биелэлтэд хяналт тавих ажиллагааны нэгдэл болно.

Хилийн аюулгүй байдлыг хангах дипломатын ажиллагааны зарчим нь цэрэг улс төрийн байдлыг тодорхой мэдэж байх, адил тэгш эрх эдлэх, асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх, хил, түүний хамгаалалт үр ашигтай байх, санаачилгыг гартаа авч байх, үнэн зөв өргөн мэдээлэлд тулгуурлахад үндэслэгдэнэ.

Түүний үндсэн зорилт нь улсын хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашигт учрах аюул заналаас урьдчилан сэргийлэх тул эсрэг талаас улсын хилийн баталгаажилт, хилийн дэглэмийн талаар хүлээсэн үүргийг нөгөө талаас чанд биелүүлэхийг шаардах, хилийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэх олон талт хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлж сайн хөршийн найрамдалт харилцааг бэхжүүлэх, ялангуяа хил хамгаалалтын техник, технологийг шинэчлэх чиглэлээр олон улсын дэмжлэг тусламжийг авах зэрэг дипломатын аргуудыг голчлон хэрэглэхэд чиглэгдэх нь зүйтэй юм.

Хөрш оронтой найрсаг харилцаатай байх нь хилийн аливаа зөрчлийг тэдний хил хамгаалах байгууллагатай хамтран хилчдийн хэмжээнд шийдвэрлэж будлиан, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлж чаддаг бол, хөрш оронтойгоо хүйтэн хөндий, үл ойлголцсон харилцаатай байх нь улсын хил, түүний орчимд аюул занал, түгшүүртэй байдлыг бий болгож, зэвсэгт мөргөлдөөн, тулгаралтанд хүрч хүн хүч, эд материалын үлэмж хохирлыг хүлээж байдаг.

Хилийн аюулгүй байдлыг дипломат ажиллагаагаар хангах үндэслэл

Дипломат ажиллагаагаар улсын хил, түүний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлаар олон улсын хэмжээнд дэлхийн II дайнаас хойш НҮБ-ын “Итгэлцлийн Зөвлөл” (Trusteeship Council) газар нутгийг олон улсын эрх зүйн хүрээнд хувиарлан шийдвэрлэснээс хойш ихэнх орнуудын газар нутгаа тэлэх тухай ойлголт хумигдан хил хязгаараа зөрчил маргаангүй байлгах, түүнийг тодорхой болгох, олон улсын хэмжээнд баталгаажуулах, хил хязгаарын аюулгүй байдлаа хангахад илүүтэй анхаарч байна.

Үүний нэг тод жишээ нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны хүрээнд “Хилийн аюулгүй байдал, удирдлагын зарчим” баримт бичгийг Хельсинкийн уулзалтаар батлан хилийн асуудлаар энэхүү баримт бичгийг дэлхийн, ЕАБХАБ-ын болон хөрш орнуудын хэмжээнд хэрхэн ажиллах талаар тохиролцсон асуудал нь хилийн аюулгүй байдлыг хангах дипломатын ажиллагааны олон улсын жишиг, эрх зүйн орчны үндэс болж байна.



Мөн Монгол-Орос, Монгол-Хятадын хооронд улсын хилийг гэрээгээр тогтоон тэмдэглэн баталгаажуулж, мөрдөх дэглэмтэй болсон нь улсын хилийн аюулгүй байдлыг цэргийн аргаар дагнан хамгаалж байсан тогтолцоонд өөрчлөлт оруулан дипломатын аргыг ашиглах олон улсын эрх зүйн орчинг бүрдүүлсэн туршлага юм.

Өнөөдөр хилийн аюулгүй байдлыг хангах дипломатын ажиллагаа нь олон улсын нийтлэг жишгийн дагуух дипломат ажиллагаан дээр тулгуурлан явагдаж байна. Үүний нэг нотолгоо нь хил залгаа улстай хилийн дэглэмийн гэрээ байгуулан хилийн асуудлыг зохицуулж байгаа төдийгүй хамтарч гуравдагч этгээдийн хууль бус үйл ажиллагаатай тэмцэх талаар цаашид хөгжих чиг хандлагаар илэрч байна.

Энэ нь хил дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй тэмцэх явдал олон улсын хэмжээнд чухлаар тавигдан уламжлалт бус аюул "даяарчлалын 5 аюул" /хил дамнуулан хүн, зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис наймаалах, мөнгө угаах, оюуны өмч хулгайлах/ хэмээн нэрлэгдэж буй гэмт үйлдэл нь хил дамнасан гэдэг утгаараа нэг улс эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэрлэх боломжгүй тул олон улсын хамтын ажиллагааг шаардаж 1994 онд Монгол-Оросын хооронд "Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд хилийн асуудлаар хамтран ажиллах гэрээ", 1999 онд Монгол Улсын ХЦУГ, БНХАУ-ын БХЯ-ны хооронд "Хил хамгаалалтын талаар хамтран ажиллах хэлэлцээр" байгуулагдсан зэргээр нотлогдож байна.

Өнөөдөр хилийн аюулгүй байдлыг дипломат ажиллагаагаар хангах хүрээнд дараах субъектууд чиг үүрэг хүлээж байна. Үүнд:

1. Төрийн эрх барих дээд байгууллага /УИХ/:
 - а/Улсын хилийг тодорхойлох, тогтоох, өөрчлөх асуудлыг шийдвэрлэх;
 - б/Хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах;
2. Монгол Улсын Засгийн газар:
 - а/ Улсын хилийг хамтран шалгаж баталгаажуулах;
Хөрш улсуудын хооронд байгуулсан гэрээний дагуу газар орон дээр тогтоогдсон хилийг хилийн дэглэмийн гэрээнд заасан тодорхой хугацаанд хилийн нийт шугамын дагуу эсвэл тодорхой хэсэгт хамтарсан шалгалт хийж хилийн шугамаа тодотгодог. Тухайлбал, Монгол Улс ОХУ-тай 1987-1995, 2005-2007 онд, БНХАУ-тай 1982-1984, 2001-2003 онд тус тус хилийн шугамыг хамтран шалгаж тодотгосон.
 - б/ Хилийн асуудлаар хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон гэрээ, хэлэлцээр байгуулах;
3. Яамдын /ТЗТБ/хүрээнд:
 - а) Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:
ОХУ, БНХАУ болон бусад цэрэг-техникийн хамтын ажиллагаатай улс орнуудаас хил хамгаалалтын зэвсэглэл, техник тусламжаар авах харилцааг хөгжүүлж, өргөжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж байна.



б) Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

- Хил хамгаалах байгууллагыг захиргааны удирдлагаар хангах;
- Хил хамгаалах байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;

в) Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хилийн аюулгүй байдлыг дипломат ажиллагаагаар хангахад чухал үүрэг хүлээдэг. Тухайлбал хилийн орон зайд Монгол Улсын ашиг сонирхлыг хангах гадаад таатай нөхцөл бүрдүүлэхэд хөрш улсад дипломат аргаар нөлөөлөх ёстой. Өнөөдөр дараах үүргүүдийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн хилийн асуудлаар байгуулах олон улсын гэрээ, хэлэлцээрийг бэлтгэн байгуулж, түүний биелэлтэд хяналт тавьж байна. Тухайлбал ОХУ-тай Хил орчмын хамтын ажиллагааны тухай ерөнхий Хэлэлцээрийг 2000 онд байгуулж, түүний дагуу хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малыг буцааж өгч байх асуудлаар хамтарсан комисс байгуулан ажиллуулснаар хил дамнасан малын хулгайн хэрэг буурч байгаа нь үүний нэг илрэл юм.
- Улсын хилийн аюулгүй байдлын гадаад улс төрийн болон олон улсын эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх;

Хилийн харилцааны хүрээнд 1998 оноос Монгол Улс, ОХУ Элчин сайдын яамдад Хилийн албан ёсны төлөөлөгч харилцан суулгаж ажиллуулсан нь Хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хилийн асуудлыг шуурхай шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой болсон. Цаашид үүнийг БНХАУ-д суугаа элчин сайдын яаманд суулгахаар манай улс хүчин чармайлт гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

- хилийн төлөөлөгчийн шугамаар шийдвэрлэж чадаагүй асуудлыг зохицуулах зэрэг болно.

4. Хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны төв байгууллага:

а/ Монгол Улсын Олон Улсын гэрээнд хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

Энэ зорилгоор улсын хилийн бүс, зурваст хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааг хослуулан явуулж байна.

б/ Хилийн аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр гадаад харилцааг идэвхтэй явуулж байна.

Энэ хүрээнд ОХУ-ын ХАБ-ын хилийн алба, БНХАУ-ын ХАЧА болон НАХЯ-ны ХЦУГ, Энэтхэг улсын ХАБ-ын хүчин, Энэтхэг–Түвдийн хилийн цагдаагийн хүчин, БНКаЗУ-ын ҮАБ-ын хорооны хилийн алба, АНУ-тай аюулгүй байдлын чиглэлээр /Жорж маршалын аюулгүй байдлын академи/ хамтын ажиллагаатай байна. Мөн ХХБ-ын боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр ОХУ, БНХАУ, АНУ, Энэтхэг, Герман, Казахстан, Тажикстан зэрэг улсуудад офицер, ахлагч нарыг сурган бэлтгэж байна.



Мөн Венгри улсын нийслэл Будапешт хотод төвтэй олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдалд тулгарч буй сорилтуудтай тэмцэх чиглэлээр харилцан мэдээлэл, туршлага солилцох, судлах, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал индэр нэгэнт болж чадсан Олон улсын хилийн албадын бага хуралд 2003 онд ажиглагчаар, 2004 оноос албан ёсны оролцогч орны статустай оролцож эхэлсэн. 2010 оны XVIII дахь удаагийн хуралдаанд 57 орон, арав гаруй олон улсын байгууллагын 150 гаруй төлөөлөгч оролцсон нь уг байгууллагын цар хүрээ улам өргөжиж, ач холбогдол нэмэгдэж байгааг харуулсан бөгөөд хуралдаанаар “Хууль бус цагаачлалтай тэмцэх”, “Эргийн хамгаалалт”, “Хилийн албадын хамтын ажиллагаа”, “Визийн журам”, “Хилээр нэвтэрч буй хөдөлгөөн”, “Мэдээлэл цуглуулах” зэрэг сэдвүүдээр хэлэлцсэн байна.

в/ Хилийн төлөөлөгч, орлогчийг томилж, мэргэжлийн удирдлагаар хангах; Өнөөдөр ХХЕГ-т гадаад харилцаа эрхэлсэн нэгж нь захиргааны удирдлагын нэгжид, хилийн төлөөлөгчийн алба хариуцсан нэгж нь цэргийн удирдлагын нэгжид тус тус харьяалагдаж байгаа дипломат ажиллагаа нэгдмэл бодлогоор явагдахад нийцэхгүй бүтэц юм.

Гадаад харилцаа, хилийн төлөөлөгчийн алба нь хоёулаа хилийн аюулгүй байдлыг дипломат ажиллагаагаар хангах нэг хэлбэр бөгөөд, хилийн төлөөлөгчийн ажиллагаагаар цэргийн албаны асуудлыг бус, олон улсын эрх зүйн актуудад тулгуурлан хилийн асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх юм. Түүхэн туршлагаас харахад Хилийн төлөөлөгч нь ХЦ-ийг татан буугдах үед ч байсан бөгөөд 1996-2001 онд бүс нутгийн хилийн төлөөлөгчийг газрыг хилийн тусгай ангиас тусад байгуулж байсан.

Хилийн тухай хуульд хилийн төлөөлөгч, Хил хамгаалах байгууллагын тухай өөр өөр бүлэгт хуульчилан заасан болон хилийн дэглэмийн тухай гэрээнд: “Эрх бүхий байгууллага” гэж Монгол Улс, ОХУ-ын хилийн бүрэн эрхт төлөөлөгчид болон тэдгээрийн орлогчид¹¹, “Хил хамгаалах байгууллага” гэж Улсын хилийг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх, улсын хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомтоор нэвтрэх журмыг хувь хүн болон хуулийн этгээдүүдээр сахиулан хангах¹² гэж тус тус зааглан ялгасан заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуульд Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь хойшлуулшгүй ажиллагаа явуулах, зөрчил хянан шийдвэрлэх эрхтэй зэрэг үндэслэлүүд нь:

1 дүгээрт: Гадаад харилцаа, хилийн төлөөлөгчийн алба нь нэг бүтцийн нэгжид байх;

2 дугаарт: Энэ бүтцийн нэгж нь захиргааны удирдлагад байх хамаарлыг нотлож байна.

5. Хилийн /бүрэн эрхт/ төлөөлөгч:

Хилийн төлөөлөгчийн алба нь дипломат харилцааны салшгүй хэсэг бөгөөд хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээг хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн зөрчлөөс урьдчилан

¹¹ Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ. УБ., 2007. 3 дах тал.

¹² Мөн тэнд.



ХИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
 ҮЙЛ АЖИЛЛАГАА

сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх¹³ зорилготой бөгөөд улс орны эрх ашгийг улсын хил дээр хамгаалах дипломат аргын нэг хэлбэр юм.

Хилийн төлөөлөгч нь хилийн асуудлыг Монгол улсын эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх хариуцлагатай үүрэг гүйцэтгэж, үйл ажиллагаагаа дипломат аргаар явуулж буй Хил хамгаалах байгууллагаас тусгайлан томилогдсон онцгой эрх бүхий албан тушаалтан бөгөөд үйл ажиллагаандаа олон улсын эрх зүй, хоёр улсын хэлэлцээр, дотоодын хууль дүрмийг мөрдлөг болгодог.

Аливаа асуудлыг цэрэг зэвсгийн хүчээр бус, дипломатын аргаар, хэлэлцээр зөвшилцлөөр шийдвэрлэх арга давамгайлах болсон өнөөгийн нөхцөлд улсын хилийн дэглэмийг сахиулах, хилийн зөрчил будлианыг шийдвэрлэн зохицуулахад Монгол Улсын хилийн төлөөлөгчийн үүрэг асар их юм. Хилийн төлөөлөгч нь тодорхой хариуцсан хэсэг дээрээ үйл ажиллагаа явуулах боловч эцсийн үр дүн нь хөрш зэргэлдээ улстай хэвийн харилцааг хангахад чиглэгддэг. Мөн түүнчлэн хил хяналтын, хамгаалалтын, хилийн тагнуулын, хил хамтран шалгах комиссын үйл ажиллагааг улсын хил дээр хэвийн явуулах нөхцлийг хангаж өгдөг үндсэн хүч юм.

Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа нь хилийн зөрчил, будлианыг тайван замаар шийдвэрлэх зөвшилцөө тохиролцоонд хүрэх өвөрмөц журам бөгөөд тэр нь улсын хилийн асуудлаар байгуулсан олон улсын болон хоёр талын гэрээ хэлэлцээрүүдийн заалт бүрийг ягштал биелүүлэхийг шаардахаас гадна хилийн төлөөлөгч бүрээс улсын хилийн дэглэмийн онцлог байдал, түүнийг хатуу сахиулах, хилийн аливаа зөрчил будлианыг зохицуулан шийдвэрлэх, хилийн төлөөлөгчийн хамтарсан хуралдааны шийдвэрийн биелэлтийг хянах, зэргэлдээ улсын хилийн төлөөлөгчтэй ажил хэрэгч, харилцан ойлголцсон харилцаа тогтоох, хууль, гэрээ хэлэлцээр, зэргэлдээ улсын хил орчмын оршин суугчдын үндэсний зан заншил, түүхийн талаар өргөн мэдлэгтэй байхыг шаардана.

Хилийн төлөөлөгчийн түвшинд төрөөс хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, улсын хил дээр зэвсэг хэрэглэхээс зайлсхийх, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчим баримтлахтай холбогдуулан хөрш улсуудын хил хамгаалах байгууллагатай харилцан тусалж, хамтран ажиллах олон арга хэмжээ авч байгаа юм. Эдгээрийн дотор тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тодорхой сэдвээр хамтарсан оператив-тактикийн хээрийн сургууль явуулсан нь аль аль талдаа харилцан туршлагаа солилцож, цаашид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлсон. Үүнд: 2003 онд Дорноговь–Эрээний, 2005 онд Сүхбаатар-Улиастайн, Өмнөговь-Далайхөвийн, 2010 онд Дорнод-Амгалангийн хилийн төлөөлөгчид, ОХУ-тай Сүхбаатар-Хиагтын Хилийн Бүрэн Эрхт Төлөөлөгчид тус тус хамтарсан сургууль явуулсан.

Хилийн аюулгүй байдлыг дипломат ажиллагаагаар хангах зарим асуудал

Цаашид хилийн аюулгүй байдлыг дипломатын ажиллагаагаар хангах бодлогын хүрээнд дараах асуудлуудыг шийдвэрлэх, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

¹³ Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2016.



- НҮБ-ын дүрмийн 102-ын 1-д "НҮБ-ын дүрэм батлагдсанаас хойш гишүүн улсууд байгуулсан аливаа гэрээ, хэлэлцээрээ аль болох хурдан хугацаанд НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газар бүртгүүлж хэвлүүлнэ" гэж заасан нь маргаан үүссэн үед НҮБ-ын салбар байгууллагууд, түүний дотор Олон улсын шүүхэд энэ асуудлаар хандан шийдвэрлүүлэх боломжийг олгож байгаа зохицуулалт болно. Иймд Монгол-Оросын хилийн гэрээг НҮБ-д бүртгүүлэх шаардлага урган гарч байгаа бөгөөд үүний үр дүнд Монгол улсын хойд хилд маргаан үүссэн тохиолдолд түүнийг шийдвэрлэх олон улсын эрх зүйн орчин баталгаажиж байгаа юм.

- Монгол-Хятадын хил хамгаалах байгууллагын хооронд хамтын ажиллагааны хэлэлцээрийг Засгийн газрын түвшинд байгуулах цаг үе ирээд байна. Үүний үр дүнд Монгол Улс, БНХАУ элчин сайдын яамдаа Хилийн албан ёсны төлөөлөгч харилцан суулгаж ажиллуулснаар Хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хилийн асуудлыг шуурхай шийдвэрлэх нэг чухал алхам болно.

- Хилийн төлөөлөгчийн алба нь хилийн аюулгүй байдлыг дипломатын ажиллагаагаар хангах нэг хэлбэр учир хилийн төлөөлөгч, орлогчийг Засгийн Газар томилж, "Хилийн төлөөлөгчийн албаны дүрэм"-ийг Монгол Улсын Засгийн Газрын тэргүүнээр батлуулан мөрдөх нь зүйтэй.

- Хилийн дэглэмийн гэрээ, хилийн тухай хуулийн дагуу хилийн төлөөлөгчийн байгууллагыг "Бүсчилсэн хил хамгаалалт" төсөлтэй уялдуулан "Бүсийн хил хамгаалалтын газар"-уудад бие даасан байдалтай байгуулах зэргээр боловсронгуй болгох нь зүйтэй. Үүний тулд "Бүсийн хил хамгаалалтын газар"-ын дарга "Бүсийн хилийн төлөөлөгч" байх ба хилийн отрядын дарга нар хилийн дэглэмийн гэрээнд заасанчлан тухайн хилийн хэсгийн "хилийн төлөөлөгч" байх нь оновчтой гэж үзэж байна. ОХУ-ын хувьд хилийн төлөөлөгч нь улсын хилийг хамгаалж байгаа хилийн нэгтгэл, ангийн захирагчийн албан тушаалыг хавсран гүйцэтгэж болохгүй¹⁴, учир нь Хилийн төлөөлөгч нь улсын хил дээр гарч буй маргаантай асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй, нөгөө нь хилийн хэсгийн хамгаалалтыг хариуцна гэж үздэг.


- Хилийн аюулгүй байдлыг хангах дипломатын ажиллагааг зохион байгуулах бүтцийн нэгж салангид, удирдлага төвлөрөөгүй байгааг нэгдсэн удирдлагад оруулах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл дипломат байгуулалт нэгдмэл удирдлагатай байх шаардлагатай бөгөөд Монгол-Хятадын хилийн дэглэмийн гэрээнд "Хилийн дэглэмийн гэрээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол, Хятадын хилийн хамтарсан комисс байгуулна"¹⁵ гэж зааснаар үүний эрх зүйн үндэс өмнөд хилд тавигдсан юм.

Иймд хилийн аюулгүй байдлыг дипломатын аргаар хангах удирдлагын бүтцийг дараах хувилбараар үзүүлэв.

¹⁴ Сүндэв.П, Базарсад.П, Монгол Улс, ОХУ-ын хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагаа,УБ,2008,27х

¹⁵ Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн Газар, БНХАУ-ын Засгийн Газар хоорондын гэрээ,УБ,2011,26х

Схем 1. Дипломат ажиллагаагаар Хилийн аюулгүй байдлыг хангах нэгжийн бүтэц



Дүгнэлт

Хөршийг сонгодоггүй гэж эртний мэргэн үг байдаг. Бид хойд талдаа ОХУ, өмнөд талдаа БНХАУ-тай хөрш болсон далайд гарцгүй улс юм. Иймд аюулгүй байдлын ихэнх судлаачид Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд хөрш хоёр гүрэн, тэдгээрийн дотоод, гадаад байдал шууд нөлөөлдөг гэж үздэг.

Өнөөдөр хоёр хөрштэй харилцах харилцаа түүхэнд байхгүй таатай бөгөөд тэнцвэртэй байгаа хэдий ч энэ нь манай улсын бодлого байр сууринаас илүүтэй гадаад орчноос, хоёр хөршийн хоорондын харилцаанаас хамаарч байгааг тооцож, харилцаанд өөрчлөлт гарах, хүйтэрч харилцаа муудах, эсвэл хэт сайдах нөхцөлд баримтлах гадаад бодлогын урьдчилсан төлөвтэй байх ёстой бөгөөд энэ нь хилийн аюулгүй байдлыг хангах дипломат бодлогод мөн тусгалаа олох нь зүйн хэрэг юм.

Монгол Улс хоёр том хөрштэйгөө хилээ тодорхой тогтоож, бүс нутагтаа газар нутгийн маргаангүй цорын ганц улс болох ч нэгэнт тогтоосон хилээ олон улсын эрх зүйн хувьд баталгаажуулах, хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн амин чухал ашиг сонирхлыг хангахад дипломат ажиллагааг идэвхтэй явуулах нь стратегийн хувьд ач холбогдолтой хэвээр байна.

Бид аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалуудад улс төр, дипломат бодлогыг урьтал болгохоо тодорхойлсон боловч судалгааны ажлын үр дүнд хилийн аюулгүй байдлыг хангахад дипломат ажиллагааг хэн хэрхэн явуулах тактикийн чиг шугам, арга барил тодорхойгүй байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл хилийн аюулгүй байдлыг хангах дипломат бодлого нь ч, үйл ажиллагаа нь ч тэр Монгол Улсын дипломатын бодлогын үргэлжлэл бөгөөд төрийн дипломат албаны нэгээхэн хэсэг болохыг дээр дурдсан билээ.

Иймд хилийн аюулгүй байдлыг хангах буюу улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах арга зам, түүнд дипломат ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх, боловсронгуй болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нэмэгдүүлэх, гүнзгийрүүлэх цаг үеийн хэрэгцээ шаардлага их байгааг энд зориуд дурдмаар байна.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗОХИОН
ТӨР
1921

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2016.
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2010. №36.
3. Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ Засгийн Газар хоорондын гэрээ. УБ., 2007.
4. Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, БНХАУ-ын Засгийн Газар хоорондын гэрээ. УБ., 2011.
5. Ш.Арвай. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. 2005.
6. П.Сүндэв, П.Базарсад. Монгол Улс, ОХУ-ын хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагаа. УБ., 2008.
7. Д.Цолмон, Д.Оюунсүрэн, Д.Баясгалан. Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс. УБ., 2009.
8. Ж.Энхбаяр. Аюулгүй байдлын олон талт асуудал. УБ., 2007.
9. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. УБ., 2010. №14(24).
10. Стратеги судлал сэтгүүл. УБ., 2010. №51.
11. Үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах нь. ЭШБХ-ын материал. УБ., 2010.



ОЛОН УЛСЫН ТЕРРОРИЗМ БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА

PREVENTION OF INTERNATIONAL TERRORISM

Л.Бат-Очир

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

Bat-Ochir L.

Police Captain, Senior Lecturer of Criminal Law and Criminology faculty,
Police Institute, Law Enforcement University

✉ batochir@leu.gov.mn

Товч агуулга: Дэлхийн хүн төрөлхтний айдас болсон терроризмын өнөөгийн байдал, түүний зорилго, эрүүгийн хуульд хуульчилсан байдал, цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал.

Abstract: This study focuses on terrorism, its current situation and purpose, how terrorism should be understood in the criminal law and how we should prevent from terrorism.

Түлхүүр үгс: Терроризмын зорилго, терроризм үйлдэх арга, урьдчилан сэргийлэх ажиллагаа.

Keywords: Terrorism purpose, tactics of terrorism, prevention.

Хүн төрөлхтний айдас түгшүүргүй амгалан аж төрөх, эрүүл энх байх, амьд явах эрхэд байнга заналхийлсэн олон аюул дотроос терроризм илт давамгайлах болов.

Улс төрийн, үндэстний, шашны, өс хонзонгийн гэх мэт урьдчилан төсөөлөхөд бэрх, дэлхий нийтийн болоод тодорхой бүс нутаг, улс орны хэмжээнд өмнө нь байсан, одоо байгаа, цаашид ч устаж үгүй болохгүй олон бэрхшээлтэй асуудлуудыг зөвхөн террорист аргаар шийдвэрлэх гэсэн оролдлогууд сүүлийн жилүүдэд улам нэмэгдэх хандлагатай байна.

Энэ харгис хүчирхийллийн золиос нь хэн ч байж болзошгүй бөгөөд түүнийг үйлдэх шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхэд өчүүхэн ч оролцоо байхгүй, жирийн амьдралтай эгэл жирийн хүмүүс хүртэл террорист халдлагад үй олноороо өртөж байна.

Терроризмын гол аюул нь дайсагнагч талын зэвсэгт хүчин, цэргийн объектод бус, гэм зэмгүй энгийн ард олон, ямар ч төрлийн объектод чиглэдэг бөгөөд зөвхөн нэг улсын дотоод асуудлаас хальж олон улсын шинжтэй, төр нийгэм, улс төр, эдийн засаг, хууль зүй, ёс суртахуун, болон цэрэг, соёл урлагт ч нөлөөлөхүйц янз бүрийн зорилгод хүрэх нийгмийн зөрөлдөөнийг шийдвэрлэх хүн төрөлхтний эсрэг арга хэрэглүүр болж хувирч байна.

Монгол улсын ерөнхийлөгч асан Н.Багабанди 2002 оны 9 сард гадаадад суугаа өөрийн орны элчин сайд, консулуудтай хийсэн уулзалт дээр: Монголчууд бид терроризмын талаар ам өрсөлдөн ярих биш 1.5 сая хавтгай дөрвөлжин км газар нутгаа террористууд болон терроризм үл нутагших, үл орогнох, дархан





газар болгоход чиглэгдсэн бодит арга хэмжээ авах, тэрчлэн террорист сурталчилгааг үл явуулах, террорист сэтгэлгээг үл тэвчих ажил зохиох шаардлагатай¹ болохыг зориуд анхааруулсан нь Монголын төрөөс терроризмтой тэмцэх бодлого, үйл ажиллагааны чиглэл болсон.

Иймд терроризмтой тэмцэхийн тулд улс орон бүр өөрийн нийгмийн гадаад, дотоод байдалд бодит шинжилгээ хийж, терроризм үүсэх шалтгаан, нөхцөлийг олж тогтоох, террорист халдлага үйлдэх нөхцөл боломж, арга замыг хаах нь тулгамдсан асуудал болоод байна.

Дэлхий нийтэд үндэсний мөргөлдөөн, шашны үзэл суртал, олон улсыг хамарсан, үндэстэн дамнасан зохион байгуулалттай алан хядах үйл ажиллагаа, галт зэвсэг, мансууруулах бодис, хүн худалдаалах, цахим гэмт хэргийн гаралт ихсэж, террорист ажиллагаа, үйлдлийг өргөн хэрэглэх, шинжлэх ухаан, техникийн дэвшил, тухайлбал генийн инженерчлэл, компьютер мэдээллийн орчин үеийн техник, технологи, шинэ төрлийн зэвсэг, холбоо дохиоллын техник хэрэгслийг өргөн ашиглах болсноор терроризм улам даяарчлагдаж дэлхийн улс гүрнүүд хамтарч тэмцэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Дэлхийд 500 гаруй алан хядах байгууллага байгаа гэсэн тооцоо бий². Жишээ нь: Аль Кайда бүлгийн санхүүгийн боломж 5 миллиард доллар, үүнээс жилийн төсөв нь 20-50 сая орчим доллар Ливаны Хезболла, Палистины Хамас зэрэг бүлэглэлүүд жилд 2-5 сая орчим доллар террорист ажиллагаанд зориулдаг бөгөөд санхүүгийн гол эх сурвалж нь мансууруулах бодис, хүн худалдаалах, галт зэвсгийн худалдаа байдаг ба террорист бүлэглэлүүд хар тамхинаас жилд 400 тэрбум гаруй долларын ашиг олдог байна.³

Сүүлийн жилүүдэд Азийн зарим улсад болон манай хоёр хөрш улсад террорист халдлага үйлдэгдэх болсон нь Монгол улсад үйлдэгдэхгүй гэх баталгаа алга байна.

Терроризм нь - "terror" гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд "айдас", "цочирдуулан балмагдуулах", "аймшиг" гэсэн утгатай латин үг юм. Дэлхийн зарим улс орнууд терроризмын тухай ойлголтыг дараах байдлаар тодорхойлж байна.

АНУ-ын Холбооны мөрдөх товчооны тодорхойлолтод: "Терроризм гэж улс төрийн болон нийгмийн энгийн иргэдийг айлган сүрдүүлэх аргаар бие хүн тэдний эд хөрөнгийн эсрэг хууль бусаар хүч хэрэглэх эсхүл хүчирхийлэхийг хэлнэ⁴, АНУ-н департамент: Үндэстэн дамнасан бүлэглэл эсвэл улс төрийн агентууд улс төрийн сэдэлтэйгээр нийгмийн тодорхой хэсэг, гэмгүй номхон ард иргэд, чухал алба хашдаг эрх мэдэл бүхий хүмүүст нөлөөлөх зорилгоор иргэний байгууламжийг бай болгон зориуд санаатай үйлдэж буй хүчирхийлэл, АНУ-н Батлан хамгаалах яам: Улс төр, шашин, үзэл суртлын зорилгоор төр засаг, нийгэмд шахалт үзүүлэх, эсвэл тэднийг айлган сүрдүүлэх зорилго бүхий зориуд санаатай үйлдэж буй хүчирхийлэл, түүний аюул, ОХУ: Терроризм бол хүчирхийллийн гэмт үйлдэл, Их Британи: Улс төр, шашин, үзэл суртлын зорилгын төлөө, түүний дотор нийгмийг эсвэл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар

¹ Терроризмын эсрэг. УБ., 2003. 37 дах тал.

² Терроризмын эсрэг. Терроризмын эсрэг Монголын холбоо. УБ., 2003. 45 дах тал.

³ www.criminology.mn

⁴ З.Термандах. АНУ-ын гэмт хэрэгтэй тэмцэх орчин. УБ., 2013. 25 дах тал.



харгис хүчирхийлэл хэрэглэх явдал, НАТО: Хөрөнгө санхүү, хөнөөх хэрэгслийн хүчинд дулдуйдан хууль бус зэвсэгт бүлэглэлээс улс төр, шашин үзэл суртлын зорилгодоо хүрэх онцгой харгис үйлдлийг зөвтгөн, нийгэмд бүхэлд нь эсвэл тодорхой хэсэгт айдас аймшиг төрүүлэхээр энгийн иргэд, эд хөрөнгийн эсрэг зориуд санаатайгаар үйлдэж буй хэт харгис хүчирхийлэл, заналхийлэл гэж тус тус тэмдэглэсэн бол Монгол улс: Хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагаа гэж хуульчилсан байна. Дээрх тодорхойлолтуудаас дүгнэхэд терроризм нь зорилгодоо хүрэх онц харгис хэрцгий үйлдлийг зөвтгөсөн, хөрөнгө санхүүгээр тэтгэсэн, зэвсэг хөнөөх хэрэгслийн хүчинд тулгуурласан, салан тусгаарлагч үзэлтэй цөөн хүний хүрээллийн дотор өндөр нууцлалтай бэлтгэгдэж үндэстэн дамжсан эрүүгийн онц ноцтой гэмт хэргийн шинжтэй харгис хэрцгий хүчирхийлэл юм.

Терроризм нь зорилгын хувьд:⁵

- Төр засгийн болон нийгмийн байгуулалт, бодлогыг өөрчлөх гэсэн улс төрийн зорилготой;
- Соёл иргэншлийн эх сурвалж бүхий шашин, амьдралын хэв маягийг дэлгэрүүлэх, үзэл суртал, ёс суртахууныг түгээх, дэлгэрүүлэх.

Аргын хувьд:

- Террорист бүлэг байгуулах, бэлтгэх, зохион байгуулах;
- Олон хүний амь насыг хохироох, эд хөрөнгө, стратегийн болон бусад объектыг устгах, заналхийлэх;
- Улс төрийн зүтгэлтэн, нөлөө бүхий хүмүүсийн амь насанд халдах, олон нийтийг айдаст автуулах;
- Нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэх, төр засгийн удирдлагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;
- Иргэдийг элслүүлэх, зэвсэглэх, сургах;
- Байгууллага, иргэдийг өдөөн хатгах, албадах;
- ОУ-н конвенц, дүрэм, үндэсний хууль тогтоомжийг зөрчих;
- Нийгэм, хүн төрөлхтний ёсыг гажуудуулсан, ёс суртахуунгүй хүмүүнлэг бус бодлого, үйл ажиллагаа;
- Терроризмын үзэл санааг дэлгэрүүлэх;
- Эрүүгийн гэм хэрэг үйлдэх хэлбэртэй байна.

Монгол улсын төрөөс олон улсын өмнө хүлээсэн терроризмтой тэмцэх үүргээ биелүүлэн холбогдох хууль, тогтоол шийдвэр гаргаж түүний хэрэгжилтийг хангах, гадаад улстай хамтран ажиллах, мэдээлэл, туршлага солилцох, зэрэг шат дараалсан арга хэмжээ авч байна. Тухайлбал “Терроризмтой тэмцэх тухай

⁵ Ц.Дашзэвэг, Д.Чагнаадорж. “Олон улсын терроризм, түүнээс урьдчилан сэргийлэх зарим асуудал”. УБ., 2004. 78 дах тал.



хууль”⁶, “Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай”⁷ Ерөнхийлөгчийн зарлиг, “Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай”⁸ тогтоол, “Олон улсын алан хядах үйл ажиллагаанаас сэрэмжлэх арга хэмжээний тухай” зөвлөмжийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргаж эрүүгийн хуульд терроризмтой холбоотой 3 гэмт хэргийг хуульчилсан байна.⁹

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан эрүүгийн хуульд терроризмтой холбоотой гэмт хэргүүдийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1.29.1. Террор үйлдэх

1. Төр, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, шийдвэр гаргахаас татгалзуулах зорилгоор галдан шатаах, цахим сүлжээ, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, хими биологийн хортой, аюултай бодис ашиглаж, ашиглахаар заналхийлж хүн амыг айдаст автуулсан: хүнийг санаатай алсан, эрүүл мэндэд хүнд хор уршиг учруулсан: зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний амь бие, бие махбодид халдсан хүнийг 12-20 жил хүртэл хугацаагаар, эсвэл бүх насаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг татан буулгах ял шийтгэнэ,

2.29.9.Террор үйлдэхэд бэлтгэх

1. Террор үйл ажиллагаа явуулах зорилгоор зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, бусдыг элсүүлсэн, татан оролцуулсан, бэлтгэсэн, сургасан, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлээр хангасан бол 12-20 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг татан буулгах ял шийтгэнэ.

Тайлбар: террор ажиллагааг бэлтгэхэд оролцсон хүн гэмт хэргээ сай дураар илчилсэн, төрийн байгууллагад цаг тухайд нь сэрэмжлүүлсэн, террор ажиллагааг таслан зогсооход бодитой тус дөхөм үзүүлсэн тухайн хүний үйлдэл өөр гэмт хэргийн шинжгүй бол ялаас чөлөөлнө.

3.29.10 Террор үйлдэхийг санхүүжүүлэх

1. Террорист, террорист байгууллага, террор ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд, шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж 120 нэгжээс 400000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ гэж тус тус заажээ. Энэ нь эдгээр төрлийн гэмт хэргийн төрлийн объектыг хүн төрөлхтний аюулгүй байдал энх тайвны эсрэг гэмт

⁶ Терроризмтой тэмцэх тухай хууль. 2004.

⁷ Монгол Улсын ерөнхийлөгчийн 2001 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 60 дугаар зарлиг.

⁸ Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 226 дугаар тогтоол.

⁹ Эрүүгийн хууль. 2002. 178¹ дүгээр зүйл. Терроризм, 178² дугаар зүйл. Терроризмыг санхүүжүүлэх, 178³ дугаар зүйл. Терроризмыг сурталчлах.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЭРХ
ТӨРЛӨЙН ГЭМТ
ХЭРЭГТ

хэрэгт хамааруулж байгаа явдал нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний хувьд дэвшилттэй алхам болжээ. Учир нь шинэ эрүүгийн хуулийн 1.10.4 дэх хэсэгт хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэж заасан байна. Нөгөө талаар шинэ эрүүгийн хуулийн 1.7.2 дэх хэсэгт “Монгол улсын нутаг дэвсгэрийн гадна гэмт хэрэг үйлдсэн Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, Монгол улсад байнга оршин суудаггүй харьяалалгүй хүнийг Монгол улсын олон улсын гэрээний дагуу гэмт хэрэгт шалгуулах, ял эдлүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгч болно, 3 дэх хэсэгт “Тухайн улсын хуульд зааснаар цаазаар авах ял оногдуулах, эрүү шүүлт тулгах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тухайн улсад гэмт хэрэгт мөрдөн шалгуулах, ял шийтгүүлэхээр шилжүүлэн өгөхгүй гэж заасан нь олон улсад эрэн сурвалжлагдаж байгаа зартай алан хядагч, манай улсын нутаг дэвсгэрт байгаа тохиолдолд бид хүлээлгэн өгөх үүрэгтэй. Хүлээлгэн өгөхийг шаардаж байгаа улс тухайн алан хядагчид ямар төрлийн ял оногдуулах гэж байгааг урьдчилан таамаглах боломж байхгүй. Монгол улс дээрх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нөхцөл үүсэхээр байна.

Терроризмын гэмт хэрэгт нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахууны шинжтэй олон хүчин зүйлсийг тухай бүр оновчтой тодорхойлж түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэгжүүлэх нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн тодорхойлогдох юм. Тухайлбал үндэсний үзэл, шашны хэт даврагч үзэл, цөмийн зэвсэг, хууль бус цагаачлал, хууль бус галт зэвсэг, мансууруулах бодис, хүний наймаа, хил хязгаарын болон газар нутгийн маргаан, зохион байгуулалтай гэмт хэрэг, гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа, дэлхийн хүн амын ядуурал, хүнсний хомсдол зэрэг хүчин зүйлүүд нь энэ гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна.

Иймд дээрх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Радио идэвхт болон хими биологийн хорт бодис ашиглаж террор үйлдэхийн эсрэг тэмцэх, мэргэшсэн ажилтныг бэлтгэх.
- Сүүлийн үед террорист бүлэглэлүүд үйл ажиллагаандаа цөмийн болон хими, биологийн зэвсгийг ашиглах хандлагатай боллоо. Монгол улсын хэмжээнд 1300 гаруй аж ахуйн нэгж байгууллага 420 гаруй нэр төрлийн химийн хорт бодис хэрэглэж байна. Эдгээр хорт бодисын нөөцийн 60 хувь нь нийслэлд хадгалдагдаж байгаа тухай баримт бий.¹⁰ Жишээ нь зөвхөн нэг аж ахуйн нэгжид л 1500 тонн химийн бодис хэрэглэх тусгай зөвшөөрөл өгсөн байна. Дээрх хорт бодисуудын хадгалалт, хамгаалалт, ашиглалт, хяналт маш муу байна. Энэ нь цаашид террорист халдлага үйлдэх таатай хөрс суурь болохоос гадна хүн амын эрүүл мэнд, агаарын бохирдолд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Хууль сахиулах байгууллагаас гадаадын иргэдийн Монгол улсад нэвтрэх, зорчих, дамжин өнгөрөх, байнга болон түр оршин суух үйл ажиллагаа тэдний бичиг баримтад тавих хяналтыг сайжруулах, террор

¹⁰ МХЕГ-ын судалгааны тайлан. УБ., 2014.



- үйлдэж болзошгүй хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мэдээлэл солилцох
- Терроризмын санхүүгийн эх үүсвэр болох галт зэвсэг, мөнгө угаах, хүн худалдаалах, мансууруулах бодисын хууль бус наймаатай тэмцэх ажиллагааг эрчимжүүлэх
 - Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй шашны урсгал, сүм хийдэд тавих хяналтыг сайжруулах
 - Эдийн засгийн хямрал, улс төрийн тогтворгүй байдал, хүн амын ядуурал, ажилгүйдэл, авлига албан тушаалын гэмт хэрэг, дээрх гэмт хэрэгтэй тэмцэх төрийн чадавх, тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын түвшин, цахим терроризмтой тэмцэх
 - Терроризмын гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдэд тавих захиргааны хяналтыг чангатгах, эрх зүй, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох. Тухайлбал хүнд, онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдэж суллагдсан, согтуурах, мансуурах донтой, шашны үзэл номлогчид, илтгэгчид, бэлгийн цөөнх, сэтгэл мэдрэлийн архаг өвчтэй этгээдүүд, гадаадын иргэн, харьяалалгүй иргэд, тэнэмэл хүмүүс, насанд хүрээгүй хүнийг уруу татагч этгээдэд тавих хяналтыг чангатгах¹¹
 - Төрийн бүх шатны байгууллага, хуулийн этгээд, хувь хүн нэг бүрээс терроризмоос урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг нэгдсэн бодлого, төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлэх, хэвшүүлэх,
 - Улс орондоо террорист байгууллага, бүлэг үүсэх шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхээс сэргийлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах
 - Иргэдэд терроризмыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, газар нутагтаа олон улсын терроризм, террорист этгээд үл нэвтрэх, үл орогнох, үл нутагших орчин, нөхцөлийг бүрдүүлэх
 - Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох цэрэг, тагнуул, цагдаагийн салбар, нэгжийг тусгайлан байгуулах, эсхүл томилох, тэдгээрийн үүрэг гүйцэтгэх бэлтгэл, чадавх, бэлэн байдлыг хангах;
 - Иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг болзошгүй террорист үйлдлээс сэргийлэх, хамгаалах
 - Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;
 - Төрийн байгууллага, эдийн засгийн дэд бүтцийн барилга, байгууламж болон соёл, олон нийтийн үйлчилгээний чухал газруудыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;
 - Террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, үүдэн гарах хор уршиг, хохирлыг багасгахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авах;
 - Бусад улс, тэдний хууль сахиулах байгууллага, тусгай албад, олон улсын холбогдох байгууллагатай терроризмоос сэргийлэх, террорист үйлдлээс сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах

¹¹ Б.Баянмөнх. "Терроризмын аюул" Цагдаа судлал сэтгүүл. УБ., 2013 №01. 39 дэх тал.



МОНГОЛ
ХУУЛЬ
ЭРХ
ТӨР
ОРОН
ТӨДИЙГҮЙ
ДЭЛХИЙН
АЛС
УРСАД
ҮЙЛДЭГДЭХ
ХАНДЛАГА
ТАЙЛАН

- Террор үйлдэж болзошгүй хүмүүсийн үйл хөдөлгөөнийг хязгаарлах, таслан зогсоох, шуурхай илрүүлэх арга хэмжээ авах
- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас мэдээлэл шуурхай худалдаж авах, тийм механизмыг хуульчлах
- Терроризмын гэмт хэрэг үйлдэгдсэн бол шуурхай шалгах илрүүлэх, террорист ажиллагаа, террорист үйлдлийг илрүүлэх, түүнээс иргэн, байгууллагыг сэрэмжлүүлэх, хамгаалах, террорист үйлдэлд өртсөн иргэн, эд хөрөнгийг аврах, хамгаалах;
- Террорист ажиллагаа, террорист үйлдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг шуурхай илрүүлэн тогтоож таслан зогсоох, террорист этгээдийг баривчлах, аюулгүй болгох;
- Террорист ажиллагаа, террорист үйлдэлд ашиглаж байгаа буюу ашиглахад зориулсан эд хөрөнгө, мөнгө, террорист ажиллагаа, террорист үйлдлээс олсон орлогыг илрүүлэх, хураах, сурталчилгаа явуулж болох бүх хэлбэрт хяналт тавих
- Терроризмын санхүүгийн гол эх үүсвэрийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хар тамхи, мансууруулах, бодис, хүний наймаа, мөнгө угаах гэмт хэргүүдтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх, шуурхай илрүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг хамааруулна.

Дүгнэлт

Терроризмын гэмт хэргийн улмаас нийгэмд ямар их хохирол учруулж байгааг бид бүхэн олон улсад үйлдэгдэж буй халдлагаас харж болно. Энэ төрлийн гэмт халдлага зөвхөн хэсэг улс орон төдийгүй дэлхийн аль улсад үйлдэгдэх хандлагатай болж байгаа өнөө үед бид энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл, судалгаанд анхаарч урьдчилан сэргийлэх, терроризмтой тэмцэж байгаа дэлхийн улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлага тулгарч байна. Цаашид дэлхий нийтэд бодитой аюул учруулж буй терроризмын эсрэг Монгол улс төдийгүй, бүс нутгаараа терроризмтой тэмцэх таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, дэлхийн улсуудтай хамтран тэмцэх нь үндэсний аюулгүй байдлыг хангах хүчин зүйлийн нэг чухал хэсэг болох юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. Эрүүгийн хууль. УБ., 2002.
2. Терроризмтой тэмцэх тухай хууль. 2004.
3. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2001 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 60 дугаар зарлиг.
4. Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 226 дугаар тогтоол.
5. З.Төрмандах. АНУ-ын гэмт хэрэгтэй тэмцэх орчин. УБ., 2013.
6. Ц.Дашзэвэг, Д.Чагнаадорж. "Олон улсын терроризм, түүнээс урьдчилан сэргийлэх зарим асуудал". УБ., 2004.
7. Б.Баянмөнх. "Терроризмын аюул" Цагдаа судлал сэтгүүл. УБ., 2013 №01.
8. МХЕГ-ын судалгааны тайлан. УБ., 2014.
9. Терроризмын эсрэг. Терроризмын эсрэг Монголын холбоо. УБ., 2003.
10. www.criminology.mn

ХИЛ ДАМНАСАН БОЛОН ХИЛИЙН БҮСЭД ГАРСАН ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭР УНТРААХАД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

FOREST FIRE ISSUES ACROSS THE BORDER AND BORDER AREA

Д.Хадбаатар

Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулийн
Онцгой байдлын албаны тэнхимийн эрхлэгч, хошууч

Khadbaatar D.

Major, Head of the State Emergency Department,
School of Noncommissioned Officer, Law Enforcement University

Ю.Ганзориг

Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулийн
Онцгой байдлын албаны тэнхимийн ахлах багш, ахмад

Ganzorig Yu.

Captain, Senior lecturer of the State Emergency Department,
School of Noncommissioned Officer, Law Enforcement University

✉ khadbaatar.d@leu.gov.mn

Товч агуулга: Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хил дамнасан болон хил бүсэд гарсан Оой, хээрийн түймрийг унтраах, урьдчилан сэргийлэх зурвасыг арчлах, сэргээх, хамгаалах ажлыг эрчимжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг судалгааны үндсэн дээр тодруулан гаргах, шийдвэрлэх арга замыг хайх, дээд шатны байгууллагад танилцуулах саналыг боловсруулахад оршино.

Abstract: The purpose of the study is to identify facing issues on maintaining border security, fighting against the forest fire across the border and, or border area, restoring fire protection zone and accelerating prevention through research work. In addition, coming up with certain solution, developing and introducing proposals on the facing issues to authorities will be focused on this study.

Түлхүүр үгс: Онцгой байдлын байгууллага, хил хамгаалах байгууллага, ой, хээрийн түймэр, уулын бүс, тайгын бүс, говь, цөлийн бүс, тал хээрийн бүс.

Keywords: State emergency organization, border protection authorities, forest fire, mountain zone, taiga zone, desert zone, steppe zone.

Оршил

Азийн хэмжээнд гарч байгаа гамшгийн төлөв байдал нь дэлхийн байгаль экологийн өөрчлөлт цаг уурын дулаарал, хүний зохисгүй үйл ажиллагаанаас улбаатай гарч буй байгалийн гамшгийн давтамж ойртож, үргэлжлэх хугацаа нь уртсаж, түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Монгол улсын хэмжээнд объектын болон ой хээрийн түймэр, ган, зуд, цасан болон шороон шуурга, цөлжилт, хэт халалт зэрэг байгалийн гамшгаас гадна хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, хортон шавжийн тархалт, үйлдвэр, тээврийн хэрэгслийн осол, цацраг идэвхт хордолт, химийн хорт бодисын



алдагдалт зэргээс хүний амь эрсдэх, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчинд ихээхэн хохирол учирсаар байна.

Хил хамгаалах байгууллага нь Онцгой байдлын ерөнхий газартай Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай, Онц байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй байх, үр дүнгээ хамтран хэлэлцэж дүгнэх, харилцан бие биеэ хүндэтгэх зарчмыг баримтлан харилцан ажиллаж байна.

Монгол Улсын хил хамгаалалтыг хилийн 14 аймаг, 70 сумын нутаг дэвсгэр дэх хилийн отряд, тусгай салбар, застав, харуулын хүч хэрэгслээр хариуцсан хэсгийн байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан бүсчлэн зохион байгуулдаг.

Хилийн бүсийн нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн түймрийг унтраах үйл ажиллагаанд Хил хамгаалах байгууллагын хилийн отряд, заставын офицер, ахлагч, хугацаат цэргийн албан хаагч нар хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Хил орчмын нутаг дэвсгэрт гамшгийн эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдал

Уулын бүсэд

- Цаг уурын гэнэтийн өөрчлөлт /хэт халалт, хүйтрэлт/;
- Гол, усны үер;
- Хүн, малын гоц халдварт өвчин;
- Газар хөдлөлт;
- Цасан уруй;

Ой, тайгын бүсэд

- Ойн түймэр;
- Хүн, малын гоц халдварт өвчин;
- Ган, зуд;

Говь, цөлийн бүсэд

- Цаг уурын гэнэтийн өөрчлөлт /хэт халалт/;
- Хүн, малын гоц халдварт өвчин;
- Ган, зуд;
- Шуурга /угалз/;


Тал хээрийн бүсэд

- Цаг уурын гэнэтийн өөрчлөлт /хэт халалт, хүйтрэлт/;
- Гол, усны үер;
- Тал хээрийн түймэр;
- Хүн, малын гоц халдварт өвчин;
- Ган, зуд;
- Хүчтэй шуурга.

Гамшгаас урьдчилан сэргийлэх талаар Хил хамгаалах байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Бүх төрлийн зарлан мэдээлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулж, бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдлыг хангах;
- Шаардлагатай үед хэрэглэх бүх төрлийн нөөц, багаж, хэрэгслийг байнгын бэлэн байлгах;
- Хил орчмын ард иргэдэд ухуулга, сурталчилгаа хийх;
- Харилцан ажиллагаатай байгууллагуудтай тогтмол мэдээ мэдээллийг солилцох;
- Улсын хил орчмын нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд төвдөө болон Онцгой байдлын байгууллагад мэдэгдэх, унтраах арга хэмжээг авах;
- Гамшгийн аюул улсын хил даван орж ирэх, гарахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр инженер, техникийн байгууламж, шороон зурвасыг хилийн зурваст байгуулах;
- Байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн үед хүч хэрэгслийн дэмжлэг үзүүлэх;
- Хил орчмын нутаг дэвсгэрт хүн, мал, амьтны гаралтай гоц халдварт өвчлөл бий болсон үед талууд мэдээ, мэдээллийг шуурхай солилцож, хамтран ажиллах;
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах чиглэлээр хил орчмын нутаг дэвсгэрийн оршин суугчид болон аж ахуйн нэгж, байгууллага, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг оролцуулах асуудлаар хамтран ажиллах;
- Хил орчмын нутаг дэвсгэрт болзошгүй гамшгаас хамгаалах чиглэлээр хамтарсан дадлага, сургалтыг анги, салбар, нэгжүүдийн хооронд болон төв байгууллагуудын дунд үе шаттай зохион байгуулах.

График 1. Ой, хээрийн түймрийн сүүлийн 10 жилийн график судалгаа (оноор)¹



¹ Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл 2000-2017. УБ., 2014. 31 дах тал. ОБЕГ-ын гамшгийн мэдээ-Гал түймэртэй тэмцэх газар 2018 оны мэдээ нэмэлтээр.

Хилийн бүсэд гарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдал

2010-2018 онд хилийн зурвас, бүсэд нийт 256 удаагийн ой, хээрийн түймэр гарч Хил хамгаалах байгууллагаас давхардсан тоогоор 5988 алба хаагч, 1056 автомашин, техник хэрэгсэлтэйгээр оролцож, түймрийг унтраасан.

Дотоодод 198 удаагийн түймэр гарснаас 10 удаагийн түймэр хил давж, БНХАУ-ын талаас 7, ОХУ-ын талаас 41 удаагийн түймэр хил давж орж ирсэн байна.

Нийт түймрийн 59.2 хувь нь хилийн зурваст, 33.6 хувь нь хилийн бүсэд, 7.2 хувь нь зурвас, бүсийг дамнан гарсан.

График 2. Хилийн зурвас, бүсэд 2010-2018 онд гарсан түймрийн судалгаа (оноор)





График 3. Хилийн зурвас, бүсэд 2010-2018 онд гарсан түймрийн судалгаа (аймгаар)



МОНГОЛЫН ХУУЛЬ
ЭРХЭМ
ТӨСӨМӨР

Онцгой байдлын байгууллагаас хил дамнасан ой, хээрийн түймэртэй талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмын дагуу хамтран ажилладаг.
- Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагууд ОХУ-тай жилд 1 удаа, БНХАУ-тай 2 жилд 1 удаа албан уулзалтуудыг зохион байгуулж хамтран ажилладаг.
- Зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Онцгой байдлын газрууд ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотын Онц байдлын газартай хамтран Монгол Улс, ОХУ-ын Хил хамгаалах байгууллагын хяналтан дор хил дамнасан ой, хээрийн түймрийг унтраах, мэдээлэл солилцох дадлага, сургалтыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна.
- Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын хамтран ажиллах гэрээний дагуу хилийн бүсийн нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн түймрийн талаар мэдээлэл солилцох, түймэр унтраах үйл ажиллагаанд Хил хамгаалах байгууллагын хилийн отряд, заставын офицер, ахлагч, хугацаат цэргийн албан хаагч нар үүрэг гүйцэтгэн ажилладаг.
- Аймаг орон нутгийн Онцгой байдлын газрууд Хилийн хамгаалах байгууллагын анги салбаруудтай хамтран гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, дадлага, сургалтуудыг зохион байгуулдаг.

Ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар Хил хамгаалах байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Улсын хил дамнасан болон хил орчмын нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн түймэр, түймрийн аюулын талаарх мэдээ, мэдээллийг салбар нэгжүүдээр дамжуулан Онцгой байдлын байгууллагатай яаралтай солилцох;
- Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраах арга хэмжээг хамтран зохион байгуулахын зэрэгцээ хил дамнасан түймэр гарсан үед унтраах бүлгийг улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг хөрш улсуудын эрх бүхий байгууллагуудтай харилцан тохиролцож, шуурхай шийдвэрлэх;
- Улсын хил болон хил орчмын иргэдийн амь нас, аж ахуйн нэгж байгууллагуудын өмч, хөрөнгийг ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зурвасыг зориулалтын төсөв, санхүүжилтээр арчлах, сэргээх, хамгаалах;
- Онцгой байдлын ерөнхий газар, орон нутаг дахь байгууллагын алба хаагчдыг албан томиллоор хилийн бүс, зурваст нэвтрэх үед нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- Ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагааны чиглэлээр холбогдох байгууллагуудтай харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэх /төсөл, хөтөлбөрт хамруулах, техник, технологийн гэх мэт/;
- Улсын хилийн дагуу байрлаж байгаа түймрийн эрсдэлтэй хилийн анги, салбар, нэгжүүдэд ажиллагсдын амь нас, эд хөрөнгийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах багаж, хэрэгслээр хангах ажилд дэмжлэг үзүүлэх;



Дүгнэлт

Хилийн зурвас, бүсэд гарсан гал түймрийн судалгаанаас харахад хойд талаараа ОХУ-тай, урд талаараа БНХАУ-тай хиллэдэг Дорнод аймгийн хилийн зурвас бүсэд ой, тал хээрийн түймэр 131 удаа буюу 51,1 хувийг эзэлж байна.

2016-2018 оны Хил дамнасан болон хилийн бүсийн нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн түймрийн тоо судалгаанаас харахад буурсан үзүүлэлттэй байгаа нь Хил хамгаалах байгууллагын хилийн отряд, заставын офицер, ахлагч, хугацаат цэргийн албан хаагч нар цаг хугацаанд нь шуурхай арга хэмжээ авч ажилласны үр дүн гэж үзэж байна.

Зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Онцгой байдлын газрууд ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотын Онц байдлын газартай хамтран Монгол Улс, ОХУ-ын Хил хамгаалах байгууллагын хяналтан дор хил дамнасан ой, хээрийн түймрийг унтраах, мэдээлэл солилцох дадлага, сургалтыг жил бүр зохион байгуулж явуулдаг нь үр дүнтэй сургууль болсон байна.

Улсын хил болон хил орчмын иргэдийн амь нас, аж ахуйн нэгж байгууллагуудын өмч, хөрөнгийг ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зурвасыг арчлах, сэргээх, хамгаалах ажлыг эрчимжүүлж, хилийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

Санал

1. Улсын хилийн дагуу байрлаж байгаа түймрийн эрсдэлтэй хилийн анги, салбар, нэгжүүдэд ажиллагсдын амь нас, эд хөрөнгийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах багаж, хэрэгслээр хангах ажилд дэмжлэг үзүүлэх.

2. Монгол Улстай хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-тай хилийн бүс нутгийн орчимд ой, тал хээрийн түймэр гарсан үед шуурхай цаг хугацаа алдалгүй мэдээлэл солилцох.

3. Хилийн бүс нутгийн орчимд ой, тал хээрийн түймэр гарсан үед хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-ын шаардлагатай албан тушаалтнуудыг утасны жагсаалтуудыг харилцан солилцох.

4. Хилийн бүс нутгийн орчимд ой, тал хээрийн түймэр гарсан үед хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-ын хилийн зурвас газраар Онцгой байдлын албаны албан хаагчид хялбаршуулсан журмаар нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017.
2. Хилийн тухай хууль. 2016
3. Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам. 2011.
4. Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл 2000-2013. УБ., 2014.
5. Б.Жадамбаа, Ц.Чимэдлхам. Судалгааны арга зүй. УБ., 2001.
6. Ц.Минжин, Н.Жалбажав. Шинжлэх ухааны судалгааны арга зүй. УБ., 2016.

А.Гантуул

Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Удирдахуйн ухааны профессорын багийн дэд профессор, цагдаагийн хошууч

Gantuul A.

Police major, Associate professor of Management Professor's team,
The Executive Leadership Academy, Law Enforcement University

✉ gantuul@leu.gov.mn

Товч агуулга: Энэхүү илтгэлээр удирдагчийн шийдвэр гаргах үйл явц нь байгууллагын хөгжил, соёлд хэрхэн нөлөөлдөг, түүнийг сайжруулах зарим аргаас хил хамгаалах байгууллагын хүрээнд хэрэгжүүлж болох талаас нь санал дэвшүүлэхийг зорилго.

Abstract: This article aims to introduce the influence of managerial decision making process in organizational development and culture, and to propose improvement of some methods in decision making within the framework of the Border Protection Organization.

Түлхүүр үгс: Удирдлагын шийдвэр, шийдвэр гаргалт, шийдвэр гаргахад харгалзах хүчин зүйл, шийдвэр гаргах арга, шийдвэр гаргах ур чадвар, захирагч төвтэй шийдвэр гаргалт, штаб төвтэй шийдвэр гаргалт.

Keywords: Managerial decision, decision making, factors and methods for decision making, decision making skills, superintended-centered decision, staff-centered decision.

Оршил

Хууль сахиулахын удирдлагын академи /цаашид Академи гэх/ нь хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн тусгай албадын удирдах албан тушаалтныг сургах, бэлтгэх үндсэн зорилгоор сургалт, эрдэм шинжилгээний ажлыг эрхэлж байна. Академийн үндсэн зорилготой уялдуулан хил хамгаалах байгууллагын удирдах бүрэлдэхүүн тэр дундаа төв, орон нутгаас алслагдсан хилийн застав, анги, бүлгийн дарга нарт ажлын байран дээрээ суралцах боломжийг нэмэгдүүлэх, бүх шатны удирдах бүрэлдэхүүний шийдвэр гаргах ур чадварыг дээшлүүлэхэд санал, зөвлөмж хүргүүлж ажиллах нь Удирдлагын шинжлэх ухааны онол, арга зүйг судалж буй судлаачийн үүрэг гэж үзэж байна.

Удирдлагын шийдвэр гаргалтын тухай ерөнхий ойлголт

Хүний амьдралд ямар нэг хэмжээгээр шийдвэр гаргах асуудал өдөр тутам үүсэн бий болж байдаг. Энэ утгаараа шийдвэр гаргалт нь хамгийн энгийнээс эхлээд нарийн төвөгтэй байдалд шилжиж, хувь хүний төвшнөөс байгууллага, цаашлаад улс орон, бүс нутаг, даян дэлхийн асуудлыг хэн нэгэн удирдагч, бие хүн шийдвэр гаргасны үр дүнд хэрэгжүүлдэг үйл явц болно.



МУОНГОЛ УЛСЫН
 ХУУЛЬ ЭРХЭМ
 АЖИЛЛАГААНЫ
 АКАДЕМИ

Удирдлагын шийдвэрийг англиар Managerial decision, оросоор “Управленческое решение” гэх агаад үүнийг Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор Я.Шуурав “Асуудал бэрхшээлийг даван туулж, дэвшүүлсэн зорилгод хүрэх арга замуудаас зохих шалгуурын дагуу сонгон авсан боломжит /оновчтой/ хувилбар. Удирдлагын шийдвэр нь үндэслэлтэй, тодорхой томъёологдсон, цагаа олсон, бодитой хэрэгждэг, үр дүн, үр ашигтай байх ёстой” гэж тайлбарлажээ.¹

Нөгөөтэйгөөр “Удирдлагын шинжлэх ухааны судлагдахууны гол цөм нь шийдвэр гаргах үйл явц байдаг. Үүнд л удирдлагын шинжлэх ухааны зүй тогтол, удирдах ажилтны хувийн шинж чанар харагддаг. Нөгөө талдаа аливаа удирдах ажилтны үйл ажиллагааны гол үүрэг бол шийдвэр гаргах явдал байна. Шийдвэр гаргах нь тулгарч буй асуудалд баримжаалах болон түүнийг шийдвэрлэх үйлдлийн хооронд “гүүр” болдог. Энэ “гүүр” хэр оновчтой, бүтээлч, гүйцэтгэл нь хэр сайн байхаас удирдах ажилтны бүхий л үйл ажиллагаа хамаарч байдаг.”² гэж зарим судлаачид тэмдэглэсэн нь бий.

Удирдлагын бүхий л үйл ажиллагаанд шийдвэр гаргах хэрэгцээ өдөр тутамд тулгарч байдаг. Аливаа байгууллагын зорилгыг хангах үйл явцад саад учруулж байгаа тодорхой асуудал, бэрхшээлийг судлан илрүүлж, түүнийг шийдвэрлэх оновчтой арга замыг сонгон хэрэгжүүлэхэд шийдвэр гаргах үйл явцын мөн чанар нь оршдог.

Нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн хурдацтай өөрчлөлт, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ өсөн нэмэгдэж байгаа өнөө үед удирдлагын шийдвэрийн үр өгөөж, чанарыг сайжруулах асуудал нь зүй ёсны хэрэгцээ шаардлага болж байна. Нөгөө талдаа өнөөгийн нөхцөл байдал, гадаад, дотоод орчны нөлөөлөл шийдвэр гаргалтыг илүү төвөгтэй болгож байна. Тухайлбал: Шийдвэрийн сонголтын тоо хэмжээ маш их болсон, шийдвэр гаргалтын үр дагаврын тодорхойгүй байдал нэмэгдсэний улмаас урьдчилан таамаглахад хүндрэлтэй болсон, шийдвэр гаргалтын алдаа, түүний зардал нь их гарах болсон зэрэг болно.

Иймд удирдлагын зүгээс оновчтой шийдвэр гаргахын тулд шинжлэх ухаан, практикаар нотлогдсон олон арга хэрэгсэл, зарчмуудыг танин мэдэж зөв ашиглах нь чухал юм.

Удирдлагын шийдвэр гаргалт нь ихэвчлэн математик статистикийн аргууд болон удирдах бүрэлдэхүүний мэдлэг, ур чадвар, дадлага туршлага, алсын хараа зарим тохиолдолд зөн билгийг өргөнөөр ашигладаг гэж судлаачид олонтой тэмдэглэсэн нь бий.

Гэвч шийдвэр гаргалт нь асуудал бэрхшээлийг олж харахаас эхлээд шийдлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, улмаар хэрэгжилтийг үнэлж, сайжруулах хүртэлх үйл ажиллагааны харилцан уялдаатай үйл явц байдаг учир зарим тохиолдолд нарийн төвөгтэй, тодорхой бус байдал, аливаа үзэгдлийн талаар анхны мэдээлэл дутмаг, тэдгээрийг математик, статистикийн аргуудаар загварчлах боломжгүй байх зэргээс шалтгаалан тодорхой тохиолдлуудад аливаа үзэгдлийн

¹ Я.Шуурав, Ч.Сайнцогт. Удирдлагын шийдвэр боловсруулахад экспертийн үнэлгээний аргыг хэрэглэх нь. УБ., 2011. 7 дах тал.

² П.Увш, Б.Хэрлэн. Байгууллагын зан үйл. УБ., 2017. 137 дах тал.



талаарх гүн бат мэдлэг, түүний хөгжил, ирээдүйн үр дагаврыг шинжлэх ухааны үүднээс урьдчилан харах чадвар, нийгмийн хөгжлийн зүй тогтлыг ухаж ойлгох чадвар, түүхийн ижил төстэй үзэгдлүүдийг адилтган үзэж тооцоолох, жишин харьцуулж оновчтойг сонгох чадварт нь тулгуурлан эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн санал, зөвлөмжийг авч шийдвэр гаргах нь бий. Үүнийг экспертийн үнэлгээний арга гэж нэрлэдэг. Экспертүүд тухайн асуудлыг шийдвэрлэж болох үндэслэл, санал, дүгнэлт гаргадгаас шийдвэрийг зөвхөн эрх бүхий албан тушаалтан гаргадаг гэдгийг тунгааж энэ тохиолдолд удирдах ажилтан системийг бүх талаас нь задлан шинжлэх, системд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох, үнэлэх, үр өгөөж бүхий аргуудыг олж сонгох зэрэг ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай юм.

Удирдлагын шийдвэр гаргах үйл явц

Шийдвэр гаргалт нь аливаа байгууллагын удирдах бүрэлдэхүүний өдөр тутмын ажлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байдаг бөгөөд шийдвэр гаргалт гэдэг нь хэд хэдэн хувилбараас оновчтойг нь сонгох оюуны үйлдэл юм. Шийдвэр гаргах оюуны үйлдэл нь удирдлагын шинжлэх ухааны онолын төлөвлөх, зохион байгуулах, идэвхжүүлэх, хянах функцийн хүрээнд хэрэгждэг. Өөрөөр хэлбэл ямар ажлыг, хэн, хэрхэн хийх, яаж идэвхжүүлж, гүйцэтгэлийг хэрхэн хянах, гарсан ололт, амжилт, алдаа дутагдлыг дүгнэж цэгнэх, засаж залруулах гэсэн асуултад хариулт өгөх цогц үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Шийдвэр гаргахдаа удирдагч урьдчилан харах буюу төсөөлөх, түүнийгээ төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах үүргийг хэрэгжүүлдэг. Шийдвэр гаргалтын үйл явц тухайн шийдвэрийн төрөл, хэлбэр /бүрэн бүтэцлэгдсэн, хагас бүтэцлэгдсэн, бүтэцлэгдээгүй/-ээс үл хамааран үндсэн зургаан үе шатаас бүрддэг.



Зураг 1. Удирдлагын шийдвэр гаргах үйл явц.



Судлаач миний бие хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын тэр дундаа хил хамгаалах байгууллагын удирдах бүрэлдэхүүнд мэдээлэл хүргэх зорилго агуулан энэхүү өгүүллийг бичиж байх тул шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлж буй зарим хүчин зүйлийг дэлгэрүүлж Та бүхнийг цаашид оновчтой шийдвэр гаргахад тус дэм болно хэмээн найдав.

Аливаа байгууллагын удирдлага шийдвэр гаргахдаа дараах зургаан алдааг хамгийн ихээр гаргадаг³ тул зарим тохиолдолд гаргасан шийдвэр үр дүнгүй болж, улмаар байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг болохыг судлаачид тогтоосон байна. Үүнд:

1. Анхны төрсөн сэтгэгдэлдээ автах: Хамгийн түрүүнд авсан мэдээлэлдээ илүү ач холбогдол өгч өөрийн мэдэлгүй уг мэдээлэлдээ тулгуурлан шийдвэр гаргадаг. Гадаад, дотоод орчны тогтворгүй, хувьсал өөрчлөлт ихтэй цаг үед энэ хандлагыг баримтлах нь алдаатай таамаглал дэвшүүлж улмаар буруу шийдвэр гаргах эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

Иймд аливаа төвшний удирдах албан тушаал хашиж буй хүмүүс мэдээллийг олон талаас нь авч мэдээлэлдээ задлан шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд экспертүүдээс санал, зөвлөгөө авч байх нь зүйтэй.

2. Урьд өмнө гаргасан шийдвэрээ илүү дагах: Бидний хэн ч ялгаагүй өмнөх гаргасан шийдвэрээ баталгаажуулсан сонголтыг хийж алдаа гаргадаг.

Иймд шийдвэр гаргахдаа урьд гаргасан ямар нэг шийдвэрийг дагах, давтах бус тухайн нөхцөл байдлаа сайтар үнэлэх нь чухал юм.

3. Өөрийн хүсч байгаага бодит байдал гэж үзэх: Хүмүүс өөрт таалагдсан, өөрийнх нь санаа бодол, таамаглалыг батлахуйц мэдээллийг илүүтэй хүлээн авч түүний эсрэг мэдээлэл, өгөгдлүүдийг зүгээр л үгүйсгэж шийдвэр гаргадаг.

Эн тэргүүнд байгууллага, хамт олны эрх ашгийг дээгүүрт тавьж шийдвэр гаргах нь чухал бөгөөд энэ нь алдаатай шийдвэр гаргахаас сэргийлэх боломжийг нэмэгдүүлнэ.

4. Нэгэнт олж авсан байр сууриа хадгалахыг эрмэлзэх: Заримдаа удирдагчид өөрийн зөв гэсэн хувилбар дээр хатуу зогсож, шинэ арга зам хайх, нэмэлт мэдээлэл болон өөр боломжит технологийг сонгох тухайд авч үзэхийг хүсдэггүй.

Иймд асуудалд хэт нэг талыг барьж, өөрийн санаа бодлыг хүчээр тулгахгүйгээр байгууллагын зорилго, стратегитай уялдуулан аливаа асуудлын голыг болон шийдлийг олж харах нь чухал юм.

5. Асуудлын томъёололд хэт баригдах: Тухайн асуудлыг томъёолохдоо хариуцлагатай хандаж боломжит хувилбаруудаас аль нь илүү үр дүнд хүрэхийг нь нарийн тооцохгүйгээр хэт их үг, үсгээр хөөцөлдөх нь зарим тохиолдолд алдаатай шийдвэр гаргахад хүргэдэг.

6. Ямар ч үндэслэлгүйгээр хэт найдвар тавих: Тодорхой бус үр дүнг таамаглахдаа өөрийн авьяас чадварыг хэтэрхий үнэлэх явдал цөөнгүй байдаг.

Иймд аль ч төвшний удирдлага тухайн асуудлыг мэдэж байсан ч гэсэн эцсийн шийдвэрийг гаргахын урьд дахин магадлах, мэдээлэлд үнэлгээ шинжилгээ хийх нь нэн чухал болно.

³ Д.Ганбаатар, Я.Шуурав, Д.Сэржамц. "Менежмент". УБ., 2017. 223 дах тал.

Түүнчлэн бүх шатны удирдах албан тушаалтан шийдвэр гаргахдаа:

- Үр өгөөжтэй байх;
- Үндэслэл сайтай байх;
- Цаг үеэ олсон байх;
- Хэрэгжих боломжтой бодитой байх;
- Тодорхой байх;
- Чанд хатуу болон уян хатан байх чанарыг хослуулах;
- Эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзан үзэх гэсэн зарчмуудыг баримтлах нь зүйтэй.

Удирдлагын шийдвэр гаргах аргууд

Удирдлагын шинжлэх ухааны эрдэмтэн судлаачид экспертийн аргаас гадна удирдлагын шийдвэр гаргалтыг оновчтой болгох олон аргуудыг боловсруулж ирсэн бөгөөд эдгээр аргуудыг ямар төрлийн шийдвэрт хэрэглэгдэж байгаагаар нь бүлэглэдэг байна. Тухайлбал: Удирдлагын шийдвэрт бодит байдалтай адилтгах загварчлал, шийдвэрийн хүснэгт, шийдвэрийн салаа мөчир буюу мод, тоглоомын онол, шугаман програмчлал, хугарлын цэгийн шинжилгээ, дарааллын загвар гэх зэрэг олон аргыг ашиглаж байна.

Шийдвэр гаргалтын загварууд: Шийдвэр гаргах явцад удирдагчийн сонгож авдаг загварыг *сонгодог, захиргааны болон улс төрийн* гэж ангилдаг. Аль загварыг сонгох нь тухайн удирдагчийн хувь хүний онцлог, шийдвэр хэр зэрэг програмчлагдсан байх, мөн эрсдэл, итгэл төгс бус байх эсвэл нөхцөл байдлын тодорхой бус байдлаас шалтгаалдаг.

Сонгодог загвар: Шийдвэр гаргах сонгодог загвар нь эдийн засгийн үндэслэл ямар байгааг голлон авч үздэг. Байгууллагын эдийн засгийн ашиг нэн түрүүнд удирдлагын шийдвэртэй уялдаж байх учиртай.

Захиргааны загвар: Хүнд төвөгтэй нөхцөлд удирдлагын шийдвэрийг яаж гаргах ёстой талаар захиргааны загварт голлон тайлбарладаг ба онолын талаас яаж шийдэх тухайд тулгалт хийдэггүй онцлогтой.

Улс төрийн загвар: Энэ загварыг програмчлагдаагүй шийдвэр гаргахад голлон ашигладаг бөгөөд дөрвөн үндсэн дүгнэлт дээр суурилдаг. Эдгээрийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Шийдвэр гаргах сонгодог, захиргааны болон улс төрийн загваруудын үзүүлэлтүүд

Сонгодог загвар	Захиргааны загвар	Улстөрийн загвар
-Зорилго тодорхой, асуудлаа бүрэн ойлгодог; -Нөхцөл байдлын талаар бүрэн ойлголттой; -Шийдлүүд болон боломжит үр дүнгийн тухайд хангалттай мэдээлэл авдаг; -Хамгийн сайн үр дүнд хүрэхүйц оновчтой хувилбарыг сонгодог.	-Асуудал болон зорилго төдийлөн тодорхой бус; -Нөхцөл байдлын тухай зарим зүйл тодорхой бус; -Шийдлүүд болон боломжит үр дүнгийн тухай мэдээлэл хангалттай бус; -Өөрийн мэдрэмж болон бүлгийн хэлэлцүүлгийн дүнд байж болох хувилбар сонгодог.	-Олон эшт үзэл бодол, зорилгын талаар зөрчилтэй; -Итгэл төгс бус байх, тодорхой бус байдал; -Санал зөрөлдөөн, мэдээллийн тодорхой бус байдал; -Гишүүдийн дунд хэлэлцүүлэг өрнөж, "хэлцэл" хийгддэг.



МОНГОЛЫН
ХУУЛЬ ТАСЛАХ
УНИВЕРСИТЕТ
LAW ENFORCEMENT
UNIVERSITY

Шийдвэрийн хүснэгтийн арга: Асуудлын бүх боломжит үр дүнг нэгэн зэрэг харьцуулан шалгадаг арга юм. Шийдвэрийн хүснэгтийн аргыг тодорхой, эрсдэлтэй, тодорхой бус гэсэн гурван нөхцөлийн дор ашиглаж болдог.

Тоглоомын онол: Энэ онол нь маргаант нөхцөл байдлыг тоон шинж чанарыг шинжлэн судалдаг бөгөөд Ямар аргаар үйл ажиллагаагаа явуулах вэ?, Ямар үр дүнд хүрч болох вэ? гэсэн хоёр асуултад хариулт өгдөг. Гаргасан шийдвэр нь өрсөлдөгчдөд хэрхэн нөлөөлөхийг үнэлэх загварчлалын аргыг тоглоомын онол гэнэ.⁴ Тиймээс энэхүү онолыг тодорхой бус нөхцөл байдалд, маргаантай үед гаргах шийдвэрийг сонгох математик гэж ч тодорхойлдог. Жишээ: хоёр болон түүнээс дээш тооны өөр өөр үзэл бодол, зорилготой хүмүүсийн маргаан бөгөөд нөгөө талаа өөртөө татаж өөрийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрүүлэх явдал юм.

Салаа мөчрийн арга: Шийдвэрийн мод нь хувилбарууд дотроос хамгийн үр дүнтэй чиглэлийг сонгоход ашиглагддаг. Шийдвэрийн салаа мөчир гэдэг бол шийдвэр гаргах асуудлын бүдүүвчилсэн төсөөлөл юм.⁵ Шийдвэрийн мод нь хувилбар тус бүрээр үр дүнг жиших, түүнийг байж болох магадлалуудаар нь засаж залруулах, дараа нь харьцуулж, оновчтойг нь сонгон шийдвэр гаргах боломж олгодог. Энэхүү загварын харагдах байдал нь модтой адил учир ийн нэрийдсэн байна.

Хяналтын асуултын жагсаалт гаргах арга: Энэхүү арга техникийг удирдахуйн шинжлэх ухаанд өргөн ашиглаж иржээ. Ялангуяа шинэ санаа, шийдвэр гаргах хувилбарыг авч үзэх шатанд голлон хэрэглэдэг. Тухайн арга нь асуудлыг олон өнцгөөс авч үзэх бүтээлч сэтгэлгээг дэмжиж идэвхжүүлэх хөшүүрэг ашиглахад илүү тохиромжтой.

Тодорхой хэсэгт салган задалж, шинжилгээ хийх арга: Өөрчлөх, сайжруулах шаардлагатай байгаа эд юмсын үндэслэлийг нарийвчлан судалж, гаргаж байгаа шийдвэрээ баталгаажуулах зорилгоор тухайн тоног төхөөрөмжийг салган задалж, хэсэг тус бүрт дүн шинжилгээ хийж болно. Анализ, синтез, хийсвэрлэх, дотоод зүй тогтлыг илрүүлэх зэрэг сэтгэхүйн үйлдлүүд шаардсан арга юм.

Зардал ба үр ашгийг харьцуулан задлан шинжлэх арга: Цаг хугацаа болон санхүүгийн хязгаарлагдмал орон зайн хүрээнд дотоод нөөц боллоцоо, ухаан самбаагаа дайчлан ашиглах замаар тодорхой үр дүнд хүрэх арга замыг эрэл хайгуул хийх, хурдан шуурхай, эрсдэл багатай шийдвэр гаргахад энэ арга техникийг ашиглаж иржээ. Энэ аргыг хэрэглэхэд дараах гурван нөхцөл чухал байдаг. Үүнд: Багаар ажилладаг хөдөлмөр зохион байгуулалттай хамт олон тухайн аргыг хэрэглэхэд илүү тохиромжтой.

SWOT шинжилгээний арга: Байгууллагын гадаад, дотоод орчныг шинжилсний үр дүнд үндэслэл сайтай, үр ашигтай, баталгаатай шийдвэр гаргахад SWOT шинжилгээний аргыг өргөн хэрэглэдэг.

Сүүлийн үед байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ өсөн нэмэгдэж байгаатай холбоотой дан ганц SWOT шинжилгээний аргыг ашиглаж шийдвэр

⁴ Т.Дорж, Ү.Чимэд. Менежмент. УБ., 2000. 134 дэх тал.

⁵ Х.Лутчимэг, Н.Дамдинсүрэн. Удирдахуйн ухаан. УБ., 2015. 55 дах тал.

гаргах нь хангалттай бус болж орчны шинжилгээний PEST, PESTLE, PESTIE, TOWS, ETOP, SAP зэрэг олон аргуудыг удирдлагын шинжлэх ухаанд өргөнөөр ашиглаж байна.

Бусдын гаргаж байгаа санаа бодлыг сонсож, тодруулах арга:

Харилцагчаа идэвхтэй сонсож, өөрийн санаа бодлыг эмх цэгцтэй, товч тодорхой илэрхийлэх удирдагчийн харилцааны ур чадвараас шийдвэр гаргалтын үр дүн шалтгаалж байдаг. Санаа бодлоо цэгцлэх, хүнд нөхцөл байдлаас хурдан гарах, оновчтой зөв шийдвэр гаргахад бусдын санаа бодлыг сонсох, тодруулах арга техник чухал санаа эрсдэлийг зогсоох, асуудлыг эергээр эргүүлэх хүчтэй нөлөөтэй.

Дүгнэлт

Удирдлагын шийдвэр гаргалтыг ийнхүү судалж үзэхэд удирдлагын үйл ажиллагааны эцсийн бүтээгдэхүүн нь шийдвэр гаргалт бөгөөд удирдлагын аливаа шийдвэр гаргах үйл явц нь асуудлыг тал бүрээс нь судлах, задлан шинжлэх, шийдлийн хувилбарууд боловсруулах, оновчтой хувилбарыг сонгох, хэрэгжүүлэх, хянах зэрэг олон шат дамжлагаар дамжин хэрэгждэг үйл явц учраас шийдвэр гаргагчаас өндөр ур чадвар, онолын болон практик мэдлэг, туршлагыг шаарддаг.

Өөрөөр хэлбэл шийдвэр нь тухайн удирдах ажилтнаас ажил хэргийн талаарх мэдлэг, овсгоо, самбаа, шийдэмгий гярхай байдал, олон хувилбараас онож сонгох чадвар, зөн билэг, орчны нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэх ойр болон ирээдүйг урьдчилан харах нарийн мэдрэмжийг шаардаж байдаг байна.

Хил хамгаалах байгууллагын тактикийн төвшний удирдлага буюу отрядын дарга нь зөвлөх эрх бүхий даргын зөвлөлийн 10 гишүүнтэй ажилладаг байна. Эдгээр гишүүд нь захирагчид аливаа асуудлаар санал, зөвлөмж өгөх бөгөөд эцсийн шийдвэрийг захирагч гаргах эрхтэй байдаг байна. Энэ нь цэргийн удирдлагын захирагч төвтэй шийдвэр гаргалтын хэлбэр болно.

Тус Академийг Хууль сахиулах удирдлага, Хилийн удирдлага, стратеги-тактик мэргэжлээр төгссөн магистр хийж байсан судалгааны ажлын сэдэвтэйгээ уялдуулан 2016, 2017 онд хилийн ...дугаар найман анги, Хууль сахиулахын их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн хил судлалын магистрантууд, мөн Их сургуулийн Хилийн сургуулийн бакалаврын эчнээ дамжааны суралцагчид зэрэг нийт 947 хүнээс авсан асуулгын болон эмпирик төвшний судалгаа хийснийг нягтлан үзэхэд *"...Удирдлагын эрх мэдлийн төвлөрөл ихтэй, бүлгийн гишүүдийн оролцоо бага, төлөөлүүлэн удирдах үйл явцад анхаарал бага тавьдаг байгууллагын фаталист соёл, удирдлагын автократ арга барилтай дарга, захирагч нар их."* гэсэн судалгааны дүн гарсан байдаг.

Түүнчлэн дийлэнх отрядын даргын зөвлөлийн гишүүд нь захирагчийн шийдвэрийг хэлбэрэлтгүй даган хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч субъект нь байдаг гэжээ.

Цэргийн удирдлагын шийдвэр гаргалтыг олон улсад захирагч төвтэй болон штаб төвтэй шийдвэр гаргалт гэж ангилдаг бөгөөд дээрх судалгааны дүнгээс үзэхэд хил хамгаалах байгууллага нь ихэвчлэн захирагч төвтэй шийдвэр гаргалтыг хэрэгжүүлдэг байна. Энэ нь нэг талаас цагийн байдлын гэнэтийн өөрчлөлт, хилийн эрэл, онцгой нөхцөл байдалд шуурхай шийдвэр гаргах, хойшлуулшгүй мөрдөх ажиллагааны үед зорилгоо чухалчлан эрх мэдлийг төвлөрүүлж, дэг журмыг тогтооход давуу талыг бий болгох хэдий ч нөгөө талдаа дараах сөрөг





талтай байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Удирдагчийн дан ганц үзэл бодлоос шалтгаалсан шийдвэр нь хамт олны сэтгэл ханамж, албанд хандах хандлагад сөргөөр нөлөөлж, албандаа болон өөртөө итгэлгүй болох байдал давамгайлж, хяналт шалгалт ихсэх, хиймэл ачаалал, стресс үүсгэх, үр дүн ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж зөвхөн удирдлагын шийдвэрийг л хүлээдэг, бүтээлч бус, хайрцаглагдсан сэтгэхүй давамгайлах байдлыг үүсгэдэг.

“Хилийн отряд, ангиудын үндсэн үйл ажиллагааны гуравны хоёроос дээш хувь нь өдөр тутмын захиргааны шинжтэй шийдвэр гаргаж байна” гэж Архивын ерөнхий газраас 2015 онд зохион байгуулсан улсын үзлэгийн нэгдсэн илтгэх хуудсанд тэмдэглэгдсэн байх бөгөөд үлдсэн нэг орчим хувь нь л цагийн байдлын өрнөлтийн үед гаргадаг мэргэжлийн удирдлагын шийдвэр байна.

Иймд хил хамгаалах байгууллагын бүх шатны удирдлагууд штаб төвтэй шийдвэр гаргахад анхаарч, байгууллагад үүсч болох нөхцөл байдал, эрсдэлийг урьдчилан харж, таамаглах, тооцоолох, тухайн нөхцөл байдалд бүлгийн шийдвэр гаргах, тохирох хувилбар, загварчлалуудыг боловсруулж, албаны бэлэн байдлыг хангасан байхад үйл ажиллагаагаа чиглүүлэх нь цаашид хил хамгаалах байгууллагын хөгжил, соёлд эергээр нөлөөлж болох юм гэж үзлээ.

Санал

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа урьдчилан таамаглахад адармаатай, цаг үеийн шинжтэй хүндрэлтэй асуудлуудтай байнга тулгарч байдаг тул удирдлагын шинжлэх ухааны дэвшилттэй шийдвэр гаргах загвар, хандлагуудыг цэргийн шинжлэх ухааны онол, арга зүйтэй хослуулах замаар бүх шатны удирдах бүрэлдэхүүний үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлж болох талтай.

Байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хэвшмэл загвараас салж, оролцоонд тулгуурласан, эрх мэдлийг хуваарилсан, төлөөлүүлэн удирдах үйл явц, бүлгийн шийдвэр гаргах ажиллагаанд суралцах шаардлагатай гэсэн саналыг судлаачийн зүгээс тус тус дэвшүүлж байна.

Эцэст нь тэмдэглэхэд удирдлагын шийдвэр нь албан хаагч нэг бүрийн хүсэл зорилго, эрх ашигт нийцэх бус харин байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бүтээмжийг дээшлүүлэх, ажил үүргийн уялдаа холбоог төгөлдөржүүлэх, албан хаагчдын нийтлэг эрх ашгийг хангаж, хамгаалахад чиглэгдэж, хуульд нийцсэн байх ёстой.

Ашигласан эх сурвалж

1. Д.Ганбаатар, Я.Шуурав, Д.Сэржамц. “Менежмент”. УБ., 2017.
2. П.Увш, Б.Хэрлэн. “Байгууллагын зан үйл”. УБ., 2017.
3. Х.Лутчимэг, Дамдинсүрэн. “Удирдахуйн ухаан”. УБ., 2015.
4. Ц.Цэрэндорж, С.Цэрэндамба. “Бидний менежмент”. УБ., 2010.
5. Я.Шуурав, Ч.Сайнцогт. “Удирдлагын шийдвэр боловсруулахад экспертийн үнэлгээний аргыг хэрэглэх нь”. УБ., 2011.
6. Т.Дорж, Ү.Чимэд. “Менежмент”. УБ., 2000.

ХИЛ ДАМНАСАН БОЛОН ХИЛ ОРЧМЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛД

CHALLENGES FACING CROSS-BORDER ROAD FREIGHT TRANSPORTATION

М.Дэлгэрнасан

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургууль

Delgernasan M.

School of Mechanical Engineering and Transportation,
Mongolian University of Science and Technology

Э.Чанцалдулам

"Автотээврийн үндэсний төв" Төрийн өмчит үйлчилгээний газар

Chantsaldulam E.

"National Center for Road Transportation" State Owned Enterprise

✉ deegii@must.edu.mn

Товч агуулга: Манай орны хувьд улс хоорондын байнгын ачаа тээвэрт зонхилох ачаа нь уул уурхай, ашигт малтмалын тээвэрлэлт байдаг бөгөөд үүний дийлэнхийг нүүрсний тээвэрлэлт эзэлдэг.

Энэхүү судалгааны хүрээнд хил дамнасан болон хил орчмын нүүрсний экспортын тээвэрлэлтийн өнөөгийн байдлыг судлан тээвэрлэлтийн төлөв байдлыг тодорхойлсны үндсэн дээр төлөвлөлт, зохион байгуулалтын аргыг санал болгож тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорилоо.

Үүний тулд хил дамнасан болон хил орчмын тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн ашиглалтын үзүүлэлтэд тулгуурлан нэг рейсийн зардал, өртөг, ашиг орлогын шинжилгээг нүүрсний тээвэрлэлтийн гурван янзын замналын хувьд тооцон харьцуулалт хийн тээврийн зохион байгуулалтыг олборлогч, тээвэрлэгч, зам эзэмшигч, хил гаалийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, хяналтын тогтолцоог бүрдүүлэн, нэгдсэн удирдлагаар хангах боломжтой программ хангамжийн тусламжтайгаар шийдвэрлэх, тээврийн хэрэгслийн дарааллын улмаас гарах зардлыг тооцоолон бодитоор хянах боломжтой болохыг дүгнэж байна.

Abstract: In Mongolia, freight flow crossing the borders of neighboring countries are mainly consisted of minerals and mining products. Specially coal transportation is dominating in cross-border road freight transportation today.

This study aims to investigate coal export transportation near border area and construct solutions to facilitate cross-border coal transportation. Based on approved method, statistic data and survey conducted with drivers, the transportation costs are calculated for 3 different routes, explored and modeled the costs related to queue to cross the border. This paper emphasizes the importance of the collaboration and connections among mining company, road company, transportation operators and border and custom organization. Therefore it suggested the use of the integrated software to organize entire coal exporting chain effectively.

Түлхүүр үгс: Хил дамнасан тээвэрлэлт, төлөвлөлт, зохион байгуулалт, рейс, зардал, боомт, ачаа, тээврийн хэрэгсэл

Keywords: cross-border transportation, transport planning, haul, cost, dry port, freight, vehicle



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН
ТӨСӨӨГӨЙ
ХАМГААГАХ
ЯМ

Оршил

Монгол улс ОХУ-тай 29, БНХАУ-тай 12 нийт 41 боомтоор харилцдаг. Үүний 20 нь автозамын хилийн боомт юм. Хилийн боомтууд аймгийн төвүүдээс 241 км, хамгийн хол нь 455 км зайд байрладаг. БНХАУ-тай хиллэдэг түр болон байнгын ажиллагаатай 8 боомтоор 16 уурхайгаас улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэж байна.

Улс хоорондын байнгын ачаа тээвэрт зонхилох ачаа нь уул уурхай, ашигт малтмалын тээвэрлэлт байдаг бөгөөд үүний дийлэнхийг нүүрсний тээвэрлэлт эзэлдэг. Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтоор газрын тос, нүүрс, төмрийн хүдэр, Дорноговь аймгийн Ханги боомтоор нүүрс, төмрийн хүдэр, Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтоор нүүрс, зэсийн баяжмал болон Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтоор нүүрс, төмрийн хүдрийн экспортын тээвэрлэлт хийгдэж байна.


Хил дамнасан нүүрсний экспортын тээвэрлэлт нь эдийн засгийн хувьд өгөөжтэй боловч зөв зохистой төлөвлөлт, оновчтой зохион байгуулалтгүйгээс тээвэрлэлтийн гүйцэтгэлд цаг хугацаа, зардлын асуудал хөндөгдөхөөс гадна тэнд ажиллагчдын эрүүл мэнд, нийгмийн зэрэг олон асуудал тулгамдаад байна.

Энэхүү илтгэлд Тавантолгойн орд газраас Гашуун сухайт, БНХАУ-ын Ганц мод боомтын чиглэлд хийгдэж байгаа нүүрсний тээвэрлэлтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилгоо.

1. Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн өнөөгийн байдал

Автозамын хилийн боомтуудаар улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийг 2017 онд 10 чиглэлд 241 ААНБ-тай тээвэрлэлтийн гэрээ байгуулан 11125 хүнд даацын автомашин, 8804 мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэн 33,2 сая.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21,0%-иар өссөн үзүүлэлттэй байна.

График 1. Монгол Улсын автозамын хилийн боомтоор нэвтэрсэн ачаа урсгалын хэмжээ хувь /сая.тн/



Экспортын голлох бүтээгдэхүүнүүдийг төрлөөр нь авч үзвэл 2017 онд нүүрс 29.6 сая.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21%-иар, төмрийн хүдэр 1,150.6 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8 дахин тус тус өссөн бол зэсийн баяжмал 652.1 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 24.8%-иар, газрын тос 859.9 мян.тн тээвэрлэсэн нь өмнөх оноос 10%-иар нь тус тус буурсан байна.


Хүснэгт 1. Экспортын голлох бүтээгдэхүүний төрөл

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2015 он	2016 он	2017 он
1	Нүүрс	/мян.тн/	12,557.50	24,388.20	29,698.40
2	Газрын тос	/мян.тн/	1,043.40	957,0	859,9
3	Төмрийн хүдэр	/мян.тн/	965,5	13,0	1,150.60
4	Зэсийн баяжмал	/мян.тн/	857,7	867,8	652.1
	Нийт дүн	/мян.тн/	15,402.10	26,226.00	32,361.50

Эх сурвалж: АТҮТ-ийн зохицуулалтаар

Судалгаанаас харахад нүүрсний экспортын хэмжээ 2015 оноос тасралтгүй өсөж, бусад ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хэмжээтэй харьцуулбал нийт бүтээгдэхүүний 94%-ийг эзэлж байна.

График 2. Экспортлогдож байгаа ашигт малтмалыг хувиар



Автозамын хилийн боомтуудаар тээвэрлэж байгаа Монгол улсын ашигт малтмалын экспортын бүтээгдэхүүнийг хэмжээг судалж үзвэл Өмнөговь аймгийн Гашуун сухайт боомтоор 55%, Шивээхүрэн боомтоор 32%, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор 4%, Дорноговь аймгийн Ханги, Булган болон Бичигт боомтуудаар 2%, Баянхошуу боомтоор 1% нь тээвэрлэгдсэн байна.


2. Өмнөговь аймгийн Гашуун сухайт хилийн боомтоор экспортлогдож байгаа нүүрсний тээвэрлэлтийн байдал

Өмнөговь аймаг дахь Гашуунсухайт боомтоор 2017 онд импортлогдож байгаа бараа нь салхин сэнс болон тоног төхөөрөмж байгаа бол экспортлогдож байгаа бараа бүтээгдэхүүнд ашигт малтмал, нүүрс зонхилж байна. Нүүрсний экспортын хэмжээг сараар авч үзвэл 5-6 саруудад өсөлттэй, 8-12 сар хүртэл хамгийн өндөр ачаалалтай байдаг.

Сүүлийн хоёр жилд тус боомтоор экспортлогдсон нүүрсний тоо хэмжээ өсөхийн зэрэгцээ тэнд ажиллах тээврийн хэрэгслийн тоо эрс өссөн байгаа нь ашигт малтмалын тээвэрлэлтийн төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож зохистой хяналтыг тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатайг харуулж байна.

Гашуун сухайтын боомтоор 2017 онд Тавантолгой Ухаа худгийн уурхайгаас “Эрдэнэс тавантолгой” ХК, “Орон нутгийн Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК нь 17,2 сая.тн нүүрс экспортолсон нь өмнөх оны мөн үеэс 32%-иар өссөн үзүүлэлттэй байна.

График 3. Гашуун сухайт боомтоор экспортлогдсон нүүрсний хэмжээ жилээр хувь /мян.тн/



2017 онд экспортолсон нийт нүүрсний хувь хэмжээг уурхай тус бүрээр нь авч үзвэл Эрдэнэс таван толгой 49%, Энержи ресурс 26%, Тавантолгой 6%, Цагаан хадны гаалийн хяналтын бүсээс 19% нь тээвэрлэгдсэн байна.

График 4. Экспортлогдсон нүүрсний хэмжээг уурхайгаар /хувь/




Увс Аймаг Цагдаагийн Газар

2017 оны байдлаар тус боомтоор нүүрсний экспортын тээвэрлэлтийг 127 аж ахуйн нэгж, байгууллагын 7853 хүнд даацын тээврийн хэрэгсэл, 7500 мэргэшсэн жолоочтой гүйцэтгэсэн байна.


Хил дамнасан экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг үнэлэх, тээврийн хэрэгслийн ашиглалт, тээвэрлэлтийн зардлыг тооцоолоход шаардлагатай зарим мэдээллийг цуглуулах зорилгоор Тавантолгойн нүүрсний уурхайгаас Гашуун сухайтын чиглэлд улс хоорондын ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч 120 жолоочоос асуулгын аргаар судалгаа авч үр дүнг гаргахад дараах үр дүн гарлаа. Судалгаагаар тээврийн хэрэгслийн марк, шатахуун зарцуулалт, шатахууны зардал, замд дараалалд зогсоон өнгөрөөдөг хоногийн дундаж тоо, тогтмол чиглэлд сард гүйцэтгэж байгаа рейсийн тоо, цалин урамшуулал зэрэг мэдээллийг цуглуулан үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон.

График 5. Судалгаанд оролцсон жолооч нарын нас




Судалгаанд оролцогчдын 27.0% нь 20-30 насны, 39% нь 31-40 насны, 17% нь 41-50 насны, 17.0% нь 50-иас дээш насны жолооч нар байсан.

График 6. Гашуун сухайт боомтоор сард тээвэрлэлт гүйцэтгэдэг рейсийн тоо




Сард Гашуун сухайт боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлт гүйцэтгэдэг нийт тээврийн хэрэгслийн 35% нь 1 рейс, 54% нь 2 рейс, 8% нь 3 рейс, 3% нь 4 рейс гүйцэтгэдэг байна.

График 7. Тээврийн хэрэгслийн дараалалтай үеийн түлш зарцуулалт хувиар



Гашуун сухайт боомтоор тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэл нь дунджаар 10-14 хоног дараалалд зогсохдоо зуны 350-400 литр, өвлийн нөхцөлд 401-500 литр түлш зарцуулж байна. .

График 8. Тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн марк



Тээвэрлэлт гүйцэтгэж байгаа 7853 хүнд даацын тээврийн хэрэгслийг марк төрлөөр нь авч үзвэл, нийт тээврийн хэрэгслийн 72%-ийг Nord benz маркийн автомашин эзэлж байна.

3. Тээвэрлэлтийн зардлын тооцоо

Хил дамнасан нүүрсний тээвэрлэлтийн нэг рейсийн зардлыг Nord benz маркийн тээврийн хэрэгслийн техник ашиглалтын үзүүлэлтүүд, автомашин, чиргүүл, дугуйн гүйлтийн норм, цалингийн хэлэлцээрт заагдсан жишиг үзүүлэлтүүдийг ашиглан тооцож үзэхэд дараах үр дүн гарч байна..

Хүснэгт 2. Техникийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	NORTH BENZ (ND9140)		
			Замнал 1 /478 км/	Замнал 2 /46 км/	Замнал 3 /432 км/
			тоогоор		
1	Нэг талын тээврийн зай	км	239	23	216
2	Машин, чиргүүлийн дугуйны тоо	ширхэг	22	22	22
3	Чиргүүлийн жин	тонн	18	18	18
4	Ачааны жин	тонн	70	95	70
5	Ачаатай явалтын тоо	тоо	1	1	1
6	Гүйцэтгэх ажил	км*тн	16730	2185	15120
7	Нийт гүйлт	км	478	46	432
8	Нэг литр шатахууны үнэ ӨМ-т	төгрөг	2,000	2,000	2,000
9	Нэг машины зах зээлийн үнэ	төгрөг	100,000,000	100,000,000	100,000,000
10	Машины гүйлтийн норм	км	350,000	350,000	350,000
11	Чиргүүлийн үнэ	төгрөг	30,000,000	30,000,000	30,000,000
12	Чиргүүлийн гүйлтийн норм	км	350,000	350,000	350,000
13	Дугуйны үнэ	төгрөг	570,000	570,000	570,000
14	Дугуйны гүйлтийн норм	км	45,000	45,000	45,000
15	Хоногийн дундаж гүйлт	км	239	23	216
16	Жолоочийн дундаж цалин	төгрөг	850,000	850,000	850,000

Тайлбар: 1. Судалгаагаар авсан тоо

2. Норм нормативаас авсан тогтмол тоо

Nord Benz маркийн автомашины чирэгч нь 28 тн, чиргүүл нь 18 тонн жинтэй болно.



Тээвэрлэлтийн I замналын хувьд шатахууны нийт зардал 1,189,503 төгрөг, шатах тослох материалын зардал нийт шатахууны 5% тооцогдож¹ 59,475 төгрөг, сэлбэг хэрэгсэл мөн шатахууны 6%, буюу 71,370 төгрөг, тээврийн хэрэгслийн элэгдэл 310,746 төгрөг, шууд зардал 1,717,639 төгрөг, нийт зардал 2,078,343 төгрөг бөгөөд өөрийн өртөг 124.2 төгрөг болж байна.

Тээвэрлэлтийн II замналын хувьд шатахууны нийт зардал 134,308 төгрөг, шатах тослох материалын зардал нийт шатахууны 5% тооцогдож² 6,715 төгрөг, сэлбэг хэрэгсэл мөн шатахууны 6% буюу 8,058 төгрөг, тээврийн хэрэгслийн элэгдэл 29,904 төгрөг, шууд зардал 265,532 төгрөг, нийт зардал 321,294 төгрөг бөгөөд өөрийн өртөг 147.0 төгрөг болж байна.

Тээвэрлэлтийн III замналын хувьд шатахууны нийт зардал 1,075,032 төгрөг, шатах тослох материалын зардал нийт шатахууны 5% тооцогдож³ 53,751 төгрөг, сэлбэг хэрэгсэл мөн шатахууны 6% буюу 64,501 төгрөг, тээврийн хэрэгслийн элэгдэл 280,841 төгрөг, шууд зардал 1,560,672 төгрөг, нийт зардал 1,888,413 төгрөг бөгөөд өөрийн өртөг 124.9 төгрөг болж байна.

Хүснэгт 3. Нэг тонн километрийн өртгийн тооцоо

№	Үзүүлэлт Нэг талын тээврийн зай	Хэмжи х нэгж	NORTH BENZ (ND9140)		
			Замнал 1 /478 км/	Замнал 2 /46 км/	Замнал 3 /432 км/
<i>Шатахуун зардалын тооцоо /дизель/</i>					
1	Үндсэн норм Нс	литр	30	30	30
2	Чиргүүлийн нэмэгдэл Нч	литр	31.05	31.05	31.05
3	Хүйтний нэмэгдэл Нх (5%)	литр	1.5	1.5	1.5
4	Замын нөхцлийн нэмэгдэл Нз (5%)	литр	1.5	1.5	1.5
5	100 км-т зарцуулах шатахуун	литр	64.05	64.05	64.05
6	100 ткм-т зарцуулах шатахуун	литр	1.725	1.725	1.725
7	Нийт шатахууны зарцуулалт	литр	594.8	67.2	537.5
8	Нийт зарцуулсан шатахууны үнэ	төгрөг	1,189,503.0	134,308.5	1,075,032.0
9	Шатах тослох материал (5%)	төгрөг	59,475.2	6,715.4	53,751.6
10	Сэлбэг хэрэгсэл (6%)	төгрөг	71,370.2	8,058.5	64,501.9
<i>Элэгдэл</i>					
1	Машины элэгдэл	төгрөг	136,571	13,143	123,429
2	Чиргүүлийн элэгдэл	төгрөг	40,971	3,943	37,029
3	Дугуйн элэгдэл	төгрөг	133,203	12,819	120,384
4	Нийт элэгдэл	төгрөг	310,746	29,904	280,841
<i>Бусад зардал</i>					
5	Жолоочийн цалин, шимтгэл (12%)	төгрөг	86,545	86,545	86,545
6	Шууд зардлын дүн	төгрөг	1,717,639	265,532	1,560,672
7	Шууд бус зардал (шууд зардлын 21%)	төгрөг	360,704.3	55,761.8	327,741.1
8	Нийт зардлын дүн	төгрөг	2,078,343.6	321,294.0	1,888,413.3
9	Өөрийн өртөг	төгрөг	124.2	147.0	124.9

¹ Монгол Улсын Зам, тээврийн сайдын 2013 оны "Автотээврийн тариф тооцох зөвлөмж"

² Мөн тэнд.

³ Мөн тэнд.

Зардлын тооцоог боловсруулахдаа дараах томъёоллыг ашигласан болно.

$$\text{Чиргүүлийн нэмэгдэл} = \text{Чиргүүлийн жин} \cdot 1,7 \text{ буюу } 18 \cdot 1,7 = 31,0$$

$$\text{Хүйтний нэмэгдэл} = \frac{\text{үндсэн нормыг} \cdot 5}{100}; \frac{30 \cdot 5}{100} = 1,5$$

Өртгийн тооцоог тээврийн хэрэгслийн боомтоор нэвтрэх дарааллаас үүдсэн хүлээлгэд зогссоноос нэмэгдэх хувьсах зардлыг бодолцвол шатахуун зарцуулалт, шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн болон автомашин, чиргүүлийн элэгдлийн зардлууд нэмэгдэнэ. Судалгаанаас хүлээлгийн улмаас сард дунджаар 10-14 хоног ачаатайгаар зам дээр зогсдог, автомашины насжилтаас хамааран ачаатай талдаа 450-500 литр шатахуун зарцуулдаг байна. Эндээс нэг рейсд гарах шатахууны бодит зарцуулалт нормоор тооцсоноос 100,5 литрээр илүү байна. Энэхүү нэмэлт зарцуулалтыг хүлээлгийн дундаж хугацаа 12 хоногт тооцон тослох материалын болон сэлбэгийн зардлыг хувьчлан авч үзэхэд цаг тутамд 1521,4 төгрөг, харин автомашин чиргүүлийн ашиглалтын хугацааг 10 жилээр авч нэг цаг тутамд оногдох элэгдлийн зардлыг тооцоход 1504,63 төгрөг гарч байна.

Үүнийг хоногоор, цаашлаад хүлээлгийн дундаж хугацаа 12 хоногоор тооцвол дараах байдалтай байна. Энэ зардлын тооцоонд жолоочийн цалин хөлс, амьжиргааны зардал, нийгмийн холбоотой бусад зардлыг оруулаагүй болно.

Хүснэгт 4. Хүлээлгээс нэмэгдэх зардлын тооцоо

Зардал	Нэг цаг /төг/	Нэг хоногт /төг/	Хүлээлгийн дундаж хугацаа буюу 12 хоногт /төг/
Нэмэгдэл зардал /жолоочийн цалин хөлс, амьжиргааны зардал, нийгмийн холбоотой бусад зардлыг тооцоогүй/	3026,03	54367,94	652415,26

Зардлын тэгшитгэл дараах байдалтай байна.

$$C_{\text{рейс}} = C_k \cdot S_k + C \cdot T_k$$

$C_{\text{рейс}}$ - Нэг рейсийн зардал

S_k - Тээвэрлэлтийн зай

C - Нэг цагийн өртөг

C_k - Нэг тонн км-ын өртөг

T_k - Хүлээлгийн хугацаа (цагаар)

Эндээс харахад тээвэрлэлтийг оновчтой төлөвлөн зохион байгуулснаар их хэмжээний зардлын хэмнэлт гарах боломжтой нь харагдаж байна.

4. Нүүрсний тээвэрлэлтэд шаардлагатай тээврийн хэрэгслийн тоог тодорхойлох нь

Судалгаагаар тээврийн хэрэгслийн ашиглалт 80 хувьтай гэж тогтоогдсон бөгөөд боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг харгалзан Тавантолгой Ухаа худгийн уурхайгаас Гашуун сухайт боомт чиглэлд 24.2 сая.тн нүүрсийг экспортлоход



МОНГОЛЫН ХУУЛЬ
ЭРХЭМЧИЙН
ТӨСӨМӨР

шаардагдах тээврийн хэрэгслийн тоог болон парк ашиглалтын коэффициентийг тооцоход дараах үр дүн гарч байна.



$$A = \frac{Q_{\Phi}(L_{re}\beta_e V_T t_{n-p})}{T_M \beta_e V_T \gamma_c};$$


- A - Шаардлагатай автомашины тоо
- Q_Φ- Тээх ачаа (тонноор)
- L_{re}- Ачаатай явах дундаж зай км
- β_e- Нэг явалт (рейс)-нд гүйлт ашиглах коэффициент
- V_T- Техникийн хурд км (цаг)
- t_{n-p}- Ачих буулгахад зогсох хугацаа (нэг явалтад)
- T_M- Автомашины маршрутад ажиллах хугацаа (цаг)
- q- Автомашины даац (суудал ашиглалт)
- γ_c- Даац ашиглах статик коэффициент

$$\alpha_{\beta} = \left(\frac{AD_3}{AD_H} \right)$$

α_β – Парк ашиглалтын коэффициент
 AD₃ – Үйлчилгээнд гарах тээврийн хэрэгслийн тоо
 AD_H – Дансанд байгаа тээврийн хэрэгслийн тоо

Тавантолгой-Гашуун сухайт БНХАУ-ын Ганц мод боомтын чиглэлд 2017 онд Эрдэнэс тавантолгой ХК нь 13,2 сая.тн, Энержи Ресурс ХХК 8 сая.тн, Орон нутгийн Тавантолгой 3 сая.тн нүүрс нийт 24,2 сая.тн нүүрсийг 4590 хүнд даацын тээврийн хэрэгслээр экспортлох тооцоо гарч байна. Энэ төлөвлөлтийг уурхай тус бүрээр нь авч үзвэл:

Схем 1. Нүүрс экспортын тээвэрт шаардагдах тээврийн хэрэгслийн тоог парк ашиглалтын коэффициентээр тооцсон загвар





МУОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
 ХАТГАХ АШИГЛАЛТЫН
 ДУНДАЖ ХУРДЫГ
 ХҮЛЭЭЛЭГ ҮҮСЭХГҮЙ

/Тавантолгойд олборлолт хийж байгаа гурван уурхайн өдөрт, сард болон жилд экспортлох нүүрсний хэмжээг тооцохдоо Монгол улсаас БНХАУ-ын Эрэн хотод суугаа Консулын газрын мэдээлснээр Монгол, Хятадын хилийн боомт тэдгээрийн тухай Монгол улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 2018 онд тохиох хоёр улсын тэмдэглэлт баярын өдрүүдийг хасаж тооцсон болно./

Энэхүү төлөвлөлтийн хүрээнд хоногт уурхайгаас ачилт хийх тээврийн хэрэгслийн тоо болон хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог гаргахдаа шалган нэвтрүүлэх постуудаар дайран өнгөрөх хугацаа, Гашуун сухайт хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг тооцон ашиглалтын дундаж хурдыг хүлээлэг үүсэхгүй үеийнхээр буюу 30км/цаг байхаар авч тооцсон болно.

Хүснэгт 5. Тавантолгой-Гашуун сухайт-БНХАУ-ын хүртэлх нүүрс экспортын тээврийн хугацааг, техникийн ашиглалтыг тооцсон график

№	Хугацаа /цаг/мин/	Хугацаа /ашиглалтын хурд ачаатай 30км/цаг									
	Туулах зай /км/	60 мин	36 мин	50 мин	Хоолны цаг буюу түр амрах хугацаа 60 мин	3 цаг 54 мин	8 мин	30 мин	3 мин	5 мин	8 цаг 10 мин
ТЭЭВРИЙН ТӨЛӨВЛӨЛТ											
1	Уурхайгаас	2 км									
2	I-р пост хүртэл		24 км								
3	II-р пост хүртэл			33 км							
4	III-р пост хүртэл				156 км						
5	IV-р пост хүртэл /Цагаан хад/						5 км				
7	Гашуун сухайт боомт							20 км			
8	Хилийн боомтоор гарах /шалган/								3 км		
Нийт километр											243 км

Уурхайд ачилт хийлгэх, жин тонноо хэмжүүлэх, хучлага хийлгэх болон гаалийн бүрдүүлэлт хийж уурхайгаас замд гарах хугацаа нь 60 мин, Гашуун сухайтын замд дөрвөн шалган нэвтрүүлэх цэг байдаг бөгөөд тэдгээрийн хоорондох км зай, зарцуулах хугацаа болон техникийг ашиглалтыг тооцон үзвэл: Уурхайгаас шалган нэвтрүүлэх I пост хүртэл 24 км замыг 36 мин, I постоос II пост хүртэлх 33 км замыг 50 минутад туулна. II постоос III пост хүртэлх 156 км замд жолооч нэг цаг амрагч хооллох ба тус замыг 3 цаг 54 минут явна. III постоос IV пост хүртэл 5 км ба энэ хоёр постын дундаас Цагаан хадны буюу богинын тээвэр орж ирдэг.

$$V_3 = \frac{L_{\text{обш}}}{T_H} \text{ км/цаг}$$

V_3 = Ашиглалтын дундаж хурд

$L_{\text{обш}}$ = Автомашинь ачаатай явалт (км)

T_H = Автомашинь замд ажиллах хугацаа (цаг)

Уурхайгаас хоногт ачилт хийж, буулгах үеийн хугацааг тооцсон графикийн дагуу улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг тээвэрлэлт гүйцэтгэх хуваарьт оруулсан бөгөөд энэхүү гар ажиллагааг хөнгөвчлөхийн тулд “Тээвэр төлөвлөлтийн программ”-ыг нэвтрүүлсэн. Тус программаар Тавантолгой Ухаа худгийн уурхайгаас дараах маршрутаар тээвэрлэлт гүйцэтгэдэг тээврийн хэрэгслийн зохион байгуулалтыг төлөвлөхийг зорьсон.


Хүснэгт 6. Тээвэрлэлтийн зай


№	Маршрут	Зай /км/
1	Тавантолгой –Гашуун сухайт – БНХАУ-ын Ганц мод боомтын чиглэлийн тээвэрлэлт	239
2	Тавантолгой – Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн чиглэлийн тээвэрлэлт	216
3	Цагаан хад – Гашуун сухайт, БНХАУ-ын Ганц мод боомтын чиглэлийн тээвэрлэлт	23

Хоногт уурхайгаас ачилт хийх болон хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог ААНБ-аар хуваарьт оруулсан схемийн дагуу өдөр бүр тээвэрлэгчидтэй холбогдон ажиллах нь цаг хугацаа болон ажлын бүтээмжийг сайжруулахад хүндрэл бэрхшээлтэй учраас тээвэр төлөвлөлтийн программыг нэвтрүүлсэн.

Ингэснээр уурхай, зам болон тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд тус программд нэвтэрч ачаа тээврийн төлөвлөлтийн шийдлийг боловсруулж, программ хангамж өгөгдлийн сангийн зөв зохион байгуулалт, бусад мэдээ мэдээлэл цуглуулах, мөн тоног төхөөрөмжүүдтэй уялдан ажиллах системийг үүсгэх, тээврийн урсгалыг зөв зохион байгуулах, бүртгэл статистикийг нарийвчлан гаргах боломж бүрдэх нөхцөл бүрдсэн.

Уг программыг ашигласнаар хоногт уурхайгаас ачилт хийх болон хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог ААНБ-аар хуваарьт оруулах ажлыг графикийн дагуу мөрдөж ажиллахад хялбар, хүний оролцоо багасаж төлөвлөлт, хяналт зэрэг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхээрээ давуу талтай юм.





Зураг 1. Өдөрт уурхайгаас ачилт хийх болон хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог ААНБ-аар хуваарьт оруулсан тээвэр төлөвлөлтийн программ

Гэвч энэхүү программд дараах дутагдалтай талууд байна. Тухайлбал:

1. Нэгэн зэрэг олон хэрэглэгч хандахад ачаалал нэмэгдэж, систем удаашран цаг цаг хугацаа алдах асуудал үүссэн;
2. Програмын функцийг хувьд хайлт болон өгөгдөл хэсгүүдэд гар ажиллагаа ихээр шаардсан хэсэг олон;
3. Бусад боловсронгуй болсон төлөвлөлтийн программын загварыг ашиглах;

Дээрх программ хангамжийг шинэчлэн сайжруулж, олборлогч, тээвэрлэгч ААНБ-ын эрэлтэд нийцсэн орчин үеийн өндөр хурд, боловсронгуй болсон программ хангамжийг нэвтрүүлэх зорилгоор "Transportation Management System" Тээвэр төлөвлөлтийн программыг 2018 оны III улиралд туршилтаар нэвтрүүлсэн.

"Тээврийн нэгдсэн систем" тээвэр төлөвлөлтийн программын үндсэн функцийг хувьд Монгол улс болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн тухай хэлэлцээрийн дагуу хоёр улсын автозамын хилийн боомтуудаар нэвтрэх зөвшөөрлийн бичгийн олголт, зарцуулалт, Тээвэрлэлтийн гэрээ, ААНБ-ын бүртгэл, тээврийн хэрэгсэл, жолооч нарын тоо болон тээвэрлэлтийн статистик мэдээллийн сан агуулагдах үндэсний хэмжээний программ болох юм.

"Тээврийн нэгдсэн систем" Тээвэр төлөвлөлтийн программ ашиглалтад орсноор өмнө нь хийгдсэн программ хангамжид гарсан хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэж чадсанаараа онцлог юм.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН
АВТОТЭЭВРИЙН
ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН
ДАГУУ



Дүгнэлт

1. Нүүрсний экспортын тээвэрлэлт нь манай улсын эдийн засгийн хувьд өгөөжтэй боловч зөв зохистой төлөвлөлт, оновчтой зохион байгуулалтгүйгээс тээвэрлэлтийн гүйцэтгэлд цаг хугацаа, зардлын асуудал хөндөгдөхөөс гадна тэнд ажиллагчдын эрүүл мэнд, нийгмийн зэрэг олон асуудал тулгамдаад байна.

2. Тавантолгой - Ганц мод боомтын чиглэлд нүүрс экспортлох тээврийн нэг рейсийг гүйцэтгэхэд ачаатай талдаа 8 цаг 10 минут шаардлагатай байгаа боловч бодит байдалд 10-12 хоногийн хүлээлттэй байна. Хүлээлгийн улмаас зөвхөн тээврийн хэрэгслийн ашиглалтын зардалд нэг тээврийн хэрэгсэл дунджаар цаг тутамд 3026,0 төгрөг, хоногт 54367,9 төгрөг, хүлээлгийн дундаж хугацаанд 652415,2 төгрөг илүү зарцуулж байгаа нь тээвэрлэлтийн төлөвлөлт, зохион байгуулалт төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, тээвэрлэлтийн төлөвлөлт, зохион байгуулалт муу байгааг харуулж байна.

3. Хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн дарааллын улмаас гарах зардлыг тооцоолон бодитоор загварчилсан тул аж ахуйн нэгж, байгууллагууд уг загварыг ашиглан нэгж хугацаанд гарах нэмэлт зардлыг шууд хянах боломжтой юм.

Санал

1. Хил дамнасан уртын тээвэрлэлтэд ажиллах тээврийн хэрэгслийн оновчтой тоог тодорхойлон аж ахуйн нэгжүүдэд квотоор хуваарилах ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

2. Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилго болон боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг тооцож тээврийн төлөвлөлтийг хийх шаардлагатай байна.

3. Тээвэрлэлтийг үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахын тулд олборлогч, тээвэрлэгч, зам эзэмшигч, хил гаалийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, хяналтын тогтолцоог бүрдүүлж нэгдсэн удирдлагаар хангах нь энэ тэргүүний асуудал юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Зам, тээврийн сайдын 2013 оны "Автотээврийн тариф тооцох зөвлөмж".
2. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам".
3. Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал "Жишиг норм батлах тухай".
4. Автотээврийн салбарын тарифын хэлэлцээр. 2012.
5. Д.Ёндонсүрэн. "Автотээврийн хэрэгслийн ашиглалтын норм". 2004.
6. Автотээврийн үндэсний төвийн статистик мэдээлэл.
7. Гашуун сүхайт боомтын гаалийн статистик мэдээлэл.